

# MONGOLIAN ECONOMY

2015 оны 07 сар. № 15 (094)  
[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

## УУЛУУРХАЙ

Б.Намхайнямбуу: "Эрдэнэт" үйлдвэр олон жил том динозавр байж ирсэн


## БИЗНЕС

Бизнес эрхлэгчид нэгнийдээ зочилж эхэллээ

## НИЙГЭМ

Эдийн засагжаагүй салбар

# Х□гжил хаанаас ЭХЭЛДЭГ ВЭ





Бизнес стартапын  
**туршлага**



Хууль эрх зүйн  
**зөвлөгөө**



Хөрөнгө санхүүгийн  
**туслалцаа**



Санхүүгийн иж бүрэн  
**үйлчилгээ**



Маркетингийн  
**шийдэл**



Ня-бо бүртгэлийн  
**дэмжлэг**

Ажлын байрны түрээс

**₮ 300К + нөат**

Дээрхээс гадна ширээ, сандал, уулзалт, сургалтын тасалгаа, интернет, дулаан, цахилгаан, ус, харуул хамгаалалт энэ үнэд багтаж байна.

**Хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Амарын гудамж Өнгөт хэвлэл компанийн байр, 2-р давхар




## DELL POWEREDGE VRTX IT ДЭД БҮТЦИЙН ТӨГС ШИЙДЭЛ

Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд болон томоохон байгууллагын салбарууд өөрсдийн хэрэгцээний сервер, сторейжуудаа байрлуулахад сүлжээний свич, зогсуур (rack), кондишнерээс эхлээд тусдаа жижиг өрөө хүртэл хэрэг болдог. Энэ сервер, свич нь сүүлдээ сүлжээний болон цахилгааны кабель орооцолдсон замбараагүй зүйл болж хувирдаг.

Мэдээллийн технологийн салбарт дэлхийд тэргүүлэгч DELL компани дээрх асуудлуудыг шийдэхэд зориулж сервер, сторейж, свич зэргийг нэгтгэсэн All-in One server буюу PowerEdge VRTX server-ээ зах зээлд гаргалаа.

Dell PowerEdge VRTX server нь 48 x 31 x 73 см хэмжээтэй 1 chassis дотор 4 хүртэлх сервер, 48TB хүртэлх хэмжээтэй хард дискүүд, 1Gbps 8 порт свичийг багтаасан нь хамгийн шинэлэг, шилдэг шийдэл болж чадсан юм.

Оффисийн өрөөний температурт хэвийн ажиллах Fresh Air технологитой  
Оффисийн өрөөнд ил байрлуулахад дуу чимээ нь сонсогдохгүй  
Газарзүйн хувьд алслагдсан бүсүүдэд ажиллаж байгаа олон VRTX серверүүдийг төвлөрсөн нэг цэгээс хянах, тохиргоо хийх зэргээр удирдах бүрэн боломжтой.



**БҮГД  
НЭГ ДОР**



НЭГ ДУГААР 15,000₮  
УЛИРАЛ /6 ДУГААР/ 90,000₮  
ХАГАС ЖИЛ /12 ДУГААР/ 180,000₮  
ЖИЛ /24 ДУГААР/ 360,000₮

180,000₮

Үүсгэн байгуулагч, Эрхлэгч:

Д.БЭХБАЯР / 9999-4248

Үүсгэн байгуулагч, Орлогч эрхлэгч:

И.ОТГОНЖАРГАЛ / 8800-6228

Сэтгүүлийн редактор:

Б.ҮҮРИЙНТУЯА

Англи хэлний редактор:

О.ТҮВШИН

Вэб редактор:

Б.ЭНХЦЭЦЭГ

Сэтгүүлчид:

А.БҮРЭНЖАРГАЛ

Г.ОРХОН

Ц.ЭЛБЭГСАЙХАН

Дизайнер:

С.ЭРДЭНЭЦОГ

Маркетингийн менежер:

Д.БАРИАНЖАВ / 9409 2904

Ч.ҮҮРИЙНТУЯА / 9409 2905

ХАЯГ

Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг.

I хороо, Энхтайвны өргөн чөлөө.

Экспресс тауэр. 1101 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан,

ш/ х-2762

WWW.MONGOLIANECONOMY.MN

INFO@MONGOLIANECONOMY.MN

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

“Улаанбаатар Принт” ХХК-д хэвлэв

WWW.UVPRINT.MN

Борлуулах цэгүүд:

“Интер ном”

“Цэцэг төв”

“Минж плаза”

“Алтантулхуур” номын дэлгүүр

“Номин” супермаркетин бүх салбар

“Макс” супермаркетин бүх салбар

“Фреско” супермаркет

ВТS1 супермаркет

“Аз орчлон” номын дэлгүүр

“Билэг” их дэлгүүрийн номын тасаг

“Гранд Плаза” дахь супермаркет

“Мир” номын дэлгүүрийн


“GRAND PLAZA”

“METRO MALL”

“Sky” супермаркет

“Улаанбаатар” их дэлгүүр

“Мах mall” дэх салбарууд



### ГҮНЗГИЙ МЭД



УУЛ УУРХАЙ

10 САЛБАРЫН ТҮҮЧЭЭ

13 Б.НАМХАЙНЯМБУУ: "ЭРДЭНЭТ" ҮЙЛДВЭР ОЛОН ЖИЛ  
ТОМ ДИНОЗАВР БАЙЖ ИРСЭН

16 ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД НҮҮРСНИЙ ХЭРЭГЛЭЭГЭЭ  
ХЯЗГААРЛАЖ ЭХЭЛЛЭЭ

БИЗНЕС

18 БИЗНЕС ЭРХЛЭГЧИД НЭГНИЙДЭЭ ЗОЧИЛЖ ЭХЭЛЛЭЭ

НИЙГЭМ

18 Ц.ЭНХЦЭНГЭЛ: ХӨГЖЛИЙН ХУВЬД ИРГЭД БОЛОВСРОЛ,  
СОЁЛ,ЭРҮҮЛМЭНД,НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ ӨНДӨР  
ТҮВШИНД ХҮРЭХ ЁСТОЙ

25 АМАР ТАЙВНЫГ САХИГЧИД

28 Ч.БОЛДБААТАР: ЦАГДААГИЙН АЖЛЫГ ИРГЭД САЙНААР  
ҮНЭЛДЭГ БОЛЖ

29 ШИЙДЭЛ

31 Ш.ЭНХБАТ: ЭРҮҮЛМЭНДИЙН САЛБАР ҮРГЭЛЖ  
ҮЛДЭГДЭЛХЭЛБЭРЭЭР САНХҮҮЖИЖ ИРЛЭЭ

32 Г.БАДАМЦЭЦЭГ: ХОРХОГ,БООДОГ ИДЧИХЭЭД АРХИ  
УУВАЛУХЭЛД ХҮРГЭХ АЮУЛТАЙ

34 ИРГЭДИЙН ИДЭВХЭЭР ХӨГЖИХ СПОРТЫН САЛБАР

35 Ж.ГАНБОЛД: ЭРҮҮЛАЖ ТӨРӨХ ОРЧНЫГ БҮРДҮҮЛНЭ

36 ЭДИЙН ЗАСАГЖААГҮЙ САЛБАР

38 ВЕНИЙН ҮДЭШ

39 ДАЙРДАГ, ЗОРЬДОГ, АЯЛДАГ ХОТ

40 ЖУУЛЧДЫН ТӨЛСӨН ТАТВАРААР ДАРААГИЙН  
ТӨСЛҮҮДИЙГ САНХҮҮЖҮҮЛНЭ

42 УЛСЫН ИРЭЭДҮЙ ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД

43 Ц.ОТГОНБАГАНА: МОНГОЛУЛСЫН ИРЭЭДҮЙГ  
БОЛОВСРОЛТОЙ ХҮН АВЧ ЯВНА



Энэ 2015 он дэлхийн уур амьсгалыг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг шинэ шатанд гаргахад онцгой ач холбогдолтой жил болж байна. Учир нь сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар явагдсан яриа хэлэлцээний үр дүнд энэ асуудлаар улс орнуудын хүлээх үүрэг хариуцлагыг олон улсын хэмжээнд хуульчлан тогтоосон шинэ Протоколыг хэлэлцэж батлах НҮБ-ын дээд хэмжээний бага хурал Парис хотноо энэ оны 11 сарын сүүлчээр хуралдана.




Тэрбээр өнөөдөр 15:00 цагаас албандаа гарах хуваарьтай. Гэхдээ өнөөдрийн хувьд өдөр тутам гүйцэтгэдэггүй чухал үүрэгт ажилд томилогдсон нь энэ.




Олон улсын зэрэглэлийн ганц онгоцны буудал, төмөр замын босоо нэг шугамтай Монголд жуулчид аялахын тулд хүслээрээ бус "хүчээр" Улаанбаатарт эхлээд ирдэг. Нийслэлээр аяллаа эхэлж бас дуусгадаг атлаа жуулчид эргээд харихдаа Монголын нүүдэлчин соёл заншил, хөдөө нутгийг онцолдогоос нийслэл хотыг биширч ярьдаг нь юу л бол.


ТА ӨӨРИЙН ГЭР БҮЛ,  
ҮР ХҮҮХЭД, ӨМЧ ХӨРӨНГӨ,  
БИЗНЕСИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД  
**САНАА ЗОВИНОДОГ УУ?**

ТЭГВЭЛ ОРОН ЗАЙ ЦАГ ХУГАЦААГ ҮЛ ХАМААРАН БҮХНИЙГ ХЯНАХ  
БОЛОМЖИЙГ “ДУВАСОХОР НД” КЛОУД КАМЕР ТАНЬД ОЛГОЖ БАЙНА



**HD 720p** Дуу болон Дүрсийг HD чанартайгаар дамжуулна

 Камерны чанга яригчийг ашиглан харилцан ярилцах боломжтой

 Univision, Skymedia болон бусад бүх төрлийн интернэт түгээгчийн WiFi төхөөрөмжтэй шууд зохицон ажиллана



WiFi болон 3G холболттой бүх төрлийн төхөөрөмжөөс хянах боломжтой



7-30 хоногийн бичлэг хадгалах клоуд үйлчилгээг камер тус бүрт сонгон хэрэглэнэ



Таны эзгүйд хөдөлгөөн илэрсэн тохиолдолд гар утас руу тань анхааруулах мессеж зургийн хамтаар илгээнэ



Та нэмж бичлэгийн төхөөрөмж, хард диск, хяналтын компьютер, статик IP хаяг зэргийг худалдан авах шаардлагагүй ба мэргэжлийн угсралт суурилуулалт, техникийн үйлчилгээ, хөглөрсөн утас кабельгүйгээр хүссэн газраа суурилуулан мөн зөөж ашиглах боломжтой

“ДУВА СОХОР НД” КЛОУД КАМЕР: **250 000₮**

MONGOLIAN ECONOMY СЭТГҮҮЛИЙН УНШИГЧДАД ТУСГАЙ БЭЛЭГ

**LIVE UB.MN**  
Cloud video surveillance

Вэб: [www.liveub.mn](http://www.liveub.mn)  
Facebook: [www.facebook.com/www.liveub.mn](http://www.facebook.com/www.liveub.mn)  
Утас: 94242564  
И-мэйл: [info@liveub.mn](mailto:info@liveub.mn)

**50 000₮**



**USAID**  
АМЕРИКИЙН АРД ТҮМНЭЭС



**QSDC**  
БИД ТАНЫ БИЗНЕСИЙН АМЖИЛТАД  
ХӨРӨНГӨ ОРУУЛНА

**ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ХӨГЖИЛ ЧАНАРЫН ТӨВ**

## **“6 СИГМА НОГООН БҮС” СУРГАЛТ**

“Ханган нийлүүлэгчдийн хөгжил, чанарын төв” (ХНХЧТ) нь Вагнер Ази Тоног Төхөөрөмж ХХК-тай хамтран “6 Сигма Ногоон бүс” ээлжит сургалтаа зохион байгуулах гэж байна.

“6 Сигма” нь мэдээлэл, тоо баримт дээр тулгуурлан бүхий л төрлийн үйлдвэрлэл, үйлчилгээний үйл явцад гарах гологдол/доголдлыг бууруулах зорилготой аргачлал бөгөөд тус аргачлалыг Fortune сэтгүүлийн ТОП 500-д багтдаг Женерал Электрик, Моторола зэрэг томоохон компаниуд үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ашигладаг. Сургалтыг “6 Сигма Хар бүс”-т сургагч багш нар удирдах бөгөөд энэхүү аргачлалаар ямарваа байгууллагын үйл ажиллагааны явц, процессийн чанарыг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх 6 Сигма аргачлалын зарчим, практик болон арга техникийг зааж сургана.

**Сургалт явагдах өдөр : 2015 оны 8-р сарын 11-13**

**Сургалтын төлбөр: 450,000₮**

14 хоногийн өмнө төлбөр төлсөн тохиолдолд 20% хөнгөлөлттэй  
Нэг байгууллагаас 3-7 хүн оролцох тохиолдолд 20% хөнгөлөлттэй  
Нэг байгууллагаас 8 ба түүнээс дээш хүн оролцох тохиолдолд 50% хөнгөлөлттэй

**Холбогдох хаяг:**

**Утас: 11-321375 (123), 8949-2828;**

**Имэйл: [dolgorsuren@qsdc.mn](mailto:dolgorsuren@qsdc.mn)**



**6 СИГМА  
НОГООН  
БҮС**

## ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ



Дэлхийн зах зээл дээрх алтны үнэ энэ оны тавдугаар сарын 29-ний байдлаар унци тутамд 1.190.6 ам.долларт хүрснээр өнгөрсөн оны мөн үеэс 4.7 хувиар буурч, өмнөх сараас 0.5 хувиар өслөө. Түүнчлэн А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн үнэ 60 ам.долларт хүрч өнгөрсөн сарын мөн үеэс зэсийн үнэ 5.6 хувиар буурч, төмрийн хүдрийн үнэ 1.7 хувиар өсчээ. Харин өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал зэс 13.2 хувиар, төмрийн хүдэр 34.6 хувиар буурсан байна. Түргэн эдэлгээтэй бүтээгдэхүүний импорт буурахад хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа элсэн чихэр, какао, шоколад, согтууруулах болон согтууруулах биш ундаа, сүү, сүүн бүтээгдэхүүний импортын бууралт голлон нөлөөлсөн байна. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт буурахад машин, механизм, тоног төхөөрөмж, түүхий эд анги 48 хувиар буюу 251 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Түүнчлэн барилгын материалын импорт 80 сая ам.доллараар буурсан байна.

### ҮЙЛДВЭРЛЭЛ

2020 он гэхэд бетоны хэрэгцээ



1.5-2.5 дахин өсч, 5.9-9.6 сая шоо метр хүрэх боломж бүрдсэн талаар салбарынхан хэллээ. 2030 он гэхэд Монгол Улсын нийт хүн амын 60 хувийг орчин үеийн тохилог орон сууцаар хангах зорилтыг Засгийн газраас дэвшүүлээд байгаа юм. Энэ нь орон

сууцны нийлүүлэлт, дэд бүтцийн төслүүд, нийгмийн зориулалттай барилгын эрэлттэй нийцэж буй аж. Монгол Улсад бетон зуурмаг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй 108 аж ахуйн нэгж байгаагаас Улаанбаатар хотод 72 компани идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Гэхдээ ихэнх үйлдвэр барилгын компаниудын дэргэд байгуулагдаж, зах зээлд бүтээгдэхүүнээ шууд нийлүүлдэггүй аж. 2013 оны байдлаар үйлдвэрлэсэн бетон зуурмагийн хэмжээгээр "Premium concrete" тэргүүлж байсан бол үүний араас Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Ремикон" ХК удаалж байсан. Мөн өнгөрсөн онд "Мерекс" ХК цагт 150 шоо метр бетон үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрийн төсөл хэрэгжүүлэхээр анх удаа олон нийтэд үнэт цаас санал болгосны дараа хоёрдогч зах зээлд хувьцаагаа арилжаалж байна. Энэ сард "МАК" компани 155 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар евро стандартын шинэ үйлдвэр ашиглалтад орууллаа. Энэхүү үйлдвэр нь Монгол Улсын бетоны жилийн хэрэглээний гуравны нэгийг дангаараа хангах буюу 270 мянган шоо метр бетон үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Евро стандартаар байгуулсан үйлдвэр нь бүрэн автомат ажиллагаатай гэдгээрээ онцлог юм байна.

### ЭРЧИМ ХҮЧ



Монгол Улс өнгөрсөн тавдугаар сард 405.3 сая кВт цаг цахилгаан хэрэглэснээс 94.4 хувийг дотоодын цахилгаан станцууд үйлдвэрлэж, импортоор 22.5 сая кВт цаг цахилгаан худалдан авсан талаар Эрчим хүчний яамнаас мэдээллээ. Тус хугацаанд эрчим хүчний системийн хувьд хэрэглээ төлөвлөснөөс харьцангуй бага байсан аж. Дотоодын эрчим хүч үйлдвэрлэлийн 68.8 хувийг дулааны IV цахилгаан станц дангаараа бүрдүүлсэн бол Салхитын салхин

цахилгаан станцын боловсруулалт 4.1 хувийг бүрдүүлээ. Түүнчлэн эрчим хүчний эх үүсвэр барихтай холбоотой тусгай зөвшөөрлийг салбарын нэгдсэн бодлогоор зангидах хэрэгтэйг салбарынхан хэлж байна. Үүнээс гадна барилгын ажил эхэлсэнтэй холбоотойгоор хувийн өмчлөлийн шугам, дэд станцын харилцааг хууль тогтоомжоор зохицуулаагүйн улмаас хэрэглэгчид эрчим хүчид холбогдох боломж хязгаарлагдаж байгаа нь хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл болж буйг салбарын сайд хэллээ.

### УРАН ОЛБОРЛОХ ЭРХ ОЛГОЛОО



Уран олборлуулахгүй гэх тэмцэл тууштай үргэлжилсний дүнд Засгийн газар ураны зөвшөөрлийг гадна, дотны ямар ч компанид өгөөгүй байсан. Харин өнгөрсөн сарын 19-ний ээлжит бус хуралдаанаар "Мон-Атом" төрийн өмчит компани, Бүгд найрамдах Чех улсын "Ураниум индастри" ХК-тай хамтран "Мон-Чех Ураниум" компани байгуулах шийдвэр гаргажээ. Гэрээ ёсоор хамтарсан компанийн 51 хувийг Монголын тал эзэмших юм байна. Дээрх компаниуд цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуулын салбарт хамтран ажиллах аж. Түүнчлэн Францын хөрөнгө оруулалттай "Кожеговь" компанид уран олборлох эрхийг олгожээ. Тус компани Дорноговь аймгийн Улаанбадрах суманд орших Дулаан-Уул, Зөвч овоогийн ордод цацраг идэвхт ашигт малтмал ашиглах ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан байна. Цөмийн энергийн газар татан буугдсанаар дээрх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Ашигт малтмалын газар хүлээн авч шийдвэрлэсэн аж. Ингэснээр Монголын "Мон-Атом", Францын "Арева", Японы "Мицубиши" зэрэг компанийн оролцоо бүхий "Арева Майнс" хамтарсан компани байгуулж ашиглалтын үйл ажиллагаа явуулах бэлтгэл эхэлж буй талаар Уул уурхайн сайд Р.Жигжид хэллээ. ■

## ДЭЛХИЙД

## ГРЕК



Өнгөрсөн сард "Google"-ийн хайлтын системээр хамгийн их хайсан үг "Grexit" буюу Грек гарах гэсэн үг байлаа. Грек Европын холбооноос гарах асуудлыг удаан хугацааны турш яриж байгаа ч тодорхой биш шийд гараагүй. Дампуурлаас зайлсхийхийн тулд олон улсын зээлдэгчид зээлийн эргэн төлөх хугацааг зургаан сараар сунгаж 18 тэрбум еврогийн санхүүжилт санал болгож буй.

Тэд Ерөнхийлөгч Ципрас болон түүний намыг шинэчилсэн санхүүгийн зорилт, тэтгэвэр хасалт болон татварын нэмэлтийг өргөн барихыг хүлээж байна. Хадгаламж эзэмшигчид олон тэрбум еврог Грекийн банкуудаас эргүүлэн татсаар байгаа юм. Грекийн ОУВС-д төлөх 1.5 тэрбум еврогийн эргэн төлөлтийн эцсийн хугацаа энэ долоо хоногт дууссан бөгөөд Грекийн банкууд хадгаламж эзэмшигчдийг дахин мөнгө татахаас сэргийлэх үүднээс өнгөрсөн долоо хоногт ажилсангүй. Өнгөрсөн зургаадугаар сарын 30-нд буюу Мягмар гаригт Грек улс зээлээ эргүүлэн төлж чадаагүй Европын холбооны анхны улс боллоо.



## ОХУ ба ХОРИГ

Европын холбоо ОХУ-ын Украинд явуулж буй бодлогыг эсрэг хориг арга хэмжээ тавьж, үүний эсрэг ОХУ ч хориг арга хэмжээ авсан билээ. Улмаар хоёр сая ажлын байр үгүй болох мөн Европ 100 тэрбум еврогийн алдагдал хүлээх магадлалтай байгааг Германы өдөр тутмын "Die Welt" сонин мэдээлжээ.

Сонины мэдээлснээр экспортын уналт ЕХ-ны эдийн засагт хүчтэй мэдрэгдэж байна гэв. Герман улс 500 мянган ажлын байраа алдаж, эдийн засаг нь 27 тэрбум еврогийн алдагдал хүлээж ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлт нь нэг хувиар буурах төлөвтэй байна. Харин Итали улсын хувьд 200 мянган ажлын байр болон ДНБ-ий 0.9 хувь, Франц улс 150 мянган ажлын байр болон ДНБ-ий 0.5 хувийг алдах эрсдэлд орж байна.

Мөн тус сонин Европын комиссыг дээрх барумтыг олон нийт болон ОХУ-д мэдэгдэхгүйн тулд дэлгээгүй гэж буруутгажээ. Кремлийн баримталж буй хориг арга хэмжээ нь Москвагийн эсрэг хориг тавьсан улсуудаас нэг жилийн туршид хүнс болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн импортлохгүй байхаар тусгасан юм.

## ЛЮФТХАНЗАГИЙН БЭРХШЭЭЛ

"Люфтханза" групп, тус компанийн бүхээгийн багийн гишүүдийн холбоо хооронд тэтгэврийн системийн асуудлаар маргаан үүсч ажил хаялт зарлах магадлалтай байна. Үүний улмаас Люфтханзагийн зуны нислэгүүд цуцлагдаж болзошгүй байна. Тус холбоо нь "Люфтханза" группын 13 мянга гаруй бүхээгийн багийн гишүүнийг төлөөлдөг юм. Люфтханза 2014 оны ажил хаялтын улмаас ойролцоогоор 232 сая еврогийн алдагдал хүлээж. Агаарын хөлгийн үйлчлэгчид 55 насандаа тэтгэвэрт гарч 65 нас хүртэл буюу нийгмийн даатгалд хамрагдах хүртлээ цалингийн 60 хувийг авдаг. Харин "Люфтханза" компани хөрөнгийн зах зээлд хүүгийн хэмжээ бага болсон учраас цалингийн 60 хувийг олгох боломжгүй болсон гэж мэдэгдсэн нь асуудал үүсгэжээ.



## БНХАУ-ЫН БАНК БОЛОН ИТАЛИ

"Associated Press" агентлагийн зургаадугаар сард илрүүлсэн мөнгө угаасан хэргийн улмаас Италийн прокурорууд 297 хуулийн этгээд болон


БНХАУ-ын банкыг яллахаар болсон байна. Сэжигтнүүдийн дийлэнх нь Хятадын цагаачид бөгөөд үнд БНХАУ-ын банкны Милан дахь салбарын дөрвөн ахлах менежер багтаж байгаа юм. Прокуроруудын хэлж буйгаар 2007-2010 оны хооронд дөрвөн жилийн хугацаанд хуурамч бараа, биеэ үнэлэлт, хөдөлмөрийн мөлжлөг болон татвараас зайлсхийх аргаар олсон 4.5 тэрбум еврог Хятад улс руу шилжүүлсэн гэжээ. Уг мөнгөн дүнгийн бараг тал хувь БНХАУ-ын банкаар дамжсан бөгөөд тус банк шимтгэлээр 758 мянган еврогийн ашиг олсон байна.

Италийн албаныхан хэлэхдээ Бээжин өөрийн санхүүгийн хэрэгтнүүдийг олохын тулд барууны хууль сахиулах байгууллагатай хамтарч ажилладаг хэдий ч энэ хэрэгт хамтран ажиллаагүй гэв. Хятадын төрийн өмчит "Global Times" сонин "Associated Press"-ийн мэдээг няцааж буй. БНХАУ-ын эрх баригч Коммунист нам авлигатай тэмцэх асуудлыг гол зорилго гэж үзэж буй бөгөөд ойролцоогоор 100 мянга гаруй албан тушаалтныг авлигын хэргээр шийтгээд байгаа юм.

## АНУ-ЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС ӨСЛӨӨ

Өнгөрсөн тавдугаар сард АНУ-ын хэрэглээний үнийн индекс 0.4 хувь өсч 2013 оны хоёрдугаар сараас хойш үзүүлсэн хамгийн өндөр өсөлт боллоо. Тус индексийн өсөлтөд шатахууны үнэ тавдугаар сард 10.4 хувиар өссөн нь том нөлөө үзүүлжээ. Уг үзүүлэлт 2014 оны тавдугаар сараас хойш бараг өөрчлөлтгүй байсан бөгөөд ажилгүйдлийн тэтгэмж сүүлийн 15 жилийн хамгийн доод түвшинд хүрсэн юм. Филадельфиягийн Холбооны нөөцийн банк мэдэгдэхдээ бүс нутаг дахь үйлдвэрийн үйл ажиллагаа нэмэгдсэн нь уг өсөлтөд нөлөөлсөн гэв. Үйлдвэрлэгчид бүтээгдэхүүний материалыг илүү өндөр үнээр авч байгаа нь барааныхаа үнийг нэмэхэд хүргэж байгаа бөгөөд үүний улмаас ирэх саруудад инфляцийн түвшин нэмэгдэх таамаг байна.

АНУ-ын банкны байгууллагууд, түүнчлэн Засгийн газрын байгууллагуудын мэдээлж буйгаар АНУ-ын эдийн засаг ирэх саруудад эерэг байх хандлагатай байгаа юм. ■



БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

“Эрдэнэт” үйлдвэрийн өөрөө нунтаглах хэсгийн өргөтгөл

## Салбарын түүчээ

А.Бүрэнжаргал

Их уурхайн хувь хүртэж хөгжлийн нэгэн цэгт ирээд буй Монгол Улсад түүхэнд үлдэх томоохон бүтээн байгуулалт нэгээр нэмэгдлээ. Энэ бол зэс, молибденийн хүдрийн олборлолт, баяжуулалтаар Азид томоохонд тооцогддог “Эрдэнэт” үйлдвэрийн өөрөө нунтаглах хэсгийн өргөтгөл. Баяжуулах фабрикийнхаа өөрөө нунтаглах хэсэгт өргөтгөл хийж өнгөрсөн сарын 20-нд нээлтээ хийсэн юм. Сүүлийн гурван жил үргэлжилж буй өргөтгөлийн ажилд үйлдвэрийн уурхайчид төдийгүй гэрээт 10 гаруй компани туслан гүйцэтгэгчээр ажилласан нь энэхүү бүтээн байгуулалтын цар хүрээг илтгэж буй.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Одоогоос 34 жилийн өмнө би “Эрдэнэт” үйлдвэрт ажилтнаар орж, ачигч машинч, засварчин хийж анхны цалингаа авч байлаа” хэмээн дурсан хэлсэн. “Эрдэнэт” үйлдвэр ашиглалтад орсноос хойш 37 дахь жил дээрээ шинэ бүтээн байгуулалтыг хийж буйд Монгол Улсын Ерөнхийлөгч ийн баяр хүргэн нээлтийн үйл ажиллагаанд оролцсон юм. Олон хүний оюун ухаан, хүч хөдөлмөр, техник, технологийн дэвшил шингэсэн өргөтгөлийн үйл ажиллагаа эхэлснээр үйлдвэр жилд 32 сая тонн хүдэр боловсруулж, төсвийн орлогыг 73 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх эдийн засгийн ач холбогдолтой. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр жилд 16 сая тонн зэс, молибденийн хүдэр боловсруулах хүчин чадалтайгаар анх

1978 онд ашиглалтад орж байсан. Үүнээс хойш өнөөг хүртэл үйлдвэрийнхээ техник технологийг шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг байнга авч хэрэгжүүлж ирсэн нь тус үйлдвэрийн улсад оруулж буй үр өгөөжөөр хэмжигдэнэ.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн ерөнхий захирал Ц.Даваацэрэн “Үйлдвэрийн өргөтгөл ашиглалтад орсноор компанийн хүдэр боловсруулах хүчин чадал жилд зургаан сая тонноор нэмэгдэж, үйлдвэр жилдээ 32 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай боллоо. ОХУ-ын хөрөнгө оруулалтаар Эрдэнэтийн ордыг ашиглалтад оруулсан нь Монгол Улсын нийгэм, эдийн засагт ихээхэн хувь нэмрээ оруулсан төдийгүй хөрөнгө оруулалтын хамгийн сайн жишээ болсноор бид бахархаж явдаг. Эдийн засгийн хүнд үед бид үйлдвэрийн өргөтгөлийг амжилттай ашиглалтад орууллаа. Цаашид бид үргэлжлүүлэн хөрөнгө оруулалт хийж, үйлдвэрийнхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин үеийн шинэ техник технологийг нэвтрүүлж, эдийн засгийн үр ашигтай ажиллана” гэдгийг хэлсэн юм.

Уурхайн олборлолт доошлох тусам уул геологийн нөхцөл хүндэрч, боловсруулж буй хүдэр дэх зэсийн агуулга буурч, баяжуулагдах чанар мууддаг байна. Үүнийг дагаад таваарын бүтээгдэхүүн гаргалт тогтмол унаж, борлуулалтын орлого буурах хандлагатай болдог аж. Тиймээс өнөөдрийн гаргаж

буй таваарын бүтээгдэхүүний тоо, хэмжээг (баяжмал дахь зэс ойролцоогоор 125000 тн/жил) одоогийн түвшинд хадгалах техникийн болон зохион байгуулалтын арга хэмжээг авах үүднээс өргөтгөл барих хэрэгцээ шаардлага үүссэн талаар Баяжуулах fabriкийн даргын зөвлөх, өөрөө нунтаглах хэсгийн өргөтгөл хариуцсан төслийн удирдагч Р.Дэлгэр хэлсэн юм. Түүнчлэн техник технологио сайжруулж металл авалтаа ихэсгэх, хүчин чадлаа нэмэгдүүлэн хүдэр боловсруулалтын хэмжээг өсгөх шаардлагатай тулгарсан байна. Иймээс гадаад, дотоодын ижил төстэй үйлдвэрүүдийн туршлага судалсны үр дүнд хүдэр боловсруулалтаа нэмэгдүүлэх, техник технологио сайжруулах боломжийг эрэлхийлсэн нь ийн биеллээ оллоо.

Тодруулбал, бутлан тээвэрлэх хэсгийн КСД, КМД маркийн бутлууруудаа сүүлийн үеийн өндөр хүчин чадалтай, сайжруулсан бутлуураар сольж, шигшүүрийн машинуудаа Австри улсын IFE фирмийн шигшүүрийн машинаар шинэчилжээ. Өөрөө нунтаглах хэсгийн өргөтгөл ашиглалтад орсноор дээрх шинэчлэлүүдийн үр дүн гарч үйлдвэрийн хүчин чадлыг 1.3 дахин нэмэх боломжтой бөгөөд нунтаглан баяжуулах хэсгийн флотпаркийн бүрэн шинэчлэл хийж 35 сая тонн хүдэр хүлээн авч баяжуулах нөхцөл бүрдэх аж.


“Эрдэнэт” үйлдвэр нь баяжуулах fabriкийн өөрөө нунтаглах хэсгийн өргөтгөлийн зөвхөн захиалагчийн үүрэг гүйцэтгээгүй. Үндсэн үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагааг явуулахын зэрэгцээ өргөтгөлийн ажилд өөрийн мэргэжилтнүүдийн хүч боломжийг дайчлан, ашиглалтад оруулж эдийн загсийн нөхцөл байдал сайнгүй энэ үед энэхүү бүтээн байгуулалтын ард гарсанд талархмаар.

Үйлдвэрийн өргөтгөлийн ажилд ОХУ-ын “РИВС”, БНХАУ-ын машин үйлдвэрлэлийн “Найпу”, “СІПІС”, үндэсний барилга үйлдвэрлэлийн “Тунамал-Үйлс”, “Улаанбаатар-БУК”, “ОТК” ХХК, “Вера сервис”, Орхон аймгийн “Бүтээл”, “Баяжуулагч одод”, “SASS”, ТӨСОМА”, “Техмонтаж” ХХК гээд олон үйлдвэр

хамтран ажиллажээ. Үндэсний барилга үйлдвэрлэлийн компанийн ажилчдын ур чадвар дээшилж, хандлага өөрчлөгдөн гаднынхнаас дутахааргүй болсон талаар төслийн ахлагч хэлэв. Өөрөө нунтаглах хэсгийн өргөтгөлд өндөр технологи, хүчин чадалтай БНХАУ-ын “СІПІС” фирмийн хагас өөрөө нунтаглах тээрэм SAG 9.75x4.88, бөмбөлөгт тээрэм МШЦ 6,71x9,75, “Найпу” фирмийн булинга шахах насосууд 550NZJA-MR, бүрэн автомат булинга ангилагч АГЦУ 838x7, ОХУ-ын хоцарт бутлуур ШДП 15x21, Австрали улсын “Metso” фирмийн конусан бутлуур HP400, Австри улсын “IFE” фирмийн шигшүүр, соронзон металл ялгач зэргийг нэвтрүүлсэн нь үйл ажиллагаа бүрэн автоматчилагдан дэлхийн түвшинд нийцэх тоног төхөөрөмжөөр хангагдсан гэдгийг салбарын мэргэжилтэн онцолж буй.

Хүдэр дэх металлын агуулга багассан, баяжуулагдах чанар муудсан энэ үед өөрөө нунтаглах хэсгийн өргөтгөл ажилласанаар таваарын бүтээгдэхүүний хэмжээг 20 гаруй хувиар нэмэгдүүлэх нөхцөл бүрдлээ. 2011 оноос хойш шат дараатай хийсэн төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 155.4 сая ам.доллар бөгөөд төслөөс гарах эдийн засгийн үр ашиг нь жилд 12 сая ам.доллар. Мөн нэг тонн зэсийн үнэ 6800 ам.доллар байвал нийт хөрөнгө оруулалтаа 5.7 жилийн дотор нөхөх урьдчилсан тооцоо гарчээ. Үйлдвэрийн хувьд өнгөрсөн оны гүйцэтгэлээр жилд 26.1 сая тн хүдэр боловсруулсан нь төслийн хүчин чадлаа 1.6 дахин нэмэгдүүлсэн үзүүлэлт юм.


Өдгөө тус үйлдвэрийн хамт олон 2015-2018 оны богино хугацааны хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх бизнес төлөвлөгөөний дагуу ажиллаж, 2015-2025 оны урт хугацааны хөгжлийн хөтөлбөр боловсруулж буй. Эрдэс баялгийн их уурхай болсон Монгол Улсын уул уурхайн салбарт түүчээ Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн ирээдүй ийн гэрэлтэж байна. ■



Эх сурвалж: “Эрдэнэт” үйлдвэр

# ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК

## ҮЙЛ АЖИЛЛАГАА



## ТАТВАР (2014 он)

Монгол улсын төсөвт **387,9** тэрбум ₮  
 Орхон аймгийн төсөвт **42,8** тэрбум ₮  
 Нийгмийн даатгалын санд **31,7** тэрбум ₮

Нийт **462,4** тэрбум ₮

Борлуулалтын орлогын

**40%**-ийг татварт төлдөг.

## БАЯЛАГ ҮЙЛДВЭРЛЭГЧИД

Үйлдвэрлэлийн болон нийгмийн 32 цех, нэгж:

2013 онд 5797 ажилтан



2014 онд 5841 ажилтан





Сарын дундаж цалин:

2013 онд **1,9** сая ₮

2014 онд **2,1** сая ₮ **8,3%** ↑

## ҮНДЭСНИЙ ХУДАЛДАН АВАЛТ



Дотоодын үйлдвэрлэгч | Бусад

Импорт орлох бүтээгдэхүүний худалдан авалт 2013 онтой харьцуулахад **1,6** дахин өссөн.

## ХЭМНЭЛТ

2013 он



2014 он



- Цахилгаан эрчим хүч **13** тэрбум ₮
- Материал, түлшний зардал **18** тэрбум ₮
- Бусад мөнгөн зардал **12** тэрбум ₮



## Б.Намхайнямбуу: "Эрдэнэт" үйлдвэр олон жил том динозавр байж ирсэн

Д.Бэхбаяр

*"Эрдэнэт" үйлдвэрийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Б.Намхайнямбуутай ярилцлаа.*

**-Та "Эрдэнэт" үйлдвэрийг хөгжлийн гурав дахь шат руу орсон гэж ярьсан. Энэ талаар тодруулж ярина уу?**

-Үйлдвэрийн анхны бизнесийн концепцийг 1994 оноос эхлэн боловсруулж, хэрэгжүүлж ирсэн байдаг. Анхныхыг 1994-2004, хоёр дахь нь одоо 2004-2014 оныг хүртэл хийсэн. Гурав дахь нь эхэлж байна. Компанийн хувьд үндсэн хуулийн шинж чанартай гэж хэлж болохоор энэ бодлогын баримт бичиг маш их чухал. Өмнөх хоёр концепцид авто тээвэр, баяжуулах үйлдвэр, ил уурхай, засвар механизмын завод гэсэн зөвхөн үндсэн дөрвөн газрын төлөвлөгөөг тусгасан байдаг. Харин энэ удаад шинээр дэвшүүлсэн зүйл нь "Хаалт хөгжлийн менежмент" буюу "Уурхайн тогтвортой хөгжил - хаалтын менежмент"-ийг тусгаж өгснөөрөө онцлог. Уурхайн тогтвортой хөгжил нь байгаль орчин, техник

технологи, эдийн засгийг хамарсан өргөн хүрээний ойлголт. Энэ хүрээнд спорт комплекс, эмнэлэг, сургууль, амралтын газар зэрэг нийгмийн олон асуудлыг шийдэж байгаа. Нэг талаас манай үйлдвэр улсын төсөвт гол татварыг төвлөрүүлэхийн зэрэгцээ Эрдэнэт хотын нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж буй компанийн нийгмийн хариуцлага гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл, зөвхөн техник технологийн асуудал биш нийгмийн асуудалтай нь хамт, гэхдээ тогтвортой хөгжил-хаалтын менежментийн хүрээнд шийдвэр гаргах юм.

Ер нь уурхай эхлэхээс хаах хүртэлх хаалтын менежментийг олон улсад хийгээд явдаг. Харин манай аль ч уурхайд энэ менежментийг хэрэгжүүлсэн туршлага байхгүй. Хамгийн гол нь уурхайн нөөц дуусч уурхай хаагдахад орон нутгийн ард түмэн хэвийн ажиллаж амьдрах нөхцлийг л бүрдүүлэх зорилготой. Тэгэхээр Эрдэнэтийн уурхай хаагдахад хот, орон нутгийн хөгжил цэцэглэл цаашид уурхайгаас

хамаарахгүйгээр хэвийн үргэлжлэх боломжийг л хаалтын менежментээр шийдэх юм.

**-Өргөтгөлийн тухайд?**

-Манай уурхайн хүдэр дэх зэсийн агуулга багасч байна. 2010 онд зэсийн агуулга 0.54 хувь байсан бол 2013 онд 0.51, өнгөрсөн жил 0.48 хувь болсон. Тиймээс хүчин чадлыг нэмэгдүүлж, зэсийн агуулгыг өсгөх шаардлагатай. Арга хэмжээ авахгүй бол баяжмалын экспортын хэмжээ буурна. Өөрөөр хэлбэл, баяжмал дахь зэсийн хэмжээг тогтмол барихын тулд энэ өргөтгөлийг хийж байгаа юм.

Үүнээс гадна уурхай дотор хүнд даацын белаз машинаар тээвэр хийж байна. Уг белазын туулах зам нь таваас дээш км хүрвэл эдийн засгийн үр ашиггүй болчихож байгаа юм. Тэгэхээр бид туузан дамжуулга хийх ёстой. Дээрээс нь эрчим хүчний асуудлыг шийдэхээр ажиллаж байна. Төвөлгөөгөөр одоогийн цахилгаан станцыг 48 КВт-аар хүчин чадлыг сайжруулах юм.

### **-Зэс хайлуулах үйлдвэрийг Бор-Өндөрт барихаар болсон тухай та бас ярьсан?**

-Зэс хайлуулах үйлдвэр барихад оролцох зорилготой. Тэгэхдээ бүгдийг "Эрдэнэт" барих тухай биш. Зэс хайлуулах үйлдвэр Монголд хэрэгтэй. Бид 37 жилд хуримтлуулсан туршлага, боловсон хүчний мэдлэгтээ суурилан олон инженерийн мөрөөдөл болсон ажлыг хийх зорилго тавьсан. Зэс хайлуулах үйлдвэрийг хаана барих тухайд мэргэжилтнүүд олон янзын саналтай байдаг. Зарим нь Эрдэнэтэд нөгөө нь Дархан, Сайншанд, Чойрт барих санал гаргадаг. Багагүй хугацаанд судалж, олон талаас нь бодож байж Бор-Өндөрт барих нь зөв гэж үзсэн. Жоншны үйлдвэрийн экспортоо ч дэмжье гэж шийдсэн. Зэсийн баяжуулалтаас гарах хүхрийн хүчлийг жоншны үйлдвэрт ашиглах юм. Түүнээс криолит гэж бүтээгдэхүүн гарган авч Орос, Хятадын зах зээлд борлуулах боломжтой.

Цаашдаа Бор-Өндөрт аж үйлдвэрийн хими металлургийн цогцолбор байгуулах зорилготой. Зэсийн баяжуулалтаас гарах хүхрийн хүчлийг жоншны үйлдвэрт ашиглах юм. Үйлдвэрүүдийг байгуулахдаа харилцан уялдаатай байх асуудлыг бодох ёстой. Нөгөөтэйгүүр хамгийн чухал нь ус. Тэгвэл Бор-Өндөрт ус, дэд бүтэц, ажиллах хүчний асуудлууд бүгд шийдэгдсэн газар шүү дээ. Хятадын зах зээлд байршлын хувьд ойр, мөн байгаль орчны нөхцөл тохиромжтой гээд олон давуу тал бий. Эрдэнэт, Дархан хотууд шиг хөгжих боломжтой суурин гэж харж байгаа.

### **"Эрдэнэт" үйлдвэрт одоогоор тулгарсан ямар асуудлууд байна вэ?**

-Санхүүгийн асуудал байдаг. Манайх жилд олсон орлогоосоо татвар төлөөд үлдсэн ашгаа хоёр улсын Засгийн газарт ногдол ашиг өгдөг. Ингэхээр цаана нь хөрөнгө оруулалт хийх мөнгө үлддэггүй. Үүнээс улбаалан зээл байнга авах шаардлага үүсдэг. Нөгөө талаас байгаль орчны тухайлбал, овоолго буюу үүсмэл ордын асуудлыг шийдэхээр ярьж байна.

### **-Яаж шийдэх вэ?**

-Гүн боловсруулалт хийж цахилгааны утас ч юм уу ер нь л эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг болох юм бол байгаль орчны асуудлаа шийдэхийн хажуугаар, түүнийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл

ч хөгжих боломжтой. Өнөөдөр үүсмэл орд дээр "Эрдмин", "Ачит эх" компаниуд ажиллаж жилдээ нийтдээ 13 мянган тонн зэс экспортолж байна. Хөх ус гэж ярьдаг даа. Тэрхүү уснаас зэсийг дахин шүүж, тунгааж авах нарийн технологиудыг нэвтрүүлэх шаардлага бий. Үйлдвэрийн овоолгууд дээр ажиллах эрх зүйн орчин бүрдээгүйгээс шийдвэр гаргахад бэрхшээлтэй байдаг. Энэ тухай Засгийн газар, Уул уурхайн яам, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдэд танилцуулсан.

### **-Танайх улсын төсөвт хамгийн их татвар төлдөг байгууллага хэвээрээ л байгаа. Өнгөрсөн жил хэдий хэмжээний татвар төлсөн бэ?**

-2013 онд 520 тэрбум төгрөг, энэ жил 462 тэрбум төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

### **-Хямрал нөлөөлж байна уу?**

-Бид ч бас бүсээ чангалж байгаа шүү дээ. Хэмнэлтийн бодлогод шилжсэн. Хүдэр олборлох, өөрийн өртгийг бууруулах гэх мэт тал талын арга хэмжээ авч байна. Мэдээж гадаад зах зээлээсээ хамаардаг учраас зэсийн үнийг дагаад санхүүгийн асуудал гарч ирэх зүйл байна. Гэхдээ эдийн засгийн хүндрэл, хямралыг түр зуурынх гэж ойлгож байгаа. Удирдлага, менежментээ сайжруулаад даван туулаад л гарах ёстой.

### **"Оюу Толгой", "Эрдэнэт" үйлдвэр хоёр хамтарч ажиллахаар болсон. Яг ямар байдлаар хамтарч ажиллах вэ?**

-Аль аль нь гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд. Ийм хоёр том компаниуд хамтарч ажиллах нь гадаадын хөрөнгө оруулалтыг эргүүлж татахад том дохио өгч буй нэг хэлбэр. Бид "Оюу Толгой" компаниаар хөдөлмөр хамгааллын чиглэлд хамтарч ажиллаж байна. Тус уурхайн ажилчид манай Технологийн сургуульд сурч байна. Үйлдвэрийн засвар механикын цех дээр Оюутолгойн захиалгаар Монголд үйлдвэрлэж болох зүйлсийг хийж өгч байна. Цаашдаа зах зээл дээр хамтарч ажиллах чиглэл рүү явна. Эрдэнэт, Оюутолгой, Цагаан суварга төслүүд нэгдэж нийлж, хамтарч гадаад зах зээл рүү тэмүүлж ажилладаг болох байх аа. Энэ нь ч Монгол Улсын эрх ашигт бүрэн нийцнэ гэж бодож байна.

### **-Том төслүүдийг урагшлуулах талаар ярьж байгаа ч явахгүй байна. Магад**

### **37 жилийн өмнө Эрдэнэтийг ч ингэж ярьж байсан байх. Та мега төслүүдийг тойрсон үйл явдлыг юу гэж харж байна вэ?**

-Том төслүүдийг явуулах нь их ач холбогдолтой. Хэлэлцээрийг улам боловсронгуй болгох зүйл гарах нь мэдээж. Эрдэнэтийн уурхайн төслийг эхлэх үед иймэрхүү улс төрийн асуудлууд үүсч байсан гэдэг. Тэгэхээр томоохон төслийг хөдөлгөхөд ганц хоёр хүн ажлаасаа солигдох, улстөржих, өөр бусад зүйлс байдаг юм шиг байгаа юм. Хамгийн гол баримтлах зарчим бол хувь хүнийхээс илүүтэй ард түмний эрх ашиг дээгүүр байх ёстой. Үүний тод жишээ нь "Эрдэнэт" юм. 37 жилийн туршид улсын орны хөгжлийн тэргүүн эгнээнд явж, төсөвт ихээхэн мөнгө төвлөрүүлж ирсэн. Төсөвт мөнгө төвлөрүүлэхийн зэрэгцээ үйлдвэрийг дагасан хот суурин бий болж, жижиг, дунд үйлдвэр хөгжлөө. Бид өнгөрсөн хоёр жилд дотоодын үйлдвэрүүдээ дэмжих бодлого хэрэгжүүлсний үр дүн гарсан. Зургаан жил хаалгаа барьсан молибдений үйлдвэр ажиллаж эхэллээ, үүсмэл орд дээр үйлдвэрүүд ажиллаж байгаа гэх мэтчилэн нэлээд хэдэн үйлдвэр үүдээ нээсэн. "Эрдэнэт" тэднийгээ дэмжихгүй бол дээрх үйлдвэрүүд эргээд хаагдана. Том үйлдвэрийн ач холбогдол их.

Манайх Орхон аймагтай 2016 оныг хүртэл хамтын ажиллагааны гэрээ байгуулсан. Энэ хүрээнд ажлын байр нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэхээр ажиллаж байна. Жишээ нь, Булган, Орхон аймгийн дунд онгоцны буудал барих асуудлыг одоо ид яриад явж байна. Улаанбаатар-Эрдэнэтийн хооронд зам харилцаа муугаас их цаг хугацаа зарцуулж зорчдог оос ажил алддаг тал бий. Мөн энэ хоёр аймагт төмрийн хүдэр, Эгийн голын станц, металлургийн "Бэрэн" үйлдвэр, "Шим", "Ачит-Эхт" гээд экспортод чиглэсэн үйлдвэрүүд ашиглалтад орж байна. Үйлдвэрийн ажилтан, удирдлагууд, нийслэл рүү зорчих хэрэгцээ их гардаг. Бидний хувьд хувьцаа эзэмших бус үйлчлүүлэгч нь байя гэсэн санал тавьж байгаа. Хөгжлийн түүхээ болж, нийгмийн хариуцлагатай компанийн хувьд ажлыг санаачлан эхлүүлэх л гол зорилготой.

### **-Танайх өнөөдөр хэдэн ажилтантай вэ. Ажилчдынхаа нийгмийн асуудалд хэрхэн анхаарч байна вэ?**

-6000 ажилтантай. Үүнээс 300 нь оросууд,гэр бүл,үр хүүхдийг нь оруулбал 1000-гаад орос байна. Ажилчдынхаа нийгмийн асуудлын хүрээнд "Эко 400", "Залуус 600" хорооллууд барьж байгаа. Ажилчид маань банкны зээлэнд хамрагдах боломжтой. Мөн орос ажилчдаа зориулж "Москва-300" хороолол барихаар төлөвлөсөн. Гадаадын ажилчдын аюулгүй байдалд анхаарал хандуулах ёстой. Орос мэргэжилтнүүдэд тав тухтай, эх орондоо амьдарч байгаа юм шиг тайван амьдрах нөхцөл бүрдүүлэх үүднээс нэг цэгийн үйлчилгээг бий болгох зэрэг ажил хийж байгаа.

### **-Зэсийн үйлдвэр дээр хөрөнгө оруулалт татах ямар төлөвлөгөө байгаа вэ?**

-Энэ талаар Аж үйлдвэрийн сайдтай ярилцаж байна. Үйлдвэр хөрөнгө оруулалт дангаараа хийх боломжгүй. Үйлдвэрт болоод төсөвт дарамт учруулалгүйгээр, гадаадын хөрөнгө оруулалт татах замаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байгаа.

Зэс хайлуулах, жоншны үйлдвэр нийлээд ойролцоогоор тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. "Эрдэнэт" баяжмалаа энэ үйлдвэртээ өгч, тэр нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болж экспортод гардаг болох хэрэгтэй. Үйлдвэр байгуулагдсанаар ажлын байр нэмэгдэх, техник технологи эзэмшиж сурах, түүнийг дагасан олон үйлдвэр бий болох ач холбогдолтой.

### **-“Эрдмин” үйлдвэр эцсийн бүтээгдэхүүн хийж байгаа. Үйл ажиллагаа нь хир явж байгаа вэ?**

-“Эрдэнэт” үйлдвэр “Эрдмин”-ий 30 хувийг эзэмшдэг. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлснээр сүүлийн үед ирсэн зочдын өмнө нүүр бардам байх болсон. Өмнөд хөршийн хувийн, жижиг үйлдвэрүүдээс авсан чанарын шаардлага хангахгүй цахилгааны утаснуудыг барилгад ашигласнаар осол, гал түймрийн гол шалтгаан болж байна. Тэгвэл манай “Эрдмин”-ий зэс утас чанарын шаардлага хангасан, хэрэгцээтэй бүтээгдэхүүн болсныг харахад баярлах сэтгэл төрдөг.

### **-Дэлхийн зах зээл дээрх зэсийн чиг хандлага ямар байна вэ?**

-Том зургаар харвал 21-р зуунд Хятад эдийн засгаар тэргүүлж байна.

Зэс хайлуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулахад ашигласан “SKS” технологиор өмнөд хөршид зургаа, Вьетнамд нэг үйлдвэр ашиглалтад орчихсон явна. Ойрын нэг, хоёр жилд 16 үйлдвэр ашиглалтад орох гэж байна. Өөрөөр хэлбэл технологи нь туршигдчихсан гэсэн үг. Финлянд, Япон, Австралийн технологитой харьцуулахад хөрөнгө оруулалт бага шаарддаг, ашиглалтын зардал багатай, техник үзүүлэлтийн хувьд ижил түвшинд хүрчихсэн технологи.

Зэс хайлуулах, жоншны үйлдвэр нийлээд ойролцоогоор тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. “Эрдэнэт” баяжмалаа энэ үйлдвэртээ өгч, тэр нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн болж экспортод гардаг болох хэрэгтэй. Үйлдвэр байгуулагдсанаар ажлын байр нэмэгдэх, техник технологи эзэмшиж сурах, түүнийг дагасан олон үйлдвэр бий болох ач холбогдолтой.

Хятад улсыг дуурайдаг, хуулбарладаг гэж шүүмжилдэг ч түүнийхээ зэрэгцээ хийж бүтээж чаддаг нь харагдаж байгаа юм. Одоо хятадууд зэсийн үйлдвэрлэлд тэргүүлж эхэллээ. Чили, Перу, Монголоос түүхий эдээ авч байна.

“Эрдэнэт” үйлдвэр олон жилийн турш том динозавр байж ирсэн. Өрсөлдөгчгүй байх үед шүүмжлэлд их өртдөг байлаа. Оюутолгой гарч ирснээр энэ зовлонг тэд үүрч байх шиг байна. “Оюу Толгой” компанийг Эрдэнэттэй адил хот байгуулсангүй гэж шүүмжилдэг. Өнөөдрийн Эрдэнэт хотын өнгө бол 37 жилийн үр дүн юм. 1966 онд Чех улсын геологчдийн энэ газарт ирсэн зургийг харахад хэдэн майхан гэр л байдаг. Ганц хоёр жилд хот барьчихгүй.

Том төслүүдийг явуулах шаардлагатай. Харин боловсронгуй болгох ажлыг үргэлж хийж байх нь чухал. Алддаггүй хүн гэж байхгүйтэй адил алдаагүй ажил ч ховор. Түүнийг яаж засч, зүгшрүүлж байгаагаар л тодорхойлогдох ёстой.

### **-Танай үйлдвэртэй хамтарч ажилладаг ханган нийлүүлэгч хэр олон байдаг бол?**

-Монголын том, жижиг олон компани бий. Тухайлбал, өнгөрсөн онд Эрдэнэт хотын 124 компанитай нийт 25 тэрбум төгрөгийн худалдан авалт хийхээр гэрээ байгуулсан байдаг. Энэ нь орон нутгийн бизнес эрхлэгчдээ дэмжиж буй нэг хэлбэр юм.

### **-Үйлдвэрийн ирээдүйг та хэрхэн харж байна вэ?**

-Үйлдвэрийн ирээдүй нөөцтэй шууд хамааралтай. Одоогийн байдлаар уурхайн захын агуулгыг тооцоход 1.5 тэрбум тонн хүдэр байна. 37-42 жил ажиллах нөөц. Харин цаашдаа нөөцийг нэмэгдүүлэх хайгуулыг хийх ёстой. Энэ ажлыг хийхэд бас хөрөнгө хүч шаардлагатай.

Одоохондоо өдөр тутмын ажлаасаа илүү гарч хайгуулын ажилд хөрөнгө оруулж чадахгүй байна. Манай лицензийн талбайд Оюутын ордоос эхлээд хэд, хэдэн шинж тэмдэгтэй газрууд бий.

Түрүү үеийн сайд, дарга нарын хэлж буйгаар хайгуул хийж нөөцийг бүрэн тогтоовол 100 жил ажиллах магадлалтай нөөц бий гэдэг. Өнөөдөр ил уурхайг л ашиглаж байна. Түүний дор, газрын гүнд хэдий хэмжээний нөөц байгааг тогтоож чадаагүй л явж байна шүү дээ. Тиймээс цаашдын ирээдүйг тодорхойлохын тулд геологийн ажилд мөнгө зарцуулах шаардлагатай байгаа юм. ■

# Олон улсын хэмжээнд нүүрсний хэрэглээгээ хязгаарлаж эхэллээ

С.Оюун /УИХ-ын гишүүн/  
Д.Дагвадорж /МУ-ын уур амьсгалын өөрчлөлтийн асуудал хариуцсан тусгай элч



Энэ 2015 он дэлхийн уур амьсгалыг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг шинэ шатанд гаргахад онцгой ач холбогдолтой жил болж байна. Учир нь сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар явагдсан яриа хэлэлцээний үр дүнд энэ асуудлаар улс орнуудын хүлээх үүрэг хариуцлагыг олон улсын хэмжээнд хуульчлан тогтоосон шинэ Протоколыг хэлэлцэж батлах НҮБ-ын дээд хэмжээний бага хурал Парис хотноо энэ оны 11 сарын сүүлчээр хуралдана.

Олон улсын хэмжээнд дагаж мөрдөх энэхүү шинэ баримт бичиг нь 2021 оноос эхлэн хэрэгжүүлэх уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн шинэ бодлого стратеги, түүнтэй уялдан эдийн засгийн холбогдох салбаруудын үйл ажиллагаанд тавигдах шинэ шаардлагуудыг хуульчлан тогтоох юм.

Өнөө үед улам эрчимжиж байгаа дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, тогтворжуулахад эрчим хүчний салбарын үйл ажиллагаа, ялангуяа нүүрсний хэрэглээг хязгаарлах, эрчим хүчний хэрэглээг хэмнэх, сэргээгдэх эх үүсвэр өргөн ашиглах, үйлдвэрлэлийн технологийг шинэчлэх явдал онцгой учир холбогдолтой байдаг. Иймд энэ шаардлагад нийцсэн хөгжлийн бодлого стратеги хэрэгжүүлэх, цаашдын хөгжлийн хэрэгцээ шаардлагаа хэрхэн хангах талаар улс орон болгон одооноос эхлэн төлөвлөж, тодорхой арга хэмжээ авч эхэлж байна.

Монгол шиг эрчим хүчний бараг бүх хэрэгцээгээ нүүрсээр ажилладаг дулаан цахилгааны станцуудаас хангадаг улс орнуудын хувьд энэ асуудал онцгой хамааралтай тул энэхүү шинэ шаардлага, олон улсын хөгжлийн

зарчмуудыг мөрдөхийн зэрэгцээ нийгэм-эдийн засгийн хөгжлийн зорилгоо хэрхэн хэрэгжүүлэх талаар анхаарч тодорхой арга хэмжээ авах шаардлагатай болж байна.

Олон улсын хэмжээнд мөрдөх хөгжлийн энэхүү шинэ үзэл баримтлал, зарчим нь дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг тогтворжуулахын тулд агаарт ихээр хуримтлагдаж байгаа хүлэмжийн хийг ойрын ирээдүйд мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулах нийтлэг шаардлагатай уялдан гарч иржээ.

Дани улсын Копенхаген хотноо 2009 онд хуралдсан НҮБ-ын бага хурлаас дэлхийн дулаарлын хэмжээг 20С-аас хэтрүүлэхгүй байх зорилт дэвшүүлсэн байдаг. Энэ заагаас хэтэрвэл байгаль экологи, нийгэм, эдийн засгийн ихээхэн хямрал, эрсдэл дагуулахыг эрдэмтэд, улс төрчид анхааруулж байна. Үүний тулд юуны өмнө дэлхий нийтийн хэмжээгээр агаарт хаяж байгаа хүлэмжийн хийн өнөөгийн хэмжээг 2050 оны үе гэхэд наад тал нь 50-80%-иар бууруулах шаардлагатай гэж үздэг. Энэ нь биелүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй маш том зорилт учраас улс орон бүр, ялангуяа хүлэмжийн хий ихээр ялгаруулдаг, эрчим хүчний хэрэглээ өндөртэй орнууд ихээхэн хүчин чармайлт гаргаж, хүлэмжийн хийн эх үүсвэрүүдийг хязгаарлахад чиглэсэн тодорхой арга хэмжээ авах шаардлагатай болно. Учир нь эрчим хүчний салбар, тэр тусмаа нүүрс ихээр шатааж эрчим хүч үйлдвэрлэдэг цахилгаан станцууд болон бусад цахилгаан дулааны үйлдвэрлэгчид нь байгаль орчинд ихээхэн халтай үйлдвэрлэл явуулж хүлэмжийн хийн дийлэнх хувийг гаргадаг.

Олон улсын эрчим хүчний агентлагийн мэдээгээр дэлхий нийтийн хэмжээгээр үйлдвэрлэж байгаа нийт цахилгаан эрчим хүчний 41%-ийг нүүрсээр ажилладаг цахилгаан станцууд үйлдвэрлэж байна.

Энэ үзүүлэлт АНУ-д 45%, Германд 41%, Хятадад 79%, Энэтхэгт 68% байдаг бол Монголд 95% орчим байна. Үйлдвэрлэл, хэрэглээний өсөлтөө дагаад эрчим хүчний хэрэгцээ ойрын 20-30 жилийн хугацаанд мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдэх тул уур амьсгалын шинэ бодлоготой уялдуулан нүүрсний хэрэглээний өсөлтийг хязгаарлах, эрчим хүчний сэргээгдэх болон бусад шинэ эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодитой арга хэмжээ авах шаардлагатай болж байгаа юм. Тухайлбал, сүүлийн 30 жилийн дундажаар 2.5% байсан нүүрсний хэрэглээний жилийн өсөлтийг 2012-2040 оны хоорондох хугацаанд 0.5% -аас хэтрүүлэхгүй байх зорилтыг Олон улсын эрчим хүчний агентлагаас баримтлаж байна.

Нүүрсний хэрэглээний өсөлт ойрын арван жилд гарч цаашид тогтворжин буурах хандлагатай байна. Нүүрсний хэрэглээ аж үйлдвэржсэн өндөр хөгжилтэй ихэнх оронд 2012-2040 оны хооронд бараг гуравны нэг хувиар буурах бол Хятадад ч мөн 2030 оны үед хэрэглээний хамгийн дээд төвшинд хүрээд цаашид өсөлт нь саарах төлөвтэй байна. Харин Энэтхэгийн хувьд нүүрсний хэрэглээ үргэлжлэн өсч 2020 оноос өмнө АНУ-ыг гүйцэн түрүүлж дэлхийн хоёрдох том нүүрсний хэрэглэгч болно. Зах зээлийн үнэлгээгээр 2040 оны үе гэхэд Хятад, Энэтхэг, Индонези болон Австрали улс нийлээд дэлхийн нүүрсний нийт бүтээгдэхүүний 70 гаруй

хувийг олборлож, нүүрсний худалдаа, үнийн бодлогыг тодорхойлоход Азийн орнууд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Иймд Парист батлагдах шинэ баримт бичгийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэлхийн нүүрсний томоохон хэрэглэгч улсууд болох Хятад, АНУ, Энэтхэг, Европын холбооны улсуудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн хүчин чармайлт, тэдгээрийн хамтын ажиллагаа ихээхэн үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Эдгээр орнууд Парисын Бага хурлаас өмнө зоригтой тодорхой алхамууд хийж, хамтын ажиллагааны зорилтуудаа тодорхойлж эхлээд байна.

Дэлхийн хамгийн их хүлэмжийн хий ялгаруулагч орнууд болох АНУ, Хятад улс хоёр өнгөрсөн оны 11 дүгээр сард уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр, хүлэмжийн хийн ялгаралтаа бууруулах талаар хамтарч ажиллахаар тохиролцсоноо зарласан. АНУ-ын хувьд хүлэмжийн хийн ялгаралтаа бууруулах хурдаа 2 дахин нэмэгдүүлж 2025 он гэхэд 2005 оны үзүүлэлтээс 26-28 хувиар бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах, харин Хятад улс 2030 оноос эхлэн хүлэмжийн хийн ялгаралтаа бууруулж эхлэх зорилт дэвшүүлсэн байна. Түүнчлэн саяхан Энэтхэг Хятад хоёр хамтарсан мэдэгдэл гаргаж, өөрсдийн нүүрсхүчлийн хийн ялгаралтыг бууруулах талаарх зорилтоо тодорхойлсон төлөвлөгөөгөө Парисын хурлын өмнө танилцуулах үүрэг авсан юм.

Таван жилийн өмнө Копенхагений Бага хурлын үед АНУ, Хятад, Энэтхэг зэрэг улсууд ийм хамтарсан мэдэгдэл хийж, хүлэмжийн хийн ялгаралтаа бууруулах талаар үүрэг амлалт авна гэж төсөөлөхийн аргагагүй байсан бол дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн явц, шинжлэх ухааны дүгнэлтүүд тэднийг ийм арга хэмжээ авахаас гарцаагүй байдалд хүргээд байна.

Бодит байдал дээр эдгээр гурван орон ЕХ-ны улсуудтай хамтраад ирээдүйн дэлхийн нийт эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний ихэнх хэсгийг бүрдүүлэх болно. Уур амьсгалын асуудлаар дүн шинжилгээ хийдэг ашгийн бус зарим байгууллагын судалгаагаар 1850-2012 оны хоорондох хугацаанд АНУ болон ЕХ хамтдаа өнөөгийн агаар мандалд гаргасан хүлэмжийн хийн 45

хувийг ялгаруулсан бол, Хятад, АНУ хоёр хамтдаа үүний 18%-ийг гаргажээ.

Өнөөгийн үйл ажиллагаанд үндэслэн хийсэн тооцоогоор 2020 оны үе гэхэд Хятад улс дангаараа дэлхий нийтийн хэмжээгээр ялгаруулж байгаа хүлэмжийн хийн 24%, Энэтхэг 7%, АНУ 13%, ЕХ-ны улсууд нийлээд 8%-ийг гаргахаар байгаа нь дэлхийн нийт ялгаралтыг 50 гаруй хувийг эзэлж байна. Иймд эдгээр орнуудын хүчин чармайлтаас дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн арга хэмжээний үр дүн шууд шалтгаална.

## Нүүрсний хэрэглээ ойрын арван жилд өсч цаашид тогтворжин буурах хандлагатай байна

Нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтоо хангах, ядуурлыг бууруулах асуудал улс орны хэмжээний тэргүүлэх зорилт хэвээрээ байгаа өнөө үед эдгээр улсад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах талаар өргөн хүрээтэй арга хэмжээ авах нь ихээхэн бэрхшээлтэй тулгарч, эдийн засгийн өсөлтийг мэдэгдэхүйц хэмжээгээр сааруулахад хүргэж болзошгүй. Гэвч уур амьсгалын өөрчлөлтийн учруулах эрсдэл, таагүй нөлөөллийг анхаарч үзвэл дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн дорвитой арга хэмжээ авахаас өөр аргагүй.

Энэтхэгт уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр үер усны аюул, Гималайн уулсын мөсөн голууд хайлах зэрэг олон асуудал тулгарна. Зарим судалгаагаар дэлхийн агаарын температур дунд зэрэг нэмэгдэхэд Энэтхэгийн хөдөө аж ахуйн бүтээгдхүүний үйлдвэрлэл 38% буурахаар байна. Хятадын Цаг уурын албаны мэдээгээр уур амьсгалын өөрчлөлт нь тус улсын эдийн засагт ноцтой нөлөөллийг үзүүлнэ, тухайлбал газар тариалангийн бүтээгдэхүүн буурч, байгаль экологийн ихээхэн хохирол учирч, голуудын урсац тогтворгүй болно гэжээ.

Засгийн газрын 2011 илтгэлд

дурьдсанаар уур амьсгалын өөрчлөлтийн улмаас 2050 оны үед үр тарианы бүтээгдэхүүн 5-20% буурч болохыг анхааруулсан байна.

Бусад улс орны хувьд ч өөрсдийн онцлог нөхцөл байдлаас хамааран уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалсан сөрөг таагүй нөлөөлөлтэй тулгарч нийгэм, эдийн засгийн хөгжилд нь ихээхэн саад бэрхшээл учирч эхлээд байна.

Монгол орны хувьд усны нөөц хомсдох, цэвдэгт хөрс, өндөр уулын мөсөн голууд хайлах, хөрсний үржил шим доройтож цөлжилт хүрээгээ тэлэх, ган, зуд, хүчтэй салхи шуурга зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн эрсдэл нэмэгдэх, үр тариа болон малын ашиг шим буурах зэрэг таагүй нөлөөлөл учирна. Иймд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгаралтыг багасгахад чиглэсэн арга хэмжээг улс орноо хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн учруулах нөлөөлөл, эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээтэй уялдуулан авч хэрэгжүүлэх шаардлагатай болж байна.

Хятад улс саяхан түүхий нүүрсний хэрэглээг хязгаарлах, экспортын болон дотоодын хэрэглээнд заавал боловсруулсан нүүрс нийлүүлэх шийдвэр гаргасан байна. Мөн дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын сан болох Норвегийн сан нүүрсний үйлдвэрлэлтэй холбоотой аливаа төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулалт хийхгүй байх шийдвэр гаргаснаа энэ сарын эхээр зарлалаа. Мөн хэдхэн хоногийн өмнө Германд чуулсан Их долоогийн дээд хэмжээний уулзалтаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахын тулд малтмал түлшний хэрэглээг хязгаарлах, сэргээгдэх эрчим хүчийг өргөн ашиглах, эрчим хүч, байгалийн нөөц түүхий эдийн хэрэглээний үр ашгийг дээшлүүлэхэд онцгой анхаарч нэгдсэн дорвитой арга хэмжээ авах шийдвэр гаргасан байна.

Энэ бүхэн нь улс орны нийт экспортод ихээхэн хувь эзэлдэг, эрчим хүчний үйлдвэрлэлийн гол эх үүсвэр болох нүүрсний салбарын талаар баримтлах бодлогоо дэлхийн болон бүс нутаг, хөрш орнуудын хөгжлийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн үндсэн зарчмуудтай уялдуулах шаардлага зүй ёсоор тулгарч байна. ■



## Бизнес эрхлэгчид нэгнийдээ зочилж эхэллээ

Г.Түшээ

*Монголын бизнесийн зөвлөл нь Монгол Улс дахь худалдаа, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах үндсэн зорилготойгоор анх 2007 оны намар байгуулагдсан. Тус зөвлөл нь бизнесийн орчинтой холбоотой асуудлуудаар дотоод болон гадаадын хөрөнгө оруулагч гишүүдийнхээ дуу хоолой, төлөөлөл болон ажилладаг.*

Монголын бизнесийн зөвлөлийн гишүүн байгууллагуудын төлөөлөл бүхий 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг өнгөрсөн сард нарны цахилгаан үүсгүүр үйлдвэрлэдэг “Сопоко” компанийн үйлдвэртэй танилцав. Энэхүү танилцах аяллыг бизнесийн зөвлөлийн Эрчим хүч, байгаль орчны ажлын хэсгийнхэн санаачилсан бөгөөд цаашид ийм арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах аж. Тус ажлын хэсгийн ахлагч, Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагын Ногоон хөгжлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Булганмөрөн “Манай улсад салхины болон усан цахилгаан станцын бүтээн байгуулалтууд нэлээд хийгдэж байгаа. Эдгээрийн тухай аливаа хурал цуглаан дээр зөвхөн яриад л өнгөрдөг. Тэгвэл бид үүнийг

зөвлөлийнхөө гишүүддээ нүдээр үзүүлж, техникч сэтгэлгээг суулгуулахыг зорьж байна. Энэ үүднээс уг арга хэмжээг зохион байгуулж байгаа юм” хэмээв.

“Сопоко” ХХК-ийн үйлдвэр нь толгой компани болох “Шилэн хийц” компанитай нэг байранд байрладаг бөгөөд тэд нарны самбар болон нарны эрчим хүчээр ажилладаг төрөл бүрийн цахилгаан хэрэгслийг дөрөв дэх жилдээ үйлдвэрлэж байна. Байшин барилга болон цахилгаан станцид зориулсан 250-260 ваттын хүчин чадалтай нарны дэлгэц, малчдад зориулсан 150 ваттынхыг ч хийдэг. Мөн зөвхөн гэрэл, зурагт ажиллуулах зориулалттай 73 ваттын нарны дэлгэц буюу малчдын хэлж заншсанаар нарны толийг Монголдоо үйлдвэрлэж байна. Үнийн хувьд гол түүхий эдээ урд хөршөөс худалдан авдаг тул импортоор орж ирж буй нарны толиос бага зэрэг өндөр байдаг гэнэ. Тухайлбал, 150 ваттын нарны дэлгэцийг 400 мянган төгрөгийн үнээр худалдаалж байна.

Эдний зорилтот зах зээл малчны “хот”. Малчдад зориулсан 12 вольтын хөлдөөгч, зурагт, айрагны бүлүүр зэрэг цахилгаан хэрэгслийг захиалгаар үйлдвэрлэж, “Хот айл” гэх үндэсний

брэндийг бий болгожээ. “Сопоко” компанийн дэд захирал Т.Чингэс “Монголын эрчим хүчний салбар ногоон руу чиглэж байна. Шинэ технологийг зоригтой нэвтрүүлэх хэрэгтэй” хэмээсэн. Тус компани Япон, Герман технологийг нэвтрүүлэн ажиллаж байгаа аж. Толгой компани “Шилэн хийц” ХХК-ийн үйлдвэрийн хамт олон жилдээ 1320 тонн шил үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлж байгаа төдийгүй улсын шилний хэрэглээний 40-50 хувийг хангаж байна. Ийм төрлийн танилцах аяллыг зохион байгуулснаар дотоодын компаниуд зах зээлээ тэлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх боломж нээгдэх юм. Нөгөөтэйгүүр, Монголын зах зээлийг гадаадад нээх, хөрөнгө оруулалтыг татах суурь болох учиртайг зохион байгуулагчид дурьдаж байлаа.

Ийнхүү Монголын бизнесийн зөвлөлийн гишүүд анх удаа нэгнийдээ “зочилсон” бөгөөд цаашид тэд бусад гишүүн байгууллагуудтай төдийгүй өөрсдийн компани, үйлдвэрээ танилцуулах хүсэлтэй буйгаа ажлын хэсгийнхэнд хэлсэн юм. Зөвлөлийн зүгээс ч уг аяллыг удаа дараа зохион байгуулах аж. ■

# Нийслэлийн НИЙГМИЙН ХӨГЖИЛ

Нийгмийн хөгжлийг хот байгуулалт талаас нь онцолбол нийгмийн дэд бүтэц буюу хүмүүсийн ажиллаж, амьдрахад чиглэсэн гол байгууллагууд орно. Тухайлбал, төрөх эмнэлэг, эрүүл мэндийн болон боловсролын байгууллагууд. Цаашлаад нийгмийн идэвхтэй харилцаанд орох буюу соёл урлаг, биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд багтах юм.



# Ц.Энхцэнгэл: Хөгжлийн хувьд иргэд боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн харилцааны өндөр түвшинд хүрэх ёстой

Б.Үүрийнтуяа

*Нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ц.Энхцэнгэлтэй Улаанбаатар хотын хөгжил, нийгмийн тулгамдаж буй асуудлаар ярилцлаа. Тэрбээр нийгмийн тулгуур гэгдэх нийслэлийн эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, биеийн тамир спорт, мөн нийслэлийн аялал жуулчлал гэсэн үндсэн таван салбарыг хариуцан ажилладаг бөгөөд улс орон, нийслэлийн хөгжлийн асуудалд иргэн бүрийн оролцоо чухал гэдгийг онцолж байсан юм.*

**-Хөгжил гэдэг үг их өргөн хүрээтэй. Нийслэлийн хөгжил гэхээр чухам ямар ойлголт юм бэ?**

-Нийслэлийн нийгмийн хөгжил гэвэл мэдээж их өргөн хүрээ хамарсан маш том ойлголт. Улс орны хөгжлийн ойлголт гэсэн үг шүү дээ. Улаанбаатар хотод Монгол Улсын хүн амын тал орчим хувь ажиллаж, амьдарч байна. Олон айл өрхийн хуримтлал, хадгаламж, бизнесийн үйл ажиллагаа, ирээдүйн амьдралын зорилго нь нийслэлд төвлөрч байгаа, ДНБ-д эзэлж буй хувь хэмжээгээрээ ч улсын эдийн засаг, хөгжилд тодорхойлох үүрэг хүлээж буй.

Нийслэлийг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө гарсан. 2030 он хүртэл баримтлах хөгжлийн чиг хандлага гээд УИХ-аас баталсан, өндөр ач холбогдол бүхий төлөвлөгөө ч бий. Зорилго тавьсан, түүний хүрээнд Улаанбаатар хот найман дэд төвтэй байх, тэдгээр нь худалдаа үйлчилгээ, хүн амд үзүүлэх нийгмийн үйлчилгээ болон нийгмийн, инженерийн дэд бүтцийг бий болгох гэх мэт зорилтууд агуулж байна. Эдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэгдэж буй 25 гаруй их наяд төгрөг бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлууд болон иргэдийн амьдралын

чанарыг дээшлүүлэх гээд хөгжлийн төлөөх хөрөнгө оруулалт болно. Нийгмийн хөгжлийг хот байгуулалт талаас нь онцолбол нийгмийн дэд бүтэц буюу хүмүүсийн ажиллаж, амьдрахад чиглэсэн гол байгууллагууд орно. Тухайлбал, төрөх эмнэлэг, эрүүл мэндийн болон боловсролын байгууллагууд. Цаашлаад нийгмийн идэвхтэй харилцаанд орох буюу соёл урлаг, биеийн тамир, спортын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд багтах юм. Бүтээн байгуулалтыг барилга барих гэх мэт хэрэгцээ хангах байдлаар ойлгож ирсэн. Гэтэл нөгөө талдаа энэ нь эрүүл, боловсролтой байх гээд дараагийн шат руу шилжиж байгаа ойлголт. Хөгжил ямар байх вэ гэхээр өндөр хөгжилтэй орнуудын иргэдийн аж амьдрал, амьдралын чанарт дөхөж очих. Хөгжлийн хэмжүүрүүд гэж бий.

**-Хүний хөгжлийн үндэс гэгдэх эрүүл мэнд, боловсролын салбарыг дээрх хөгжлийн хэмжүүрүүдээр авч үзвэл ямар түвшинд байна вэ?**

-Хөгжлийг маш олон янзаар хэмжинэ. Боловсролын салбарт "Боловсролын цөм хөтөлбөр" гээд хэрэгжиж байна. Энэ хөтөлбөрөөр боловсролын чанарт ахиц гаргаж, хүртээмжийг дээшлүүлэх зэрэг зорилт тавиад ажиллаж байгаа. Азийн орнууд боловсролын түвшнөөрөө дээгүүр жагсах болсныг олон улсын судалгаануудаас харж болохоор. Тэр дунд манай орон харьцангуй хоцрогдолтой явж байгаа ч бүр хоцрогдсон гэж бас болохгүй. Учир нь нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээсээ хамаараад харьцангуй ойлголт шүү дээ. Ерөнхийдөө, амьдралын хэвшлээсээ хамаараад боловсролын байгууллагын хүртээмж муу, чанар сул гэсэн ойлголт байдаг. Тэр хүрээнд зорилт тавиад сайжруулахаар ажиллаж байна.

Боловсролын стандартын хувьд бол төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын чиг үүргийн хүрээнд сургалтын агуулга, хэлбэр тогтоогддог учраас олон улсын жишиг, хандлагаас зөрсөн, гажсан зүйл байхгүй. Чанарын хувьд ахиулах, сайжруулах шаардлага бий. Зөвхөн шийдвэрлээд зогсох биш үргэлжлүүлэн хөгжүүлэх тал дээр ихээхэн анхаарал хандуулах хэрэгтэй. Боловсролын салбар байнгын хөдөлгөөнд оршдог салбар. Энэ утгаараа хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, шат шатаар ахиулж явахгүй бол зогсонги байдалд ордог.

Эрүүл мэндийн салбар өнөөдөр ямар түвшинд байгааг хүн бүр мэднэ. Нийслэлийн хэмжээнд нийт эрүүл мэндийн байгууллагын барилга, байгууламжийн 90 хувь нь зориулалтын бус эсвэл ашиглалтын шаардлага хангахгүй болчихлоо. Үзүүлж буй үйлчилгээ нь анхан болон хоёр, гурав дахь шатлалын эмнэлэгүүддээ жигд бус. Хүмүүс гурав дахь шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад түлхүү үзүүлж шаардлагагүй дараалал үүсгэж байна. Мөн эмч нарын ажлын байран дахь давтан сургалт, өрхийн буюу нэгдүгээр шатлалын эмчилгээ үзүүлэх шинжилгээ, оношилгоо, зөвлөгөөний асуудал санасан түвшинд хүрэхгүй гээд асуудал мундахгүй. Иргэд гадаад руу эмчилгээнд явах нь их болсон. Зарим талаараа үргүй зардал гарч байгаагаас гадна итгэлийн асуудал тулгамдаж байгаа юм. Эрэлт, нийлүүлэлт талаас нь авч үзвэл шаардлагатай эмчилгээ, оношилгоо хийх мэргэжлийн эмч нар хүмүүст хүрч ажиллаж чадахгүй байна. Эдийн засгийн хүрээнд олон тоо ярьдаг. Жилд дунджаар 100 гаруй сая ам.доллар гадагш алдаж байна ч гэдэг. Улсын эмнэлгүүд санхүүжилтийн хувьд байнга

дутагдалтай явж ирсэн. Инфляци өсөх тусам ирэх төсөв танагдах болж,үүнийг дагаад үйлчилгээ, хангамжийн асуудал хүнд болж буй. Жишээлбэл, эмийн зохистой хангамж доголдох. Тэгэхээр зохицуулалт талаас нь сайтар анхаарч ажиллах шаардлагатай.

### **-Хувийн эмнэлэгүүдийн “зовлон” хэр их байна вэ?**

-Хөрөнгө оруулалт сайн хийгээд явж байгаа хувийн эмнэлгүүд бий. Гэхдээ хөрөнгө оруулалт нэлээд их хийчихсэн хэрнээ оруулж ирсэн тоног, төхөөрөмж нь сул зогссон, улмаар алдагдалтай ажиллаж байгаа эмнэлгүүд ч байна. Хүн ажлын байран дээрээ хөгжиж байх ёстой байтал захиргааны, татварын, мэргэжлийн хяналт эсвэл маркетингийн асуудлуудаа шийдэхийн тулд тэр рүүгээ хамаг анхаарлаа хандуулаад мэргэжлийнхээ хүрээнд хөгжих боломжгүй болох тохиолдлууд гарсаар байгаа. Иймд салбарт ажиллаж буй хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллахад анхаарах шаардлага үүсч байгаа юм. Ингэхдээ зохион байгуулалтын арга хэмжээ авахгүй бол зарим талаар цааш явахгүй хэмжээнд яригдах энүүхэнд боллоо.

### **-Та бүхний хэрэгжүүлэхээр дэвшүүлээд буй зорилго, зорилтын хүрээнд холбогдох байгууллагууд хэр уялдаа холбоотой ажиллаж байна вэ? Дээд түвшний байгууллагууд хоорондоо нягт холбоотой ажилладаггүйгээс үүдэн бодлого, хэрэгжилтийн зөрчил их гардаг шүү дээ.**

-Харилцан уялдаа холбоо мэдээж байлгүй яахав. Хууль, тогтоомжид заасан чиг үүргийн дагуу төрийн захиргааны төв байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллагууд харилцан хамтарч ажилладаг. Төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр тухайн салбарын ерөнхийлөн захирагч буюу сайдын чиг үүргийг Нийслэлийн Засаг дарга орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ хийж хэрэгжүүлдэг 6-7 салбар байдгийн тавыг манайх гардан хариуцдаг. Санхүүжилт, бодлогын ихэнх баримт бичиг холбогдох яам, төв байгууллагууд дээрээ боловсрогддог. Бид хүний нөөц, захиргааны, засаглалын үйл ажиллагаа талаас гол үүрэг, оролцоотой. Гэвч уялдаа холбоог илүү сайжруулж, анхаарах ёстой. Жишээлбэл, Эрүүл



*Ц.Энхцэнгэл: Манай нийгмийн салбар илүү сайн төлөвлөгөөтэй болж байгаа.*

мэндийн яам Нийслэлтэй харилцан зөвлөлгөөгээр төрийн захиргааны тодорхой байгууллагуудтайгаа хамтраад янз бүрийн дүрэм, журам гаргачихдаг. Тэрийг нь орон нутгийн захиргааны байгууллага төсвийн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа учраас хэрэгжүүлэх үүрэгтэй болдог. Гэтэл бодит байдал дээр хүндрэл учруулсан хэд хэдэн жишээ бий. Тухайлбал, түргэн тусламж үйлчилгээний тасаг Хууль зүйн сайд, Цагдаагийн ерөнхий газрын харьяанд байхаар хүний нөөцийн хувьд энэ чиглэлийн сургалт алдагдаж буйг ажиллагсад хэлдэг. Мөн нэлээд хүндрэл үүсгэж өнөөдрийг хүртэл шийдэгдээгүй явж байгаа нэг асуудал бол архидан согтуурсан иргэдийг эрүүлжүүлэх үйл ажиллагаа гээд Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайд хамтраад тушаал гаргасан. Ингээд дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд архидан согтуурсан иргэдийг эрүүлжүүлэхээр хүргүүлдэг болсон. Угаасаа байшин, барилга нь ашиглалтын шаардлага хангахгүй, дээрээс нь хүн амын ачаалал хэт их гэгдэх дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд дахиад согтуу иргэдийг эрүүл болго гээд өгчихөөр бид сайдын тушаал гээд хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Ингээд хүмүүсээ шахдаг. Гэтэл бодит байдал дээр тэр нь эргээд манай бусад үйлчилгээг унагадаг. Жил гаруйн хугацаанд холбогдох байгууллагуудад хандаж байгаа ч шийднэ гэсэн хариу авах төдий хүлээгээд сууж байна. Яг

энэ асуудалд дээр харилцан ярилцаж шийдвэрлэх байсан. Орон нутгийн захиргааныхан оролцож, саналаа хүргүүлэх байсан. Ингэхгүй болохоор орон нутагтаа асуудал хариуцаад явж байгаа бидэнд эргээд том хүндрэл болж байгаа юм. Зөвхөн эрүүл мэнд гэлтгүй бусад салбарт ч ийм төрлийн бэрхшээлүүд гардаг. Жишээлбэл, хот төлөвлөлт дээр нийгмийн чанартай дэд бүтцээ бий болгох, цэцэрлэгт хүрээлэн, спортын байгууламж зэргийг ярихаар дүрэм, журмын хувьд ч шаардлагын хувьд ч тэр болгон ажлын уялдаа холбоог хангаж чаддаггүй, одоог хүртэл ярилцах хэмжээнд л явж байна. Өмнө нь зохицуулах боломжтой байсан зүйлсийг санал солилцох түвшинд л хэрэгжүүлж байна. Хөрөнгө оруулалт дээр ч мөн хөрөнгө оруулалтын ажилд шаардлагатай газар хот төлөвлөлтийн норм, дүрэм, бэлтгэл ажил зэргийг Нийслэл дээр бүрэн гүйцэт шийддэггүй байхад зарим хөрөнгө оруулалт хэдийнэ хийгдэж, тэр нь эргэж татагдсан эсвэл үр өгөөж нь зогссон тохиолдлууд байдаг. Тэгэхээр уялдаа холбоог хаа хаанаа анхаарч ажиллах шаардлагатай.

**-Соёл, урлагийн салбарт хүчин зүтгэж буй хүмүүс бор зүрхээрээ явж байна даа гэдэг. Энэ тал дээр Нийслэлтэй хамтрах ямар боломжууд байдаг юм бол. Захиргаатайгаа хамтарч ажиллах боломжуудаа тэр бүр мэддэггүй байж болох юм?**

-Бид нийгмийн соёл, урлагийн

салбараа хөгжүүлэхэд анхаарч ажиллаж байгаа. Ингэхдээ эдийн засгийн харилцаа гол утга байх талд түлхүү анхаарч байна. Жишээ нь, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг НИТХ-аар батлуулж, нийслэлийн төсвийн тав хүртэлх хувийг соёл, урлагийн салбар, олон нийтийг хамарсан арга хэмжээнүүд мөн аялал жуулчлалыг татахад чиглүүлэхээр төлөвлөсөн. Эдгээр нь эргээд шууд болон шууд бус орлогоор бусад салбараа дэмжих, бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын өгөөжийг сайжруулахад чиглэх байдлаар дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Зөөлөн гэгддэг соёл, урлагийн салбар нь нийгмийн харилцааг эерэг болгох, нийгмийн стресс бухимдлыг тайлах, түүнчлэн хүмүүсийн сэтгэлийн ирэлхийлэл болдог учраас хүмүүсийн уран сайхны мэдрэмж, соёлын уулзах цэг нь болдог. Тэгээд ч амьдралын анхдагч хэрэгцээ хангагдаад ирэхээр хүмүүс арай өндөр түвшний буюу соёлын хэрэгцээндээ илүү анхаарч эхэлдэг. Аялах, жуулчлах сонирхолтой дэлхийн хүмүүс үндсэндээ анхдагч хэрэгцээгээ хангачихсан, дараагийн шатны эрхэм хэрэгцээгээ хангах гэж яваа. Тэгэхээр Монгол ч гэсэн тэдний эрэлт, хэрэгцээнд нийцсэн уламжлалт зан заншил, өвөрмөц соёлыг түгээх бүрэн боломжтой орон. Соёл, урлагийн тоглолтоос гадна сонин, сэтгүүл гэх мэт бүтээлч урлагийг дэмжихийг мөн зорьж байгаа. Эдийн засгийн солилцоо үүсгэх чадвартай байх хэрэгтэй. Энэ нь нийгмийн хөгжлийн хувьд иргэд боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн харилцааны өндөр түвшинд хүрэх ёстой



гэсэн үг.

**-Авьяаслаг Азиуд шоу нэвтрүүлэгт “Хөсөгтөн” хамтлаг улсынхаа нэрийг гарган амжилттай оролцсон. Олон нийтийн сүлжээгээр холбогдох газрууд тэднийг дэмжсэнгүй гэх шүүмжлэл нэлээд тархсан. Иймэрхүү арга хэмжээнд оролцоод ирсэн хүмүүсээ ирсэн хойно нь “Та нар сайн байлаа” гэх биш яваххаас өмнө дэмжлэг үзүүлэх тал дээр Нийслэл яг юу хийдэг вэ?**

-Бидний зохион байгуулж буй арга хэмжээнүүд тэдгээр хүмүүст байнгын бэлтгэл, сургуулилт хийх, ашиг орлоготой байх, зах зээлийн харилцаанд орох боломжийг нь бүрдүүлж өгдөг. Урлагийг дэмжих утгаараа ч тэр, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд ч тэр. Түүнээс соёлыг дэмжиж байна гээд хуучных шиг цалинжуулаад явах гэхээсээ илүүтэй манай хүмүүс зах зээлийн харилцаанд өөрсдөө зөв тохироотой оролцох ёстой. Яг дээрх мэтийн олон улсын тэмцээн, уралдаанд явах, маркетингийн шугамаар дэмжих зэрэгт бид мэдээж анхаарах ёстой. Нийслэлийн хувьд тодорхой хэмжээнд яригдах асуудалд улсын төрийн захиргааныхан илүү оролцох шаардлагатай харилцаа. Ер нь бол эдийн засгийн үр өгөөжөө тооцох ёстой шүү дээ. Түүнээс арга хэмжээнд оролцож байгаа гээд ганц сертификат аваад ирэх биш тэрхүү сертификатын цаана олон нийтийн харилцаа үүсээд, тэр нь гадаад сурталчилгаа талаасаа хэр сайн байх зэргийг харгалзах хэрэгтэй. Жишээлбэл, бага хүрээнд байдаг спортын арга хэмжээнд Монголын тугийг бариад нэг хүн гүйх хэр үр дүнтэй вэ гэдгийг бодох хэрэгтэй. Тэгэхээр маркетингийн зүгээс авч үзээд, үр өгөөжийг тооцоолж хэрхэн, аль чиглэлээр яаж дэмжих вэ гэдгээ судалж үзэх шаардлагатай. Энэ тал дээр бид ярилцаад явж байгаа.

**-Танай хариуцдаг салбаруудын нэг болох биеийн тамир, спортын чиглэлээр “Улаанбаатар марафон”-оос гадна улаанбаатарчуудыг нэгдүүлж, спортыг ухуулан таниулах, сурталчилах тал дээр хэрхэн анхаарч ажиллаж байна вэ?**

-Ухуулга сурталчилгаа чухал. Гэхдээ спортын үйл ажиллагаа бага наснаас эхлээд амьдралын дадал, хэвшил болсон байх ёстой гэдэг талаас нь бид түлхүү анхаардаг. Тэр ч утгаараа

цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг жил бүр зохион байгуулдаг. Сургуулийн сурагчдын дунд сагсан бөмбөгийн тэмцээн, мөн “Дуулиан 2020” хөл бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж байна. Багийн спорт гэдэг нь нийгмийн харилцаа, нийгмийн зохион байгуулалтыг дэмжсэн харилцаа байдаг. Хөгжөөн дэмжигчдийг буюу нийгмийг сэргээдэг байдан эерэг үр дүнтэй спорт. Энэ утгаар нь багийн спортыг дэмжих, хөгжүүлэхийг чухалчилж буй.

“Улаанбаатар марафон”-ыг зохион байгуулахдаа олон нийтийн оролцоог голлодог. Өдгөө хоёр дахь жилдээ болж өнгөрсөн тус марафонд хүмүүс гүйж түрүүлэх гэхээсээ илүүтэй олон нийтийн арга хэмжээ гэдэг утгаар нь их эерэг хүлээж авч байгаа. Үүнийг ч олон нийтийн сүлжээгээр тархсан иргэдийн сэтгэгдлээс харж болохоор байсан. Өнгөрсөн жил хүмүүс гараанаасаа буцаж байсан бол энэ жил барианд орсон хүмүүсийн тоо эрс нэмэгдсэн. Үүнээс үзэхэд нийтийн биеийн тамирын үзүүлэлт сайжирсан байна. Спортоор хичээллэж буй хүмүүсийн тоог аль болохоор нэмэгдүүлэхээр хичээн ажиллахын зэрэгцээ нийтийн эрүүл мэнд, биеийн тамирыг хөгжүүлэх, спортыг олон нийтэд хэвшүүлэх арга хэмжээнүүдийг тогтмол байлгахаар зорьж байна.

**-Энэ зорилгуудаа хэрэгжүүлэхдээ юунаас эхлэхээр төлөвлөсөн бэ?**

-Дүүргүүдэд соёлын болон спортын ордонгууд барих төлөвлөгөө гарсан. Ирэх жил эхнээсээ ашиглалтад орно. Түүнчлэн Иргэдийн спортын наадам гэх мэтээр олон нийтийн тогтсон арга хэмжээнүүд зохион байгуулахаар ярилцаад, шийдээд явж байна. Мөн дүүрэг бүрт жижиг хэмжээний усан сангууд ашиглалтад орсныг иргэд мэдсэн байх.

**-Таныг ярьж буй зүйлсээс үзэхэд их юм хийж ээ гэж бодлоо. Гэвч энэ талаар иргэд төдийлэн сайн мэдээлэлгүй сайтай байхгүй байх шиг. Олон нийтэд мэдээлэл түгээх, хүргэх асуудалд ямар байр суурьтай хандаж байна вэ?**

-Мэдээлэл зөвхөн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгэхгүй. Олон нийтийн байнгын харилцаа болох ёстой. Компаниуд зорилтот маркетинг явуулдгийн адил бид ч гэсэн энэ чиглэлд санаа бодож, үйл ажиллагаагаа

тогтмолжуулах, түүнд оролцох сайн дурынхан, идэвхитнүүдээ илүү татан оролцуулах талыг баримтлах хэрэгтэй. Гэхдээ татан оролцуулж, урамшуулж байна гээд мөнгө тараах биш тухайн хүмүүсийн оролцоог үнэлэх, оролцогчдын тоог нэмэгдүүлэх гэх мэтээр анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байгаа. Түүнээс гадна спорт, биеийн тамирын зориулалтын барилга, байгууламжийн ашиглалтыг зорилтот бүлгийн хүмүүст хүртээлтэй болгохыг чухалчилж байна.

**-Он гарсаар хагас жил гаруй боллоо. Энэ хугацаанд хийсэн ажлуудаа дүгнэн хэлвэл, мөн ирэх хагас жилд ямар ажлууд хийхээр төлөвлөсөн байгаа вэ?**

-Энэ жил “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний жил. Өмнө нь зохиогдсон уламжлалт арга хэмжээнүүддээ тулгуурлан үргэлжлүүлэх төлөвлөгөө бий.

Хөтөлбөрийн санхүүжилттэй холбоотой зорилготавиад явж байгаа учир холбоосууд маш сайн үүсч байна. Өөрөөр хэлбэл, дараа жил зохион байгуулагдах арга хэмжээнүүдийн чанар улам сайжрахаар байна. Аялал жуулчлалын компаниуд, тур операторууд үйл ажиллагаагаа илүү оновчтой төлөвлөж сурталчилгаагаа хийх боломжтой болж байна. Жилийн эхний зургаан сард төлөвлөсөн ажлууд амжилттай хэрэгжиж байна. Сүүлийн хагаст энэ эрчээ хадгалаад явбал бид ерөнхий дүр төрх, нуруугаа олж авлаа гэж ойлгож болох юм. Ингэснээр дараагийн жилүүдэд хийх ажилдаа илүү үр дүнтэй, уялдаа холбоотой орно гэж бодож байна.

**-Гадаадын жуулчид бараг л жилийн өмнөөс хаашаа аялах, хэрхэн аялах, ингэхдээ юу үзэх гээд төлөвлөгөөгөө хэдийнэ гаргачихсан байдаг. Үүнтэй уялдсан хөтөлбөр, төлөвлөгөө жилийн өмнөөс гарч чадаж байна уу?**

-Ер нь бол гарсан. Энэ жил бид “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хэлэлцүүлэх шатанд оролцсон тухайн салбарын, мэргэжлийн сонирхол бүхий байгууллагуудтай хамтран зөвхөн захиргааны санаачлагаар биш өмнө нь зохион байгуулагддаг байсан уламжлалт арга хэмжээнүүдээ аль болох сайжруулья гэсний үр дүнд бид энэ жил үйл ажиллагааны календарчилсан

төлөвлөгөө гаргасан. Гэхдээ эхний шат учраас жилийн өмнөөс төлөвлөөд явдаг хүмүүсийн хувьд төвөгтэй асуудлууд гарч л байна. Дараагийн жилүүдэд хийсэн зүйлээ улам чанаржуулах боломжтой. Яаж гэхээр энэ оны үйл ажиллагаа, ирэх жилийн төлөвлөгөө гарсан учраас хандлага илүү нааштай болж ирнэ гэсэн үг. Өнгөрсөн гуравдугаар сард Берлинд болсон И Тэ Бэ аялал жуулчлалын олон улсын үзэсгэлэнд манай улс түнш орноор оролцсон. Тус үзэсгэлэнд түнш орноор оролцож байсан улсуудад үр өгөөж, өсөлт удаах жилд түлхүү ажиглагддаг гэсэн тооцоо байдаг. Тиймээс бид ч мөн ирэх оноос эерэг үр дүн гарна хэмээн хүлээж байна.

**-Нийслэлийн хөгжлийн зураглалаар ирэх таван жилийг төсөөлвөл?**

-Нийгмийн дэд бүтэц талаас аваад үзвэл боловсролын салбарт тулгамдаад буй анги дүүргэлтийн ачааллын асуудлыг зохицуулах эхний үр дүнгүүд гарч эхлэхээр байна. Энэ жил нийслэлийн хэмжээнд 14 бага сургууль, цэцэрлэгийн барилга ашиглалтад орохоор байгаа. Мөн 19 сургуулийн өргөтгөлийн ажил шуударч буй. Эрүүл мэндийн салбарт ч мөн эерэг өөрчлөлтүүд гарна. Тухайлбал, шинэ төрөх эмнэлэг ашиглалтад орохоос гадна Сонгинохайрхан дүүрэгт дүүргийн жишиг эмнэлэг бий болгохоор барилгын суурь ажлыг эхлүүлэх боломжтой гэж үзэж байгаа. Баянзүрх дүүрэгт Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар Анагаахын шинжлэх ухааны сургалтын бааз эмнэлэг гээд дүүргийн иргэдэд үйлчлэх зориулалтын эмнэлэг Японы барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийн стандартын дагуу, ажилтнууд нь хүртэл жишиг байдлаар бэлтгэгдэх гээд хоёр том ажил эхэлж байна. Мөн сүүлийн 30 жилд анх удаа Баянгол дүүрэг шинэ эмнэлэгтэй боллоо.

Сүүлийн жилүүдэд эдийн засаг хүндэрсэнтэй холбоотой улсын зүгээс хийж буй хөрөнгө оруулалт бага, дүүргийн эрүүл мэндийн төвүүдэд үйлчилгээ үзүүлж буй эмч нар ажлын багаж хэрэгсэлгүй, хоцрогдсон байдлаар явж ирсэн. Энэ жил тодорхой захиалга аваад 2.7 тэрбум төгрөгийн багаж, төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийхээр Нийслэлээс шийдвэрлээд байна. Түргэн тусламжийн машин нэмэгдүүлсэн,

мөн хангамжийг нь харьцангуй сайжруулсан. Соёл, урлагийн салбарт харилцан хамтран ажиллах боломжуудаа тогтоод явж байна. Спортын салбарын хувьд нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр хийж буй ажлуудаа үргэлжлүүлэн хийнэ. Аялал жуулчлалын компаниуд маань энэ жилийн хувьд үр дүнгээ үзэж эхэлж байгаа. Жуулчдад зориулсан арга хэмжээнүүд маань тогтсон цаг, хуваарьтай болж эхэллээ. Наадмыг зөвхөн долоодугаар сард үзэх биш Даншиг наадмыг энэ жилийн наймдугаар сарын 8, 9-нд хийнэ. Өөрөөр хэлбэл, зохицуулалт хийгээд ирэхээр жуулчдыг татах өөр арга хэмжээг үе шаттай зохион байгуулах боломжтой болж байгаа гэсэн үг. Ер нь бол манай нийгмийн салбар илүү сайн төлөвлөгөөтэй болж байгаа. Засаглалын хувьд ч тэр, бид зөвхөн арга хэмжээнээс гадна арга ажиллагааны засаглалын асуудалд анхаарч байна.

**-Иргэд ирэх жил олон нийтийг хамарсан ямар үйл ажиллагаанд оролцох боломжтой вэ?**

-Жуулчдад гэж байгаа боловч нийгмийн хөгжил хариуцсан гэдэг талаасаа иргэдэд, улаанбаатарчуудад зориулсан арга хэмжээнүүд шүү дээ. Манай иргэд идэвхтэй, сонирхолтой, үзэж харах юмтай гэдгийг тэр жуулчид үзэх гэж ирнэ. Бидний хэрэгжүүлж буй хөтөлбөр иргэдэд л хамгийн их нээлттэй байна.

**-Нэмж хэлэхэд?**

-Нийслэл Улаанбаатар хотод хийгдэж буй хөрөнгө оруулалт, ялангуяа дэд бүтэц, инженерийн дэд бүтэц, зам харилцаа бий болгоно гэдэг нь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн асуудал. Амьдралын чанараа дагаад эрүүл мэнд, эрүүл ахуйн байдал сайжирна. Хийгдэж буй хөрөнгө оруулалтын дийлэнх нь тэдгээр зүйлст чиглэж байна гэдэг нь шийдвэрлэх тэргүүний асуудлууд тэнд байна гэсэн үг. Гэхдээ үүний хажуугаар орхигдуулахгүй явах ёстой асуудлууд нь нийгмийн дэд бүтэц буюу боловсрол, эрүүл мэнд, соёлын үйлчилгээг сайжруулах.

Хүн болгон сайхан амьдрахын төлөө явдаг. Ингэхийн тулд нийгмийн хөгжлийн асуудлуудаа анхаарч явах шаардлагатай. Үүний төлөө бүгдээрээ хамтдаа зүтгэх ёстой. ■

# Нийслэлийн нийгмийн хөгжил

Гэрт амьдардаг

/Мянган өрх/

2012 онд 83.8

2013 онд 88.6

2014 онд 93.5

Байшинд амьдардаг

/Мянган өрх/

2012 онд 103.3

2013 онд 106.4

2014 онд 108.8

Орон сууцанд амьдардаг

/Мянган өрх/

2012 онд 126.3

2013 онд 126.3

2014 онд 147.4

Улсын цэцэрлэг

178

Хувийн цэцэрлэг

250

Улсын сургууль

114

Хувийн сургууль

89

Улсын эмнэлэг

22

Хувийн эмнэлэг

1200


Эх сурвалж:

Нийслэлийн статистикийн газар

ХОТЫН ЦАГДАА

## Амар тайвныг сахигчид

Ц.Буян



Улаанбаатар хотод 3200 гаруй цагдаагийн албан хаагч ажилладаг. Засгийн газрын 2011 оны 131 дүгээр тогтоолоор нэг албан хаагчдад ногдох нормативийг баталж өгчээ. Энэ нормативийг мөрдөхийн тулд одоо байгаа бие бүрэлдэхүүн дээр 1600 орчим албан хаагчийг нэмэх шаардлагатай аж. Ажлын ачаалал өндөр байх нь нэг талаас гол зорилго иргэддээ хүрч үйлчилж чадахгүй, нөгөө талаас албан хаагчдад учирч болзошгүй эрсдэл нэмэгдэж байгаа юм.

Засгийн газрын тогтоол хэрэгжихгүй байгаа нь Засгийн газартай холбоотой. Улаанбаатар хотын Цагдаагийн байгууллагуудад батлагдсан төсөвт орон тоо 100 хувь хангагдсан. Орон тоогоо нэмье гэхээр цалингийн сан нь хүрэлцдэггүй учраас ямар ч боломжгүй. Цагдаагийн байгууллагын төсөв Хууль зүйн сайдын багцаас санхүүждэг. Харин нэг давуу тал нь “Улаанбаатар хотын” гэх статустай учраас Нийслэлийн Засаг даргын тамгын газар санхүүжилтийн нэг эх үүсвэр болж өгдөг. Засаг даргын тамгын газраас ажиллах орчныг бүрдүүлэх, албан хаагчдын ахуй амьдралыг дээшлүүлэх, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах тал дээр туслалцаа үзүүлдэг байна. Энэ жил гэхэд 4.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Үүнээс 1.9 тэрбум төгрөгөөр Улиастайн эцсийн буудал дээр, гэр хорооллын дунд Баянзүрх дүүргийн цагдаагийн гуравдугаар хэлтсийн байрыг барихаар тендер зарлаад байгаа аж. Мөн гудамж, талбайд гарч байгаа бүх албан хаагч нэг бүрийн хамгаалах хэрэгслийг шийдсэн. Наадмаас өмнө хотын цагдаа нарын гарт очихоор болжээ. “Гэвч бүх асуудлыг шийдэхэд төсөв, санхүү хангалттай

биш. Цаашид тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлага бий” хэмээн Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга Ч.Болдбаатар тэрбээр хэлсэн юм. Одоогийн байдлаар цагдаагийн албан хаагчийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалах бүх хэрэгслийг Нийслэлийн Засаг даргын хөрөнгөөр хэрэгжүүлж байна.

Цагдаа нарын нийгмийн байдал тийм ч сайнгүй. Замын хар зуны наранд хөл дороос нь тэсэхийн аргагүй халж, өвөлдөө яаж хайрдгийг замын цагдаа нараас өөр мэдэх хүн ховор. Доороосоо халж, хөрснөөс бөөр нь өвчилсөн цагдаа олон аж. Энэ нь таргалалтын шалтгаан болно. Гэтэл олон нийтийн дунд бий болсон түгээмэл ойлголт нь “цагдаа нар их иддэг” гэнэ. Гав, бороохойгоос бусдаар хангамж гэхээр зүйл үгүй. Гурван жилийн эдэлгээ даах ёстой дүрэмт хувцас нь нар, салхинд амархан гандаж, элэгдэнэ. Тиймээс хувь хүнд хандаж захиалгаар хийлгэх хэрэгтэй болдог. Хангалтаар тавьж өгдөг борооны цув нь шиврээ бороо нэвтэрчихнэ. Ачаалал ихтэй тул амралтгүй шахам ажилладаг тэдэнд цалингаас өөр урамшуулал, хоол унааны мөнгө гэж олгодоггүй. Илүү цагийн цалин бодохгүй. Үндсэн цалин нь ч тийм өндөр биш ажээ.

“Цаашдаа албан хаагчдын эрүүл мэнд болон, амьдралын баталгааны асуудлыг шийдэх чиглэлд анхаарч ажиллана. Жишээлбэл, найман хувийн хүүтэй орон сууцны зээлд хөнгөлөлттэй хамруулах боломж НИТХ-аас баталсан “Төрийн албан хаагчдад орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд баримтлах журам”-ын хүрээнд бий болоод байна. Гэхдээ хөрөнгө санхүүгийн хувьд олон хүнийг

хамруулах бололцоо одоогоор хомс” хэмээн Ч.Болдбаатар дарга ярьсан юм.

Гэхдээ ажил урагшилж, ахиж дэвшиж байгаа аж. Асуудал, бэрхшээл бишгүй байгаа ч боломж, нөөцдөө тулгуурлан хотын цагдаа нар ажил үйлээ амжилттай үргэлжлүүлж яваа гэнэ. Сүүлийн үед “Сайн хөршийн холбоо” гэж юу болох тухай олон нийт мэдээлэлтэй болсон аяны хүрээнд зохион байгуулагдаж байсан ажил өргөжиж хөтөлбөр болон хэрэгжих гэж байгаа юм. Өнөөдөр томоохон гудамж, талбайд нэлээд сайн камержсан. Одоо орц, иргэдийн гэмт халдлагад өртөх магадлалтай харанхуй орчныг гэрэлтэй болгох, камерын хяналтад оруулах ажлыг хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах юм байна. Угаасаа хүн хүч муутай байгаа цагдаагийнхандаа иргэд нь өөрийн чадал хэрээрээ дэм болж, хажуу хавирганыхаа айл өрхийн аюулгүй, амар тайван байдалд санаа тавьдаг байх нь хотын амьдралын шаардлага болоод байгаа юм.

Өнөөдөр цагдаа нарын харилцаа, хариуцлага ч өөр болжээ. Энэ талаар иргэд ам сайтай байгаа гэнэ. Улаанбаатарын Цагдаагийн газраас боловсон хүчнээ илүү мэдлэг боловсролтой албан хаагчдаар бүрдүүлэх бодлого барьж байгаа юм байна. Учир нь иргэдийн зүгээс ирдэг шүүмжлэл нь цагдаагийн албан хаагчийн харилцааны соёл, сургалт дадлага, мэдлэг боловсрол гэсэн үндсэн гурван асуудал байдаг аж. Давтан сургалтын төвөөрөө тодорхой түвшний албан хаагч жилд хэдэн кредит цагийн сургалтад хэдэн удаа хамрагдах ёстойг тодорхойлж, албан хаагчдыг чадавхжуулах ажил байнга зохион байгуулж байгаа аж. ■



## Хүний төлөө

Ц.Сайханаа

Э.Өнөболд Баянгол дүүргийн Замын цагдаагийн тасагт ажилладаг. Арван жил төгсөөд л цагдаа болохоор шийдэж цэргийн албаас цагдаагийн албанд шилжсэн нэгэн. Тухайн үед цагдаагийн албан хаагчийг эхлээд цэргийн албанд сургадаг байжээ. Одоо тэр 27 настай.

### 11:00 - АЖИЛ ЭХЭЛЛЭЭ

Энэ өдөр Э.Өнөболдын ажил 11:00 цагт эхэллээ. Ерөөс замын цагдаа нар өдөр (07:00-15:00), орой (15:00-22:00), шөнийн (22:00-07:00) ээлжээр ажил үүргээ гүйцэтгэдэг. Зочин маань эдгээр цагийн хуваарийн дагуу өдөр тутмын ажлаа хийдэг. Тэрбээр өнөөдөр 15:00 цагаас албандаа гарах хуваарьтай. Гэхдээ өнөөдрийн хувьд өдөр тутам гүйцэтгэдэггүй чухал үүрэгт ажилд томилогдсон нь энэ. Мьянмарын холбооны бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч У Тейн Сейний манай улсад хийсэн төрийн айлчлалын хамгаалалтад замын хөдөлгөөний зохицуулалтад оролцож байгаа юм.

Хөтөлбөрийн дагуу Мьянмарын Ерөнхийлөгч 14:00 цагаас Гандан хийдээр зочлох төлөвлөгөөтэй байв. Тиймээс тэр орчмын замын хөдөлгөөнийг зохицуулж, зочид төлөөлөгчдийг зорчиход саадгүй болгох үүрэг Баянгол дүүргийн Замын цагдаагийн тасагт ногджээ.

### 15:00 - САЙХАН СЭТГЭЛ

Гандан хийд рүү орох зам руу ордог гудамж, зам, уулзвар бүрийг нэг цагдаа зохицуулан зогсоно. Үдийн нарны илч ид төөнөж, ихээхэн халуун болоход зочид хөтөлбөрт

цагаасаа хоцорч байв. Нар эгц дээр яваа тул сүүдэр ч үгүй. Э.Өнөболд нөхдийнхөө адил хариуцсан гудамжаа хамгаалан зогссоор л байлаа. Энэ үед аав нь хүүгээ тэвэрсэн, бүсгүй нь хүүхдийн тэрэг түрсэн залуу хос чиглэн ирлээ. Тэргэндээ жижиг савтай цэвэр уснууд хийчихсэн хамгаалалтад зогсоо цагдаа нарт тарааж өглөө. Сэвэлзэх төдий ч салхигүй бөгчим халуунд ангасан цагдаа нар тэр залуу хосод чин сэтгэлээсээ талархсан нь мэдээж.

Төлөвлөгөөт цагаасаа хождо буй гийчид 16:15 цагийн орчимд дараагийн болзоот газар Хүйн долоон худгийг зорив. Тэдний зорчих замыг чөлөөлж мордуулснаар Гандан дахь хамгаалалт дуусав. Ингээд дараагийн цэг рүү хөдөллөө.

### 16:30 - ЗАМД БОЛСОН ЯРИА

Эндээс дараагийн хамгаалалтад гарах цагдаа нар Яармагийг зорилоо. Тэдний дотор Э.Өнөболд багтжээ. Хүйн долоон худагт бэсрэг наадам үзсэн гийчдийн буцах зам мөн саадгүй байх ёстой. Ингээд зам зуур түүний ажлын талаар жаахан ярилцах боломж гарсан юм.

#### -Энгийн өдрүүдэд ажил чинь хэрхэн өрнөдөг вэ?

-Хуваарийнхаа дагуу шууд уулзвар дээрээ очдог. Өглөө, орой ачаалалтай үед болон гэрэл дохио ажиллахгүй тохиолдолд зохицуулалт хийнэ. Мэдээж зөрчил гаргасан жолооч нарт хариуцлага тооцно.

-Жолооч нарын хамгийн их гаргадаг зөрчил юу вэ. Өдөрт ойролцоогоор хэдэн зөрчил илэрдэг бол. Жолооч нар бас янз бүр л авир гаргадаг байх даа?

-Хамгийн их гаргадаг зөрчил гэвэл хамгаалалтын бүс хэрэглэхгүй байх, замын хөдөлгөөнд оролцож байхдаа гар утсаар ярих, гэрэл дохио зөрчих. Зөрчил илрэх тухайд янз бүр л дээ. Дунджаар өдөрт ойролцоогоор 30-40 орчим. Жолооч нарын хувьд зөрчил гаргачихаад “Сүртэй юм бэ дээ, сануулаад л өнгөрчих л дөө” гэдэг. Гэтэл хууль номондоо сануулах гэдэг заалт байхгүй. Торгох, эрхийг нь хасахаас өөр аргагүй. Сануулга гэдэг чинь цэргийн сахилгын дүрэмд л байдаг зүйл шүү дээ.

**-Иймэрхүү хамгаалалтад гарах өдрүүд хэр олон тохиодог вэ?**

-Бүх л айлчлал, дээрээс наадам, цагаан сар гээд олон нийтийн баярын өдрүүдээр хамгаалалтад гарна. Наадмаар гэхэд 10-ны өдрөөс Хүйн долоо худагт морины уралдаан эхэлдэг. Гэтэл цагдаагийн байгууллагад хүн хүч дутагдалтай байдаг болохоор цагдаа нар бүгд уртасгасан цагаар хамгаалалтад зогсоно. Цагаан сараар хүмүүс өглөө эрт аав ээжтэйгээ золгох гэж яардаг бол замын цагдаа нар тэднээс өрсөж ажил руугаа яарна шүү дээ.

**-Дараа нь амралтаа нөхөж авдаг байлгүй дээ. Ер нь ажлын ачаалал ямар байдаг юм. Амралт хэр олддог вэ?**

-Ажлын ачааллын хувьд асар өндөр. Норматив нь нэг цагдаад 250 тээврийн хэрэгсэл ногдох ёстой. Гэтэл манайд 1000-1500 ногддог гээд боддоо. Долоо хоногтоо нэг өдөр амарна. Гэхдээ амрахынхаа урьд өдөр нь заавал өглөөнөөс орой хүртэл 16 цаг ажилладаг. Ингэж бусдадаа бас амрах цаг гаргаж өгч байгаа юм. Баярын амралтыг дараа нь нөхөж олгодог л доо. Гэхдээ бүгдийг нь амраачихаж болохгүй шүү дээ. Нэг хэсэг нь амрахад үлдсэн нь уртасгасан цагаар ажиллах хэрэгтэй болно.

**-Анх автомашиныг дугаарын хязгаарлалтай болгоход та нар их ачаалалтай байсан байх?**

-Тэгэхэд гурван сарын турш бүх замын цагдаа өдрийн 16 цаг ажилласан шүү.

**-Ажлын тань сайн, сайхан зүйл юу вэ?**

-Бид чинь бүх хүний сайн сайхны төлөө л ажиллаж байгаа хүмүүс. Хүнд тустай ажил хийж байгаа шүү гэж бодохоор сайхан байдаг юм.

Жолооч нарыг торгож, хариуцлага тооцож байгаа нь тэдний өөрсдийнх нь сайн сайхны төлөө. Жолооч хамгаалалтын бүсээ зүүгээгүйн улмаас торгууллаа ч тэр хүнд учирч болох эрсдэлээс сэргийлж байгаа хэрэг. Магад тэр хүн түүнээс хойш байнга бүс хэрэглэж хэвших ч юм бил үү. Согтуу жолоочид хариуцлага тооцож байгаа нь эцсийн зорилго нь бусад жолоочийн, явган зорчигчдын, хотын иргэдийн аюулгүй байдлын төлөө. Жолооч нар үүнийг ойлгодог болчихвол бидний харилцаа их хялбар болно доо.

### 17:00 - АМС ХИЙХ БОЛОМЖ

Бид явсаар очих газартаа хүрлээ. Хүйн долоон худгийг зорьсон эрхмүүд буцах хараахан болоогүй байгаа учраас Э.Өнөболдод юм идэх цаг олдлоо. Өглөөнөөс хойш ийм боломж тохиогоогүй юм. Хуваариасаа хоцорч яваа гийчид маань харин энэ удаа санаснаас эрт замдаа гарчээ. 18:30 цагийн үед хүндэт зочид “Их тэнгэрийн ам”-ыг зорьсон юм. Ингээд Баянгол дүүргийн цагдаагийн тасгийнхны өнөөдрийн хамгаалалт дуусч байна. Харин Э.Өнөболдын хувьд ажил дуусаагүй. Түүний ажил 15:00 цагт эхэлж, 22:00 цагт дуусах ёстой. Тиймээс эндээс зохицуулалт хийх уулзвар руугаа явах юм.

### 19:00 - ГЭР РҮҮГЭЭ

Уулзвар руугаа явахын өмнө даргаас өгөх зааварчилгааг хүлээж байлаа. Мьянмарын эрхэм Ерөнхийлөгч маргааш өглөө 07:00 цагт буцах тул өглөө эрт энэ газраа дахин хамгаалалтад зогсох тул Э.Өнөболдыг амрахаар болжээ. Учир нь маргааш тэр мөн л оройн ээлжинд ажиллах хуваарьтай тул уртасгасан цагаар өдөржин ажиллах болж байгаа юм. Тэр одоо гэр рүүгээ, гэргий хүүхэд рүүгээ яаран явлаа. ■



Э.Өнөболд ажил үүргээ гүйцэтгэж буй нь



## Ч.Болдбаатар: Цагдаагийн ажлыг иргэд сайнаар үнэлдэг болж

Ц.Элбэг

*Монгол Улсын хүн амын тэн хагас нь нийслэлд амьдардаг нь хотын цагдаа нарыг өндөр ачаалалтай ажиллахад хүргэдэг. Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга Ч.Болдбаатарыг гурван асуулт буланд урьсан юм.*

**-Улаанбаатар хотын цагдаагийн байгууллагын онцлог юу вэ. Ямар асуудал тулгамдаж байна вэ?**

-Тулгамдаж буй хамгийн гол асуудал нь хүн хүч дутмаг байдал. Улаанбаатар хотын цагдаа есөн дүүрэгт 17 хэлтэстэй. Цагдаагийн албаны тухай хуулиар нутаг дэвсгэрийн зохион байгуулалттай учраас ингэж зохион байгуулж байна. Энэ нь цагдаагийн үйлчилгээг захын болон төвийн хорооллуудад жигд хүрч үйлчлэхэд чиглэж байгаа юм. Энэ үүднээс дүүргүүдэд цагдаагийн хоёр болон гуравдугаар хэлтсүүдийг захын хорооллуудад байгуулж, тэнд нь ажлын байр, хамгаалах хэрэгслээр хангаж байгаа. Хэсэг нь дотроо дэд хэсгүүдэд хуваагддаг. Дэд хэсгүүд нь хорооны зохион байгуулалтад орж хэсгийн цагдаа, хэсгийн байцаагч томилж ажиллуулж байна. Одоогийн байдлаар 152 хороонд мөн тооны хэсгийн байцаагч, хэсгийн цагдаагийн орон тоотой үйл ажиллагаагаа явуулж буй. Хороодын хүн амын нягтаршил харилцан адилгүй. Ойролцоогоор 6-10 мянга байдаг. Ийм нөхцөлд хороо бүрт нэг л байцаагч ажиллах нь иргэддээ хүрч үйлчлэхэд бэрхшээлтэй байгаа. Цаашид хороо дээрх бүтцээ өргөжүүлж, орон тоогоо нэмж ажиллавал үр дүнтэй гэж харж байна. Яагаад гэвэл иргэдийн дунд орж, аюулгүй орчныг бүрдүүлэхэд хэсгийн байцаагч хамгийн

ойр ажилладаг юм.

**-Улаанбаатар хотын цагдаагийн газраас цаашид ямар ажил хийхээр төлөвлөж байна вэ?**

-Иргэдийн хүсдэг зүйл нь аюулгүй орчинд амьдрах. Энэ хүрээнд Улаанбаатар хотын цагдаагийн газар үйл ажиллагаагаа зохион байгуулж байна. "Хөршийн холбоодын хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Олон улсын томоохон хотуудад ийм төрлийн хөтөлбөр хэрэгжүүлсэн туршлага бий. Жишээлбэл, Лондон, Сөүл хотыг нэрлэж болно. Улаанбаатар хотод эдгээр хотын туршлагыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хийж эхэлсэн. Одоогоор хөтөлбөрийг боловсруулж НИТХ-аар батлуулахаар ажиллаж байна. Энэ асуудлаар Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг ажиллаад, Засаг даргын зөвлөлийн хурлаар хөтөлбөрийг баталчихаад байгаа. НИТХ-аар баталснаар хөтөлбөр хэрэгжих шатандаа орох юм. Зорилго нь иргэн болон цагдаагийн байгууллагын хамтын ажиллагаагаар амьдрах орчиндоо аюулгүй байдлыг бүрдүүлэх. Үүнд иргэдийн оролцоо нь цагдаагийн байгууллагад орчныхоо аюулгүй байдлын талаар мэдээлэл өгөх.

Хөрш айлтайгаа харилцаа холбоотой байж харилцан аюулгүй байдалдаа хяналт тавих. Улаанбаатар хотод гарч байгаа нийт гэмт хэргийн 50 орчим хувь нь хулгай, 60 орчим хувь нь согтуугаар үйлдэгдсэн байдаг. Хөтөлбөр хэрэгжсэнээр энэ тоо, хувь багасна гэж харж байгаа.

**-Хотын цагдаа нарын нэр хүнд өнөөдөр ямар байна вэ. Иргэд хэрхэн үнэлж, дүгнэж байгаа бол. Хэрэгжүүлж буй ажлын үр дүн мэдрэгдэж байна уу?**

-Цагдаагийн байгууллагыг голчлон "өргөдөл гомдлын шийдэгдэх хугацаа урт байна, дутуу шалгаж байна, хэрхэн шалгасан тухайгаа болон, үр дүнгээ буцааж мэдэгдэхгүй байна" гэж шүүмжилдэг. Эдгээрийг шийдэхийн тулд бид өгсөн, дуудлага гомдол бүрийг шалгаж, хариу мэдээлдэг системийг бий болгож байгаа. Ингэхдээ заавал тухайн иргэнтэй уулзаж ярилцдаг хуучин арга барилыг халсан. Эхлээд дуудлага, гомдлын хуудсын дагуу шалгаж, дараа нь ажилласан байдлаа иргэнээр дүгнүүлдэг болсон. Шалгалтын дагуу ямар арга хэмжээ авсан, хэрхэн шийдвэрлэсэн тухайгаа орчин үеийн холбоо харилцааны дэвшлийг ашиглаж вэбсайт, гар утас, мессеж ашиглан иргэнд буцаад мэдээллэж байна. Үр дүнгүүд гарч иргэд ч нааштай хандаж байгаа. Цагдаагийн шуурхай утас 102 дугаарт өнгөрсөн жил ирсэн 540 мянган дуудлагад газар дээр нь очиж үүрэг гүйцэтгэсэн. Энэ нь өмнөх жилээсээ 3.4 хувиар өссөн үзүүлэлт. Хөдөлгөөнт эргүүлүүд дуудлага өгснөөс хойш 5-15 минутад хүрч үйлчилдэг болсон. 102 дугаар болон бусад техник хэрэгслээ шинэчилснээр үйл явцыг хянах боломжтой болсон юм.

Эрсдэлийг бууруулах болон бусад чиглэлийн судалгааг ЦЕГ-ын дэргэдэх судалгааны төв хийдэг юм. Ерөнхийдөө цагдаа нарын хууль хэрэгжүүлэх байдал, харилцааны чадвар дээр их шүүмжлэл гардаг. Сүүлд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс иргэд цагдаагаас яг юу хүсч байна вэ гэдгийг судалсан. Үүнээс харахад олон шүүмжлэл байгаа ч, цагдаагийн ажлыг иргэд өмнөхөөсөө сайнаар үнэлдэг болж гэж дүгнэхээр байна. ■

# Шийдэл

Г.Орхон



Монгол Улсын эрүүл мэндийн салбар салаа замын зааг дээр ирчихээд байна. Өнгөрсөн хугацаанд туулж ирсэн замаараа явах уу,свэл дэлхийн нийтийн зүглэж буй хөгжлийн шинэ замд гарах уу. Үүнийг төр шийдэх учиртай. Гэвч эл салбарт төрийн халамж үгүйлэгдэж буйг салбарынхан хэлж байна. Нэг үгээр эрүүл мэнддээ анхаардаг засаг бий гэдэгт олон хүн эргэлзэх болж.

Хөгжингүй орнууд эрүүл мэндийн салбартаа дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 10-15 хувийг зарцуулдаг байна. Ингэж байж тэгш,чанартай, хүртээмжтэй эмнэлгийн тусламжийг иргэдэд үзүүлж байгаа. Гэтэл манайх хоёрхон хувийг зарцуулчихаад чанартай,хүртээмжтэй эмнэлгийн тусламж үзүүлье гэх нь өрөөсгөл.

Энэ онд Улаанбаатар хотын иргэн 1.5 саяд хүрчээ. Энэ нь манай улсын хоёр иргэний нэг нь нийслэлд амьдардаг гэсэн үг. Гэтэл хотын дүүргийн эмнэлэг, амаржих газрууд урьд тооцсон 500 мянган хүн амтай байх үеийн хүчин чадлаараа байна. Сүүлийн 25 жилд улсын төсвөөр нэг ч амаржих газар,дүүргийн эмнэлгийг шинээр босгоогүйг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга ярилаа. Гэтэл хүн амын тоо өмнө тооцоолсноос гурав дахин нэмэгдчихэж.

Дулмаа эмээ улсын нэгдсэн болон дүүргийн эмнэлгүүдэд биеэ үзүүлэх гэж бараг долоо хоног эмнэлгийн үүд сахина. Энэ бол өнөөгийн хотын эмнэлгийн байгууллагын наад захын асуудал, хамгийн нийтлэг дүр зураг.

Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Ш.Энхбат “Хэдэн жилийн өмнө төсөв мөнгөө юунд зарцуулахаа мэдэхгүй л явлаа шүү дээ. Тэгэхээр ганцхан мөнгө дутсан учраас Улаанбаатар хотод эмнэлэг байгуулаагүй биш. Энэ бол бодлогын алдаа гэж хэлэхээс өөр аргагүй. Хүний тоо өсөхөөр хүнс нэмэгддэг биз дээ” хэмээв. Харин энэ оноос эхлэн улсын төсвөөс нийслэлд хүүхдийн гурван эмнэлэг шинээр барихаар болжээ.

Мөн 2015 онд Нийслэлийн Эрүүл мэндийн газрынхан Азийн хөгжлийн банкны тусламжтайгаар Сонгинохайрхан дүүрэгт эмнэлэг байгуулахаар төлөвлөж. Оношилгооны болон шүдний төв барих, Налайх дүүргийн Нэгдсэн эмнэлгийг концессын гэрээгээр барих зэрэг хэд хэдэн бүтээн байгуулалт хэрэгжих нь.

Манайд зориулалтын дүүргийн эмнэлэг нэг ч байхгүй бөгөөд өмнө нь зочид буудал, конторын зориулалтаар ашиглаж байсан барилга л ногддог байна. Тиймээс энэ

салбар дандаа үлдэгдэл хэлбэрээр санхүүжиж явсныг Ш.Энхбат учирласан. Тэрбээр “Өнөөдөр эрүүл мэндийн асуудлыг Сангийн яам шийддэг юм шиг болчихоод байна. Энэ онд Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмийн төсвийг гэхэд өнгөрсөн оныхоос 30 хувиар бууруулсан” гэлээ. Улсын хүн амын тоо гурван саяд хүрч,анх удаа 81700 шинэ иргэн төрж,үүний 41 мянга нь нийслэлд мэндэлсэн.

Их хотын хүн ам 41 мянгаар нэмэгдэж байхад өмнөх оныхоос төсвийг нь хасна гэдэг хүнд асуудал. Гэтэл үүний дүнд ихэнх эмнэлэг эмийн өртэй болоод байгаа аж. Эл асуудлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрынхан дөрөвдүгээр улирлын эмийн төсвийг тав, зургаа, долдугаар сар руу татаж байж шийдэж байгаа гэнэ. Тэгэхээр ирэх есөөс арванхоёрдугаар сарын хооронд дахин эмийн өр үүснэ гэсэн үг. Мөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн төсвийг дөрөв дахин танасан. Ийм нөхцөлд Нийслэлийн харьяа эрүүл мэндийн 22 байгууллагын өнөөгийн тааруухан үйлчилгээг тэнд ажиллаж буй эмч,ажилтнуудад тохих нь учир дутагдалтай. Өөрөөр,тариачин Батад тармуур,хадуур нь байхгүй бол Бат тариагаа яаж тарих билээ.

Хэдэн жилийн өмнө эрүүл мэндийн салбарыг эдийн засагт нөлөө үзүүлдэггүй салбар гэж үздэг байжээ. Харин одоо эрдэмтэд энэ салбар нь эдийн засагт шууд бус нөлөөлдөг гэж буй. Хүн эрүүл биш бол эдийн засгийн бэхжүүлж,өсгөнө гэх ойлголт байхгүй байх нь. Монгол Улсын иргэн бүр өвчтэй,хөдөлмөрийн чадвар муу байвал яаж эдийн засаг өсөх билээ. Тиймээс л эл салбарыг төрийн зүгээс нэгдсэн бодлогоор дэмжих хэрэгтэйг эрүүлийг хамгаалах байгууллагад олон жил ажилласан эмч нар хэлж байна. Энэ бодлого нь Засгийн газар, сайд, дарга нар солигдоход үл хөдлөхүйц эрүүл мэндийн салбарын хөгжлийн жанжин шугам байх ёстой аж.

Ш.Энхбат “Монгол Улсын эрүүл мэндийн салбарт аль ч намаас хамаарахгүйгээр хөгжих алсыг харсан бодлого байх ёстой. Бодлого байнга өөрчлөгдвөл энэ салбар хөгжихгүй. Энэ онд манай газрын гаргасан уриаг Эрүүл мэндийн яам дэмжиж “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг сайжруулья” гэх нэгдсэн ойлголтод хүрч энэ чиглэл рүү явж байна” гэсэн. Уг бодлого нь салбарын суурь буй өрхийн эмнэлгийн хүртээмжийг сайжруулснаар хоёр, гуравдугаар шатлалын эмнэлгийн ачааллыг багасгахад чиглэж байгаа юм.

Үүний тулд тус төвийг хөрөнгөөр хөшүүрэгдэж үйлчилгээг нь сайжруулах гэнэ. Өдгөө өрхийн эмнэлгийн санхүүжилт нэг иргэнээр тооцсон санхүүжилт байдаг аж. Нэг иргэний эмчилгээний зардлыг 11 мянган төгрөгөөр тооцож буй. Үүний 80 хувь нь тухайн өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж буй хүмүүсийн цалин, цахилгааны мөнгө зэрэгт зарцуулагдана. Үлдсэн 20-хон хувь нь эмнэлгийнхээ тусламжид зарцуулагддаг гэнэ. Нийслэлийн Эрүүл мэндийн газраас өрхийн эмнэлгийн санхүүжилтийг сайжруулахын тулд өрхөөр үзүүлж байгаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ганцхан төсвийн буюу нэг иргэнээр тооцсон биш эрүүл мэндийн даатгалд нь суутгуулжээ. Өрхийн эмнэлгийн эмч нар гэрийн бөгөөд өдрийн үйлчилгээндээ эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авах боломжийг нь нээж байгааг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга хэлэв. Мөн нэг иргэнээр тооцож буй 11 мянган

эмнэлэг хөгжихгүй байна. Нийслэлд хувийн хэвшлийн нийт 1200 эмнэлэг, эмнэлгийн байгууллага байгаа бөгөөд эдгээрийн 60 гаруй хувь нь дотор, уламжлал, эмэгтэйчүүд гэх гуравхан чиглэлийнх. Угтаа ачаалал ихтэй байгаа гэмтэл, төрөхийн зэрэг бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эмнэлэг олноор “төрвөл” дэмтэй. Гэвч хувийн хэвшлийнхэн төрөх, үхэхийн зааг дээрх, хүний амь нас эрсдэх эрсдэл өндөртэй чиглэлд хөл тавихыг төдийлэн хүсдэггүй аж. Түүнчлэн үүнийг төрөөс хууль, эрх зүйн зохицуулалт хийж өгөх хэрэгтэй Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга ярилаа.

Нийслэлчүүдийн эрүүл мэнд доройтолд ороод буйг салбарынхан анхааруулсаар. Хотын Эрүүл мэндийн газрын дарга энэ нь буруу бодлогын үр дүнг тодоор харуулж байгаа хэрэг гэсэн. Төрөөс энэ салбарт хөрөнгө зарж оновчтой, урт хугацааны бодлого хэрэгжүүлэх үр цацаж байж иргэд эрүүл



төгрөгийг 16 мянга болгохоор холбогдох албаныхантай ярилцаж байгаа аж.

Хүн бүрийг хоёр, гуравдугаар шатлалын эмнэлэгт хэвтүүлэх шаардлагагүй бөгөөд хотод эмнэлэгт хэвтэж байгаа хүний 30 хувь нь эмнэлэгт хэвтэх шаардлагагүй байгааг судалгаагаар тогтоожээ. Өрхийн эмнэлгийн үйлчилгээний хүртээмж сул, бодлого буруу байгаагаас үүдэн иргэдийн сэтгэлгээ хүртэл буруу тийш хазайжээ. Уг нь хүн эрүүл байж, эмнэлэгт хэвтэхгүй юмсан гэж боддог. Гэтэл манайхан яаж ийж байгаад нэг эмнэлэгт хэвтэж, шингэн хийлгэх зэргийг урьдач болгож байгаа нь үнэн. Улаанбаатар хотод буй 142 өрхийн эмнэлэг хөл дээрээ тогтож чадвал иргэд гэрийнхээ дэргэдэх эмнэлэгтээ үзүүлдэг болж, дээр дурьдсан Дулмаа эмээ хэдэн өдрөөр эмнэлгийн үүд сахих хэрэг юуных. Өнөөдөр манайд хувийн

мэндийн доройтлоос гарч, салбар цэцэглэнэ. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Ш.Энхбат “АНУ өнөөдөр нэг иргэндээ 8500 ам.доллар зарцуулж байна. Манайх үүнээс зуу дахин бага буюу дунджаар 82 ам.доллар зарцуулж байна. Үүний ихэнхийг цахилгаан, эрчим хүч тэргүүтэй өөр зүйлд зарцуулдаг” гэв. Хүний эрүүл мэндийн асуудлын 10-20 хувь нь эрүүл мэндийн байгууллагаас хамаардаг гэж үздэг. Бусад нь хувь хүн хийгээд төрийн үйл ажиллагаас мөн хамаарна. Гэхдээ эл салбар нь улстөрөөс хамгийн хол байлгах ёстойг албаныхан учирлаж байна.

Ш.Энхбатын хэлсэнчлэн цаашид эл салбарыг хөгжүүлэхийн тулд шинэ зам зохиож, түүгээр явах шаардлагагүй. Харин бусад орны яваа замаар явах ёстой аж. Үүний шийдэл нь урт хугацаанд хэрэгжих зөв бодлого. ■

## Ш.Энхбат: Эрүүл мэндийн салбар үргэлж үлдэгдэл хэлбэрээр санхүүжиж ирлээ

Г.Орхон



*Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Ш.Энхбаттай ярилцлаа.*

**-Нийслэлчүүдийн хувьд уушги,чихрийн шижин тэргүүтэй өвчин мундахгүй. Нэг үгээр, хотын иргэд эрүүл мэндийн доройтолд орчихоод байна. Үүний шалтгааныг та юу гэж харж байна вэ?**

-Бодлого нь буруу бол хэрэгжилт нь сайн байхгүй гэдгийг тод хариулж байгаа хэрэг. "Та хэдий хэмжээний мөнгө төлнө, төдий хэмжээний үйлчилгээ авна" гэх Орос үг бий. Тийм учраас Африкийн орон шиг мөнгө зарцуулчихаад Япон шиг тусламж, үйлчилгээ үзүүл гэвэл хэзээ ч бүтэхгүй. Иргэдийнхээ төлөө мөнгө хаяж байж тэдний эрүүл мэндийн үзүүлэлтийг сайжруулна уу гэхээс мөнгө хаяхгүйгээр зах зээлийн урсгалаар явна гэж болохгүй.

**-Манай улсын нийт хүн амын тэн хагас нь нийслэлдээ амьдарч байна. Гэтэл эмнэлгийн хүрэлцээ хэр байна вэ?**

-Улаанбаатар хотын иргэн өнөөдөр 1.5 саяд хүрлээ. Монгол Улсын хоёр иргэний нэг нь нийслэлд байна шүү дээ. Тэдний 10 гаруй хувь нь бүртгэлгүй иргэд байдаг. Гэтэл дүүргийн эмнэлэг, амаржих газрууд 500 мянган хүн

амтай байх үеийн хүчин чадлаараа л байна. Төрөөс 25 жил болоход нэг ч амаржих газар, дүүргийн эмнэлэг шинээр босгоогүй. Тэгсэн атлаа хүн ам нь гурав дахин нэмэгдчихсэн байдаг. Хэдэн жилийн өмнө бид төсөв мөнгөө юунд зарцуулахаа мэдэхгүй л явлаа шүү дээ. Тэгэхээр ганцхан мөнгө дутсан учраас Улаанбаатар хотод эмнэлэг байгуулагдаагүй гэж ойлгож болохгүй. Энэ бол бодлогын алдаа гэж хэлэхээс өөр аргагүй. Хүн нэмэхээр хүнс нэмэгддэг. Ийм том хотод зориулалтын дүүргийн эмнэлэг нэг ч алга. Бүгд зориулалтын бус байртай. Ер нь энэ салбар дандаа үлдэгдэл хэлбэрээр санхүүжиж явлаа. Өнөөдөр эрүүл мэндийн асуудлыг Сангийн яам шийддэг юм шиг болчихоод байна. Бүх хөрөнгийг нь Сангийн яам шийдэж, төсвийг нь хасаж, танадаг.

Энэ онд Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын эмийн төсвийг өнгөрсөн оныхоос 30 хувиар бууруулсан.

Энэ жил хүн амын тоо гурван сая давлаа. Анх удаа 81700 шинэ иргэн төрлөө шүү дээ. Үүний 51 мянга нь Улаанбаатар хотод төрсөн. Нийслэлийн хүн ам 51 мянгаар нэмэгдэж байхад төсвийг нь өмнөх оныхоос хасаж болохгүй. Дээр нь хөдөө орон нутгаас олон хүн ирж байна. Эцсийн дүнд өнөөдөр бүх эмнэлэг эмийн өртэй болчихлоо. Монголын эхчүүд орчин үеийн боломжийн, тохилог, эмнэлэгт очерлохгүйгээр хүүхдээ төрүүлэхийг хүсч буй. Үүнийг төр хариуцаж, нөхцлийг нь бүрдүүлэх ёстой. Хувийн хэвшил тийшээ орохгүй. Тэднийг оруулах нөхцлийг төр бүрдүүлж өгөх ёстой. Засаг өнөөдөр ажлаа хайнга хийж байна. Бодлого алга. Нийслэлийн Эрүүл мэндийн газар энэ оноос төсөвт суулган хүүхдийн гурван эмнэлэг шинээр барих гэж байна. Энэ нь 18 хүртэлх насныханд

зориулсан. Манайд 10-аас дээш настай хүүхэд эмчлүүлдэг хүүхдийн эмнэлэг гэж алга. Хүүхдийн эмнэлэг гэхээр нярайн, бүр бага насны хүүхдэд зориулсан эмнэлэг л байна.

**-Үүнээс гадна танай газраас энэ онд хийж, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудаас онцолвол?**

-Улаанбаатар хотод төсвийн мөнгөөр нэг ч эмнэлэг шинээр баригдаагүй нь яах аргагүй бодлогын хямрал. Эмч хүн эмнэлэг баръя гээд чадахгүй шүү дээ. Эрүүл мэндийн салбар алсыг харсан бодлоготой, түүнийгээ ягштал биелүүлдэг байх ёстой. Хүний эрүүл мэндийн асуудлын 10-20 хувь нь эрүүл мэндийн байгууллагаас хамаардаг гэж үздэг. Бусад нь төрийн бөгөөд байгууллагуудын үйл ажиллагаас хамаарна. Хүнсний болон эмийн аюулгүй байдал, агаарын бохирдлыг төр шийдэхгүй бол хувь хүн шийдэж чадахгүй. Тиймээс төрийн анхаарал, халамж чухал. Эрүүл мэндийн салбар нь улстөрөөс хамгийн хол салбар гэдгийг хүн бүр ойлгох ёстой. Мөн эмнэлгүүдийн бие даасан байдлыг бүрэн хангах ёстой. Шинээр "дугуй" бүтээх шаардлагагүй. Бусад орны явж буй зөв замаар явах хэрэгтэй.

Нийслэлийн Эрүүл мэндийн газраас гаргасан уриаг Эрүүл мэндийн яам дэмжээд "Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг сайжруулья" гэдэг нэгдсэн ойлголтод хүрээд, энэ чиглэл рүү явж байна. Монгол Улс өнөөг хүртэл энэ салбарыг барилга, байгууламж гэж үзвэл дээврээсээ эхэлж засч явлаа. Уг нь бол барилгын ажил сууриасаа эхэлдэг. Бид сууриас нь буюу өрхийн эмнэлгээс эхэлж байна. Нийслэлд байгаа 142 өрхийн эмнэлгийн хүртээмж сайжирвал хоёр, гуравдугаар шатлалын эмнэлгийн ачаалал эрс буурна. ■



ЭМЧИЙН ЗӨВЛӨГӨӨ

## Г.Бадамцэцэг: Хорхог, боодог идчихээд архи уувал үхэлд хүргэх аюултай

Г.Түшээ

Улсын наадам дөхсөн эдгээр өдөр нийслэлчүүд хөдөө явж амарч зугаалах нь эрс нэмэгджээ. Гэвч монголчууд бид амралт болон баярын үеэр ходоод гэдсээ хамгийн их ядрааж, зөв хооллох талаар төдийлэн боддоггүй. Тэгвэл хоол хүнсээ хэрхэн зөв зохицуулж амарч болох талаар Улсын нэгдсэн III төв эмнэлгийн Хоол боловсруулах эрхтэн судлалын тасгийн их эмч Г.Бадамцэцэгтэй ярилцлаа. Тэрбээр 1994 онд Анагаахын шинжлэх ухааны их сургуулийг дотрын эмч мэргэжлээр төгссөн бөгөөд уг мэргэжлээрээ 20 гаруй жил ажиллаж байгаа юм.

**-Бадмаа эмч ээ, би энэ зун амралтаараа хөдөө явах гэж байгаа. Өмнө нь хоолны хордлогод орох үе нэг бус удаа тохиож байлаа. Гэтэл энэ хордлогоос болж амь нас эрсддэг гэж сонслоо. Хоолны хордлогын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах гэсэн юм.**

-Урин цаг эхлэхээр хүмүүс зусланд гарах, рашаан сувилалд явах нь ихэсдэг. Улмаар иргэдийн дунд хоолны хордлогот халдвар нэлээд ихэсдэг. Энэ нь хүний биед хоол хүнсээр дамжин өвчин үүсгэгч янз бүрийн бактериуд орсны улмаас үүсдэг халдвар юм. Гэхдээ өвчин үүсгэгч бактериудын ялгаруулж буй хорт бодисууд нь өвчин үүсгэх гол шалтгаан болдог. Жишээлбэл, зонхилох шалтгаан болох бичил биетүүдээр дамжин халдварлагдсан мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, даршилсан ногоо, хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэргийг хэрэглэсний дараа хордлогот халдвар үүсэх нь олонтаа. Халдвартай бүтээгдэхүүнээс гадна энэ халуун уур амьсгалд хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горим алдагдсанаас болж уг халдвар үүсдэг. Хөдөө орон нутагт хоол хүнс хадгалах хөргөгч тэр болгон олдохгүй. Ер нь (0) хэмд бактер үржиж нь удаан байдаг бөгөөд зарим нь

үрждэггүй. (0)-(+5)хэмд бактер удаан үрждэг ба ямар нэгэн хүнс мууддаггүй. Энэ температурт түүхий махыг тав хүртэлх хоногт хадгалж болно. Харин нэмэх 5-16 хэмийн дулаанд олон нян үржиж, хоолны хордлого үүсч эрсдэлтэй. Нэмэх 16-52 хэмийг маш аюултай бүс гэж нэрлэдэг. Ийм халуун нөхцөлд хадгалсан хүнсэнд маш олон бактер үржин хордлого үүсгэх чадвартай болж, бактериуд хүнсний бүтээгдэхүүндээ хороо ялгаруулж эхэлдэг тул маш аюултай температур. Одоо цаг агаар нэмэх 20-30 градуст хүрчихлээ. Ийм нөхцөлд хүнсний бүтээгдэхүүнийг ил задгай байлгах маш аюултай.

**-Бид хөдөө, хол газар явахад замын хоол хүнсээ 2-3 хоногт авч явах нь энүүхэнд. Хамгийн аюултайд ямар хүнс орох вэ?**

-Нянгуудаасаа хамаарна. Жишээлбэл, хоолны хордлого үүсгэх бололцоотой 250 гаруй үүсгэгчийг бүртгэсэн байдаг. Үүнээс хоолны хордлогын халдвар үүсгэгч хэд хэдэн төрлийн нян бий. Сальмонеллез, ботулизм, шигелл буюу цусан суулгын үүсгэгч нян зэрэг байдаг. Жишээ нь, энэ нянгуудаас шигелла ч юмуу, кампило бактер хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн, сүүн, сүүн бүтээгдэхүүнд илүү үрждэг. Бие засах газар хангалтгүйгээс үүдэн ялаа, шумуул голлон нян дамжуулдаг. Ялгадас, амны замаар, бохир гараар халддаг нянгууд байна. Ботулизм гэх хоолны хордлогот халдвар нь хамгийн аюултай, хоолны хордлогын маш хүнд хэлбэр. Ботулизм үүсгэгч нян нь буруу лаазалсан бүтээгдэхүүнд голлон үрждэг. Лаазалсан өгөст хэмх зэрэг ийм төрлийн бүтээгдэхүүн хэрэглэсний дараа маш богино хугацаанд буюу 12-36 цагийн дараа шинж тэмдэг нь илэрч, богино хугацаанд гүн хордлогод орж амьсгалын зам, булчинд саажилт үүсгэж амь насаа алдах өндөр эрсдэлтэй. Хэдий цөөн ч гэсэн иргэдэд тохиолдсоор байдаг. Сальмонеллез гэх гэдэсний халдвар нь голлон түүхий өндөг, сүү сүүн бүтээгдэхүүн, боловсруулаагүй мах махан бүтээгдэхүүнд нян үүсгэж байдаг. Ийм халдвар авсан бүтээгдэхүүн хэрэглэснээр хордлогын шинж тэмдгүүд илэрнэ. Тухайлбал, гэдэс өвдөх, дотор муухайрах, бөөлжих,

хоногт олон удаа шингэн усархаг зүйлээр суулгадаг. Мөн халуурч, бие сульдаж, шөрмөс татах зэрэг шинж тэмдэг илэрч болно.

#### **-Хордлого авсан тохиолдолд эмчид хандалгүй удсанаас үүдэн ямар хүнд байдалд орж болох вэ?**

-Эмчид хандах хэд хэдэн шинж тэмдэг бий. Удаан хугацаанд халуурах, ядарч сульдан даралт буурах, эрдсийн алдагдалд орсноор унаж татах, алдаж байгаа шингэн нь цустай байх тохиолдолд заавал эмчид хандах ёстой. Ганц, нэг хоног суулгаж, бөөлжих үед гэрийн нөхцөлд эмчлэх бололцоотой л доо. Хордлогын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд нэн тэргүүнд ходоодыг угаана. Хоёр хувийн 1.5 литрийн содын уусмал ууж, эргээд бөөлжих байдлаар угаана. Бөөлжихдөө анхаарах зүйл бий. Элэгний хатуурал /цирроз/ өвчтэй, улаан хоолойны венийн судас өргөссөн, ходоодны шархлаатай хүмүүс уг ходоод угаах аргыг хэрэглэж болохгүй. Өөр өвчин хуучгүй хүн ходоодоо угаавал илүү үр дүнтэй. Хордлогын үед шингэн их алддаг тул шингэнээ нөхөх хэрэгтэй. Наад зах нь давс сахарын уусмал, хорсолтой ус зэргийг 1.5-3 литр хүртэлх хэмжээгээр ууж болно. Хоолны хордлогод орохгүйн тулд хүнсний бүтээгдэхүүн худалдан авахдаа муудсан шинж тэмдэг байгаа эсэхийг шалгах хэрэгтэй. Лаазалсан бүтээгдэхүүн авахдаа сав, баглааны бүтэн байдал, хугацаа, хадгалалтын горимын дагуу хадгалж байгаа эсэх зэргийг сайтар шалгах хэрэгтэй. Ер нь хоолыг сайн болгож идэх хэрэгтэй. 100-аас дээш хэмд нян үхдэг. Хоолыг аль болох өндөр хэмд боловсруулж, болгож идэж байх хэрэгтэй. Болсон хоолыг халуунд удаан хадгалахгүй байхыг хичээ. Болгосон хоолоо дахин хэрэглэх шаардлага гарвал заавал өндөр хэмд халааж ид. Болсон, болоогүй хоол хүнсийг хольж идэхгүй байх нь зөв. Зуны улиралд хүнсний бүтээгдэхүүнээ төрөл бүрийн шавьжуудаас маш сайн хамгаалах хэрэгтэй.

#### **-Зуны улиралд элэгний эмч нар амардаггүй гэсэн. Манайхан хорхог, боодгоо хэтрүүлснээс болдог үү?**

-Монголчууд хорхог, боодгыг дулааны улиралд голлон хэрэглэдэг. Тэр хурц шөл, шарсан түлсэн махыг идээд нойр булчирхайн өвчин сэдэрх, улмаар цаашдаа нойр булчирхайн үхжил үүсэх явдал нэлээд их байдаг. Хамгийн аюултай нь тэр хурц их өөх тостой мах идчихээд дараа нь хүйтэн айраг, архи уудаг. Энэ нь нойр булчирхайн үрэвсэл үүсэхээс гадна нойр булчирхайн үхжил үүсгэхэд маш их нөлөөлдөг. Цэл залуу, ямар нэгэн өвчин эмгэггүй залуучууд хөдөө яваад хорхог идэж, араас нь айраг ууж бөөрний дутагдалд орох, амь насаа алдах, хөдөлмөрийн чадвараа алдах харамсалтай тохиолдол манайд олон тохиолддог. Ялангуяа, зуны улиралд шүү. Хорхогны араас халуун бүлээн ус уух хэрэгтэй. Сүү сүүн бүтээгдэхүүн, хүйтэн ундаа, архи, пиво уух хэрэггүй. Хорхогны тэр өтгөн, өөх тос ихтэй шөлийг уугаад дэмий.

#### **-Монголчууд мах, архины араас сүүтэй цай уух зэргээр сүү, сүүн бүтээгдэхүүнийг хольж хэрэглэдэг. Энэ нь хэр зохимжтой вэ?**

-Ер нь хүнсний бүтээгдэхүүнийг хольж хэрэглэх нь зохимжгүй. Сүү, сүүн бүтээгдэхүүнийг хурц махтай хольж хэрэглэснээр нойр булчирхайн замын архаг өвчнүүдийг нэлээд сэдэрдэг. Хөдөө, орон нутгаар явж байхдаа хоол ундаа зохицуулж идээгүйгээс тухайлбал, өөх, тос ихтэй мах

идээд цөсний чулуу нь сэдэрсэн хүн олон бий. Цөсний чулуу сэдэрсний улмаас нойр булчирхайн хурц үрэвсэл, үхжилт үүсдэг.

#### **-Жуулчдад ямар зөвлөмж өгөх вэ?**

-Жуулчдын суулгалт /Traveler's diarrhea/ гэж өвчин бий. Энэ нь "E.colli" гэх нянгаар дамжин үүсдэг. Жуулчдын суулгалт нь хөгжиж буй улс оронд эрүүл ахуйн дэглэм хангалттай сахиагүйгээр үүдэлтэй. Манайд бол гаднын жуулчдад зориулсан бие засах газар хангалтгүйгээс тэд ил задгай бие засдаг. Улмаар бохир гараар "E.colli" нян дамжин гэдэсний халдвар үүсч суулгалт өгдөг. Тиймээс жуулчид эрүүл ахуйн дэглэмээ сайтар сахиж, ил задгай бие засахгүй байх хэрэгтэй. Ер нь жуулчид их явдаг газруудад бие засах газруудаа төвлөрүүлж, байнгын хлоржуулж цэвэрлэх ёстой. Аль болох ялаа шумуулнаас тусгаарлах хэрэгтэй.

#### **-Рашаан усны цаг ирлээ. Иргэд рашаан, сувилалд явахдаа юуг анхаарах хэрэгтэй вэ?**

-Хүнд зохимжгүй рашаан гэж бий. Элэгний хатуурал, ходоодны шарх, үрэвсэлтэй хүмүүс хамаагүй рашаан ууж болохгүй. Хүзэр агуулсан, ходоод гэдсийг цочроохуйц рашаан ууж болохгүй. Үүнээс болж хүндэрсэн тохиолдол цөөнгүй бий. Харин хүүхдүүд нарны хордлого нэлээд авдаг. Тиймээс нарны хэт туяанаас хамгаалах хэрэгтэй.

#### **-Танай тасаг наадмын үеэр нэлээд ачаалалтай ажилладаг биз?**

-Тийм шүү. Ер нь элэгний өвчлөл, хоол боловсруулах эмгэг их байгаатай холбоотойгоор манай эмнэлэг байнга ачаалалтай ажилладаг. Хоол боловсруулах тасаг баярын үеэр илүү их ачаалалтай болдог. Баярын дараа архины хордлого, ходоод гэдэсний цус алдалт, хордлоготой хүмүүсээр манай тасаг дүүрдэг.

#### **-Сүүлийн үед ходоодны шархлаа, хавдар их байна. Үүний шалтгааныг та хэрхэн тайлбарлах вэ?**

-Монгол цөөн хүн амтай хэрнээ ходоодны хавдраар дэлхийд хоёрдугаарт яваа. Ходоодны эмгэгийн шалтгааны дийлэнх нь хелико бактер. Манайд хелико бактерийн халдвар нэлээд байна. Давсалсан бүтээгдэхүүн, хийжүүлсэн ундаа их хэрэглэх нь ходоодны хавдар үүсэх эх үүсвэр болж байна. Нөгөө талаар, хоол хүнсний хэрэглээтэй холбоотой, хүнсний аюулгүй байдал алдагдсанаас болж ходоод гэдэсний эмгэг үүсэх хүчин зүйл болдог. Хелико бактер нь хеликотой хүний шүлс, аяга халбага болон өтгөнөөр бохирдсон зүйлээр дамжина. Уг бактерийг устгах олон улсын стандарт эмчилгээ болох антибиотик эмчилгээгээр эмчилнэ. Мөн эрүүл ахуйн дэглэм сахиж, гараа сайтар савандаж зөв угааж байж хоол ундаа идэх хэрэгтэй. Хелико бактер нь ходоодны шарх, үрэвсэл үүсгэх шалтгаануудын нэг болдог. Ходоодны үрэвслийн шинж тэмдэг илэрч байвал дийлэнх шалтгаан нь хелико бактер болдог учир шинжилгээ өгөх хэрэгтэй. Тухайлбал, хэвлийгээр цанхайж дүүрэх, цээж хорсох, хоол идсэний дараа хэвлийгээр дүүрэх гэх мэт.

#### **-Хелико бактертай хүний нүүрэн дээр юм гардаг гээд байдаг. Энэ үнэн үү?**

-Тийм шинж тэмдэг байхгүй. Хорт зуршлаас татгалзаж, кофе бага хэрэглэ. Спирт, хиама, давсалсан бүтээгдэхүүн, шарсан түлсэн бүтээгдэхүүнээс аль болох татгалзах хэрэгтэй. ■



БИЕИЙН ТАМИР

Улаанбаатар Маратон-2015

## Иргэдийн идэвхээр хөгжих спортын салбар

А.Бүрэнжаргал

Спортоор хичээллэхийн ач холбогдлыг эрүүл аж төрөх үндэс хэмээн ухаан орсон цагаас эхлэн бидэнд сургасаар ирсэн. Гэсэн ч биеийн тамираар хичээллэх орчин олон нийтэд хязгаарлагдмал болоод ч тэрүү олны хандлага өдөр тутмын спортыг ойшоохгүй өдийг хүрсэн. Харин өдгөө иргэдийн дийлэнх нь эрүүл мэнддээ анхаарч, таргалалттай тэмцэх, хөдөлгөөнөөр эрүүлжихийг илүүд үздэг болжээ. Үүнтэй холбоотой нийслэлчүүдийн эрүүл амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээг багагүй зохион байгуулж буй. Тухайлбал, энэ жил хоёр дахь удаагаа зохион байгуулж буй “Улаанбаатар марафон-2015” олон улсын гүйлтийн тэмцээнд Монгол, Австри, Япон, АНУ, Хятад зэрэг 20 орчим орны 17 мянга гаруй хүн оролцжээ. Энэхүү арга хэмжээ нь эх орондоо гүйлтийн спортыг хөгжүүлэх, нийслэлээ дэлхийн улс орнуудад сурталчлах, гүйлтээр хичээллэгч сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр залуу үеийнхэнд өөрийн дотоод нөөц боломжийг нээж зорилгодоо хүрэх тэсвэр хатуужилтай болгох арга хэмжээ гэдгийг зохион байгуулагчид онцолсон. Үүгээр зогсохгүй бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжил

төлөвшүүлэх зорилгоор “Улаанбаатар марафон-2015” олон улсын гүйлтийг жил бүрийн зургаадугаар сарын эхний долоо хоногийн амралтын өдрөөр зохион байгуулахаар болсон. Өдгөө иргэдийн спортоор хичээллэх идэвхийг дэмжин дэд бүтцийн ажил ч эрчимжсээр байна. Биеийн тамираар хичээллэнэ гэдэг өөртөө хөрөнгө зарцуулж, өөрийн эрүүл мэнддээ анхаарч байгааг хувийн хэвшлийнхэн ч анзаардаг болж. Өнөөдөр ард түмэнд спорт цогцолбор хэрэгтэй, хэрэггүй байх нь хамаагүй ирээдүйд хэрэгцээ болоод ирэхээр хувь ч бай хувьсгал ч бай бүтээдэг юм гэдгийг Нийслэлийн биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганбаатар хэлсэн. Нийгэмд хэрэгцээ нь тулгараад ирэхээр бизнесийн байгууллагууд анзаарч бүтээн байгуулалт хийдгийн тод жишээ сүүлийн жилүүдэд олноор байгуулагдах болсон фитнес клубууд юм. Түүнчлэн хувийн хэвшлийнхэн спорт ордон, иргэд биеийн тамираар хичээллэх боломжит орчин бүрдүүлэх гэж буй тохиолдолд төр, засгийн зүгээс газрын зөвшөөрөл бусад холбогдох бичиг баримтыг шийдвэрлэж өгч байх нь зүйтэй гэдгийг ч мөн албаныхан онцоллоо. Иргэдийн хувьд хөдөлгөөний дутагдалаас сэргийлж явган аялал, гүйлт, дугуйн

спортоор багагүй хичээллэх болсон байна. Гэвч олон нийтийн идэвх нэмэгдэх тусам тэд орчин шаардаж байна. Статистик мэдээллээс үзэхэд нийслэлд дасгал хөдөлгөөн хийх, бие бялдрыг чийрэгжүүлэх ногоон байгууламж бүхий 98 талбайг өнгөрсөн гурван жилд нийслэл, дүүрэг, хороо, аж ахуйн нэгж, иргэдийн үүсгэл санаачлагаар барьж байгуулснаар нийслэлд 702 биеийн тамир, чийрэгжилтийн талбай ажиллаж байгаа аж. Нийслэлийн хэмжээнд биеийн тамир, спортын гадаад харилцаа, хамтын ажиллагаа жилээс жилд өргөжин ОХУ, БНХАУ, БНСУ, Япон, Итали, Франц зэрэг орны улс болон хотуудын биеийн тамир, спортын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод 20 гаруй нөхөрсөг уулзалт, тэмцээн явуулж гадаад оронд мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах ажлыг идэвхтэй зохион байгуулж байна. Түүнчлэн манайхны хувьд шинэ тутам спорт болох усан спортыг хөгжүүлэх зорилгоор дүүрэг бүрт усан сан барих ажил ид өрнөж байна. Ингэснээр цаашид дэлхийн аварга, тивийн наадмуудыг нийслэл хотдоо үе шаттай зохион байгуулж, улмаар 2040 онд Олимпын тоглолтыг эх орныхоо нийслэлд зохион байгуулах зорилт тавин ажиллаж байгаа аж.

Гэсэн хэдий ч салбарын санхүүгийн асуудал төдийлэн хүрэлцээтэй бус. Биеийн тамир, спортын иргэдэд хүрдэг үйл ажиллагаанд улсын төсвөөс жилд 200 орчим сая төгрөг төсөвлөдөг аж. Үүнийг 10 байгууллага хуваан авдаг. Есөн дүүрэг, нийслэлийн биеийн тамир спортын газар. Нэгж бүрт үйл ажиллагаа нь хэрэгждэг учраас энэ мэт олон задардаг гэнэ. Үйл ажиллагааны тайлангаа танилцуулаад төсөвлөсөн хөрөнгийг Сангийн яам шийдэхдээ хасчихдаг аж. Эдийн засгийн нөхцөл байдал сайнгүй байгаатай холбоотой төсөвлөсөн хөрөнгөөр үйл ажиллагаагаа явуулахын зэрэгцээ иргэдийн идэвхид тулгуурлан зардал багатай үйл ажиллагаа зохион байгуулж байгаа аж. Олон нийтийн идэвхээр урагшилж буй тус салбарт ойрын хоёр жилийн хугацаанд багагүй бүтээн байгуулалт өрнөжээ. Цаашдаа ч иргэдийн идэвх салбарын хөгжлийг шинэ шатанд хүргэх тэмүүлэл болох ажээ. ■



А.Бүрнээ

## Ж.Ганболд: Эрүүл аж төрөх орчныг бүрдүүлнэ

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дарга Ж.Ганболд раас салбарын хөгжил, өнөөгийн байдлын талаар гурван асуулт тодрууллаа. Тэрбээр спортын салбарын хаалгыг татаад 40 орчим жилийг үджээ. Бөхийн спорт, тэр дундаа самбо, жудо бөхөөр хичээллэж байсан бөгөөд боловсрол судлалын ухааны доктор, Ганболд нь биеийн тамир спортын газрын даргын албыг хашаад 10 жил болж буй.

**-Биеийн тамираар хичээллэх гэдэг эрүүл аж төрөхийн нэг хэлбэр. Нийслэлчүүдийг спортоор хичээллэж эрүүл мэнддээ анхаарахад салбарын зүгээс хэрхэн анхаарч ажилладаг вэ?**

-Нийслэлийн Биеийн тамир спортын газар 50 гаруй жилийн түүхтэй. Байгуулагдсан цагаасаа эхлэн нийслэлийн иргэдийн бие бялдрыг хөгжүүлэх, хөдөлгөөний дутагдалаас урьдчилан сэргийлэх зорилготой ажиллаж байна. Нийслэлчүүдийн хувьд биеийн тамир гэдэг ямар ач холбогдолтой, иргэдэд яаж хүрч байх ёстойг тэдэнд ойртуулах нөхцөл боломжийг хэрхэн бүрдүүлэх тал дээр анхаарч ирлээ. Сүүлийн жилүүдэд Нийслэлийн удирдлага, НИТХ, НЗДТГ-ын зүгээс иргэдийн эрүүл чийрэг байх нөхцөлийг бүрдүүлэх олон үйл ажиллагаа санаачлан зохион байгуулсаар байна. Үүнээс гадна орчин бүрдүүлэх ажлыг идэвхтэй хийх төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд дүүрэг бүрт спорт цогцолбор барих ажил эхэлсэн. Мөн иргэдэд зориулсан ногоон байгууламж байгуулах, ерөнхий боловсролын сургуулиудын гадаа талбайг хиймэл ногоон зүлэгтэй болгох, төв цэнгэлдэх хүрээлэн, хөл бөмбөгийн төв талбайг

зүлэгжүүлж, биеийн тамираар хичээллэх таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд явган аялал, марафон гүйлт зэргийг зохион байгуулах, цаашид илүү тавтай орчин бүрдүүлэх тал дээр голчлон анхаарна. Мөн 2021 он гэхэд бүх дүүрэг өөрийн гэсэн спорт цогцолбортой болох зорилгыг ажил хэрэг болгоно. Спорт цогцолбор байгуулагдсанаар тухайн дүүргийн оршин суугчид дүүрэгтээ биеийн тамираар хичээллэх боломж нь нээлттэй болох юм.

Түүнчлэн олон нийтийг хамарсан спортын арга хэмжээ багагүй зохиож ирлээ. Үүний нэг марафон гүйлтийг хоёр дахь жилдээ зохион байгууллаа. Нийслэлийн Засаг даргын санаачлагаар зургаадугаар сар бүрийн эхний долоо хоногийн амралтын өдөр зохион байгуулж байхаар болсон. Дэлхий нийтээр ач холбогдол өгч зохион байгуулдаг Токио марафон, Лондон марафон гэхчлэн олон улсын томоохон хотуудын жишиг манайд амжилттай хэрэгжиж эхэлсэн нь энэ. Өнгөрсөн жил 16 мянга гаруй иргэн хамрагдаж байсан бол энэ жил 17300 гаруй иргэн гүйлтэд оролцсон байна. Өнгөрсөн жилийн хувьд хүмүүс гараанаас гараад замаасаа цуцаж гүйлтээ зогсоож байсан. Харин энэ удаа таван км замд гарсан хүмүүс бүгд бариандаа орж замаа гүйцээж байлаа. 10, 21, 42 км-ын замд ч мөн хүмүүсийн оролцоо нэмэгдсэн. Мөн гүйхгүй ч гэсэн оролцогчдыг дэмжиж үйл ажиллагаанд сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлж байсан.

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд найман чиглэлийн арга хэмжээ

зохион байгуулахаар тусгасан.

Хамгийн гол нь, Нийслэлийн Биеийн тамир, спортын газраар дамжуулж өсвөр үе, залуучуудыг багийн спортоор дамжуулж чийрэгжүүлэх бодлого баримталж ажилладаг. Тухайлбал, сурагчдын сагсан бөмбөгийн лиг байна. Энэхүү арга хэмжээ нь нийслэлийн ерөнхий боловсролын бүх сургуулийг хамардаг. Энэ нь цаашлаад нийслэлийн аварга хүртэл нь шалгаруулдаг. Мөн “Дуулиан 2020” хэмээх олон нийтийн сайн мэдэх тэмцээнийг жил бүр зохион байгуулж байна. Биеийн тамираар хичээллэхийн ач холбогдолыг ойлгож зохион байгуулж буй үйл ажиллагаанд олон нийт идэвхтэй оролцдог, хүн бүр мэддэг, нэгнээ уриалдаг болж байгаа нь бидний хийж буй үйл ажиллагааны үр дүнг илэрхийлж байна.

**-Олон нийт идэвхтэй оролцохын хэрээр төр засгийн зүгээс орчин бүрдүүлэх үүрэг тулгарч байгаа. Нэгдсэн марафон гүйлт зэрэг үйл ажиллагаанаас бусад үед бидэнд гүйх, дугуй унах зам зэрэг дэд бүтцийн асуудал тулгамддаг. Энэ чиглэлээр ямар ажил хийж байна вэ?**

-Нийслэлд спортоор хичээллэх таатай орчин бүрдээгүй. Анхнаасаа гүйлт, дугуйн замтай хийгдээгүй болохоор өдөр тутмын биеийн тамир хийх орчин бүрдүүлэх төлөвлөлтгүй байгуулагдчихсан. Жишээлбэл, дугуйн болон гүйлтийн замгүйгээр дэд бүтцээ шийдчихсэн. Саяхнаас л зарим хэсэгт дугуйн зам, гүйлтийн замыг шийдэж өгч байна. Түүнчлэн гарцуудад дугуйгаар бүүх налуу замуудыг шийдэж өгсөн. Эдийн засаг сайнгүй байгаатай холбоотой иргэдийн өдөр тутмын

бүгд хийгдээд явах боломжтой. Өнөөдөр яриад маргааш хийх ажил биш шүү дээ.

**-Нийслэлийн хүүхдийн тоглоомын ихэнх талбай хүүхдэд аюултай орчныг бүрдүүлсэн харагддаг. Түүнчлэн хүүхэд хөгжүүлэх спортын орчин тааруу байдаг. Үүнийг өөрчлөн сайжруулах ямар нэг арга хэмжээ авч байна уу?**

-Хүүхдийн тоглоомын талбайг зориулалтын шахмал резинэн хавтангаар хийж байна. Өмнө нь

цементээр хийчихсэн байсан. Шинээр баригдаж буй хорооллын тоглоомын талбайг резинэн хавтангаар хийх стандартыг баримталж ажиллахыг барилгын компаниудад үүрэг болгосон байгаа.

Мөн дүүрэг бүрт усан спортын төв байгуулагдаад дуусаж байна. Чингэлтэй, Сүхбаатар дүүрэг спорт ордонтойгоо нэгтгэж хийхээр төлөвлөсөн байгаа учраас хойшилсон. Ингэснээр дүүргийнхээ иргэдэд хүрч үйлчлэх,

хүүхдийг багаас нь усан спортоор хичээллүүлэх боломж иргэдэд улам ойртох юм. Усан спортын төвүүд бол орон нутгын санхүүжилтээр байгуулагдсан бүтээн байгуулалт.

Шат дараалалтайгаар орчин бүрдэнэ. Улс орны эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа ч сүүлийн жилүүдэд харьцангуй хурдтай хөгжиж байна. Цаашид олон асуудлыг богино хугацаанд хурдтай шийдэх боломжийг бүрдүүлэн ажиллах болно. ■

## СОЁЛ УРЛАГ

# Эдийн засагжаагүй салбар

Ц.Элбэг

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 0.3-0.5 хувьтай тэнцэх хөрөнгийг жил бүр соёлын салбарыг хөгжүүлэхэд зарцуулдаг байна. Харин АНУ-д энэ тоо 4.3 хувь байдаг. Манайд зарцуулдаг мөнгө нь байгууллагуудын барилга, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх, урын болон үзмэрийн санг баяжуулах, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, хөгжүүлэхэд хүрэлцдэггүй гэх. Америкт 4.7 сая хүн соёлын салбарт ажиллаж, 698.7 тэрбум ам.долларын баялаг үйлдвэрлэдэг ажээ. Энэ нь тус улсын Иллинойс, Пенсилвани, Флорида мужийн дотоодын нийт бүтээгдэхүүнтэй тэнцэж байна /2012 оны судалгаа/. Монгол Улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт дүнд эзлэх соёлын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нэр төрөл гэсэн зүйл анги байхгүй. Бодит байдалд байгууллагууд үйл ажиллагаанаас олсон орлого нь зарлагаа нөхөж чаддаггүй.

Нэг талаас АНУ-тай харьцуулах учир дутагдалтай. Гэхдээ ийм хэмжээний зөрүүтэй байгаа нь бидний буруу хандлагаас хамааралтай гэдгийг салбарт ажиллагсад хэлж байгаа юм. Өөрөөр хэлбэл, монголчууд соёл урлагийг бизнес гэж хардаггүй. Яагаад гэвэл 70 гаруй жил соёл урлагийг ердөө нийгмийн үйлчилгээ гэж үзэж, ашиглаж ирсэн нь тийм л байх учиртай гэсэн ухамсар бий болжээ. Тиймээс юун түрүүнд соёлын салбарыг зах зээл гэж харах нь хөрөнгө оруулалт татах суурь нөхцөл болох гэнэ.



Үүнтэй адилаар соёлын салбарын үйлдвэрлэгчид нь өөрийгөө нийгэмд үйлчлэх үүрэгтэй гэж үздэгээс бүтээгдэхүүнээ зах зээлийн эргэлтэд оруулах тал дээр идэвх муу байдаг аж. 2011 онд эдийн засгийн өсөлт 17.3 хувьтай байхад энэ салбарын бүтээмж 11.6 хувиар буурсан нь үүнийг батална. Харин ойрын хэдэн жилээс соёлын салбарыг эдийн засагжуулахад тал дээр төрөөс анхаарал хандуулж “Соёлын аж үйлдвэр” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа юм. Энэ хүрээнд олон талтай арга хэмжээ авч бодлогыг хэрэгжүүлж байгаа аж. Тухайлбал, хамгийн сүүлд Киноны тухай хуулийг УИХ-аар батлуулах гэж байгаа тухай Боловсрол, шинжлэх ухааны



Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 0.3-0.5 хувьтай тэнцэх хөрөнгийг соёлын салбарыг хөгжүүлэхэд зарцуулдаг

сайд Л.Гантөмөр дуулгасан. Тэгвэл энэ бодлого нь нийслэлийн хүрээнд “Найрсаг Улаанбаатар” төсөлтэй нягт уялдаж байгаа юм. Хөтөлбөр соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэнээр энэ салбарыг эдийн засагжуулж, зах зээлийг бий болгоход үндсэндээ чиглэж байна. Үр дүнд нь таван жилийн дараа гэхэд Улаанбаатар хотод аялах жуулчдын тоо хоёр саяд хүрч хотын музей, театрууд, уран бүтээлийн үзэсгэлэн, хамтлаг дуучдын тоглолт, концертын үзэгчид, үйлчлүүлэгчид нь болох зорилготой. Тэр үед хотын гудамж талбай, үзвэр үйлчилгээний газрууд огт өөр түвшинд хүрсэн, уран бүтээлчид нь бүтээлч үйлдвэрлэгчид болсон байх ёстой.

Нийслэлийн Соёл урлагийн газраас одоогоор хэрэгжүүлж буй бодлого нь соёлын салбар өөрөө өөрийгөө хөгжүүлэх боломжтой болох, эдийн засгийн орчин бий болгох, бүтээлч үйлдвэрлэлийн салбарт оруулах, төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх чиглэлтэй байгаа аж.

Төр, хувийн хэвшлийн зөв зүйтэй түншлэл хөгжлийн хамгийн зөв зам хэмээн тодорхойлж байна. Хэрхэн зөв түншлэх тухай тал, талдаа ярилцаж буй. Бүтээлч үйлдвэрлэл бий болгох, соёлын салбарыг эдийн засагжуулахад ч төр, хувийн хэвшлийн түншлэл чухал үүрэгтэй талаар нийслэлийн Соёл урлагийн газрын Урлаг, уран сайхны хэлтсийн дарга М.Мөнхсайхан хэлж байгаа юм. Жишээ нь, жил бүр шинэ жилийн баярыг Чингис хааны талбай дээр олон тэрбум төгрөг төсөвлөн тэмдэглэдэг. Хэрэв энэ арга хэмжээнд хувийн хэвшлийг оролцуулбал төсөв хөрөнгийг багасгах боломжтой аж. Нийслэлийн захиргаанаас талбайн асуудлыг шийдэж, хувийн компаниуд цэнгүүний хөтөлбөр, уран сайхны

хариуцаж, зар сурталчилгаа байршуулах зэргээр зардлаа нөхөж ажиллах боломж бий хэмээн тэрбээр ярьсан юм.

Соёлын үйлдвэрлэлийг зах зээлийн эргэлтэд оруулах, бүтээлч болгохын тулд манайд дутагдалтай байдаг асуудал бол хөрөнгө мөнгө. Энэ асуудлыг ч мөн түншлэлийн зарчмаар шийдэх боломжтой. Шоу бизнесийн хамгийн том үйлдвэрлэл “Холливүүд”-эд ч энэ зарчмаар шийддэг болжээ. Технологийн хөгжлийг дагаад техник хэрэгслүүд нь өдрөөс өдөрт хоцрогдох болсон тул компаниуд худалдаж авахаасаа татгалзах болжээ. Түүний оронд түрээслэх нь ашигтай тусдаг байна. Үүнийг дагаад хүссэн үйлчилгээг нь үзүүлдэг компаниуд ч бий болжээ. Манайд ч энэ загварыг авч хэрэгжүүлэх боломжтой гэж МҮОНРТ-ийн захирал Ц.Оюундарь хэлсэн. Тэрбээр соёлын дүүрэгтэй болох санаа дэвшүүлж байгаа юм. Ингэснээр түншлэгчид хоорондоо ойртож салбарын хөгжил эрчимжнэ гэж буй.

Соёлын аж үйлдвэрийг хөгжүүлэх нь улс орны өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, тогтвортой хөгжлийг хангах, хүн амын амьжиргааны түвшинг сайжруулахад хөрөнгө оруулалтын үр нөлөөг дээшлүүлэх зэрэг нөлөөтэй. Ажиллагсдын тоо, цалингийн хэмжээ, хотын болон улс орны эдийн засагт оруулж буй хувь нэмэр, татвар төлсөн дүнгээрээ соёлын салбар зочид буудал, ресторан, аялал жуулчлал, банкуудын адил эдийн засгийн ач холбогдолтой, нөлөө бүхий үйлдвэрлэл болохыг дэлхий даяар хүлээн зөвшөөрөх болжээ. Тиймдээ ч улс орнууд соёлын аж үйлдвэрийн салбар дахь өөрсдийн үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, хөрөнгө оруулалт хийхэд бодлогоо чиглүүлж байгаа аж. ■



## Венийн үдэш

"Найрсаг Улаанбаатар" хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар-Вена хотуудын соёлын хамтын ажиллагааны нэг томоохон арга хэмжээ болох "Венийн үдэш" цэнгүүн зургаадугаар сарын 5-нд Чингис хааны талбайд болсон юм. "Венийн үдэш" цэнгүүнд И.Штраусын бүтээлүүдээс гадна "Уран хас", "Дурлалын вальс", "Миний Улаанбаатар" зэрэг Монголын сонгодог вальс хөгжим эгшиглэж 100 хос бүжлээ.

Цэнгүүний ерөнхий удирдаачаар Австри улсын удирдаач Matthias Fletzberger ажиллан Монгол Улсаас Урлагийн гавьяат зүтгэлтэн, удирдаач Н.Бүтэнбаяр, Н.Туулайхүү, удирдаач Д.Нямдаш, Ч.Төмөрбат нар 120 хүний бүрэлдэхүүнтэй симфони оркестрыг дохисон юм. Тоглолтын ерөнхий найруулагчаар Нийслэлийн Улаанбаатар чуулгын дарга Р.Мөнхсайхан ажиллаж, Австрийн бүжгийн багш Heinz Heidenreich гэргийн хамт ирсэн зочдод Венийн вальсын энгийн хөдөлгөөнийг заан 100 хосыг удирдан бүжиглүүлээ.

Энэхүү үйл ажиллагаанд Австри улсын Вена хотын албаны төлөөлөл болон удирдаач, бүжгийн багш, хөгжимчдөөс гадна УДБЭТ болон Улсын филармоний Симфони оркестр, Нийслэлийн Улаанбаатар чуулгын "Хангарьд" үндэсний найрал хөгжим, Хүүхэд Залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын үлээвэр хөгжмийн хамтлаг, Улаанбаатар бүжгийн Спортын холбоо, Монголын Нийтийн бүжгийн холбооны бүжигчид оролцсон байна. ■



120 хүний бүрэлдэхүүнтэй симфони оркестор хөгжимдөж, 100 хос бүжлээ



## Дайрдаг, зорьдог, аялдаг хот

Б.Энхцэцэг

Олон улсын зэрэглэлийн ганц онгоцны буудал, төмөр замын босоо нэг шугамтай Монголд жуулчид аялахын тулд хүслээрээ бус “хүчээр” Улаанбаатарт эхлээд ирдэг. Нийслэлээр аяллаа эхэлж бас дуусгадаг атлаа жуулчид эргээд харихдаа Монголын нүүдэлчин соёл заншил, хөдөө нутгийг онцолдогдоос нийслэл хотыг биширч ярьдаг нь юу л бол.

Нийслэлийн Аялал жуулчлалын газар болон Аялал жуулчлалын үндэсний төвийн 2013 онд гаргасан судалгааны тайланд Монголд аялаад буцсан жуулчдын дийлэнх нь үзэсгэлэнт байгаль, нүүдэлчин соёлыг сэтгэл хөдөлгөм гэж онцолсон бол таагүй сэтгэгдэл үлдээсэн зүйлээр Улаанбаатар хотын замын түгжрэлийг нэрлэжээ. Харин 2005 онд жуулчдад хамгийн ихээр таалагдаагүй байсан зүйл нь орон нутгийн зорчигч тээвэр, замын нөхцөл байж. Жуулчдын дунд хийсэн энэхүү судалгаа нь гаднынханд үлдсэн таагүй сэтгэгдлийн дийлэнх нь Улаанбаатар хот доторх асуудлууд байгааг харуулжээ. Харин эерэг сэтгэгдлүүд ихэнхдээ хотоос гаднах бүст харьяалагдаж байна. Италийн Венец, Францын Парис, Австралийн Сидней тэргүүтэй дэлхийн хотууд улсаа бүрэн төлөөлдөг бөгөөд хүмүүс тухайн хотыг үзэх гэж зорьж очдог. Цаашилбал, зөвхөн нэг хотод нь болдог ганцхан том арга хэмжээ тухайн хотыг төдийгүй улсыг бүрэн илэрхийлж,

олны хараанд нүдлэгдэх тохиолдол бий. Тухайлбал, Рио Де Жанеро багт наадмаараа, Испанийн Пампилио хот бухын фестивалиараа, Германы Мьонхин шар айрагны баяраараа олноо танил байдаг.

“Улаанбаатар Монголыг төлөөлж чаддаггүй” гэж Номадик Экспедишн компанийн аяллын менежер Н.Баатарням хэлж байна. Түүний хэлж байгаагаар замын бөглөрөл ихтэй дээр нь нэмээд явган зорчигчдод ээлтэй бус зэрэг олон шалтгаанаас үүдэн хотод жуулчдын хоноглох тоо цөөхөн байдаг гэлээ. Гэвч хүссэн хүсээгүй бүс нислэгүүд Улаанбаатар хотоор дамждаг учир хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх ёстой гэдгийг тэрбээр нэмж хэлсэн юм.

“Lonely Planet” хэмээх дэлхийд хамгийн түгээмэл аяллын хөтөч номд Монголын хот ба хөдөөг “Yin, Yang” буюу эсрэг тэсрэг ч гэсэн нэг, нэгэнгүйгээр оршин тогтнох боломжгүй гэгддэг арга, билгийн ухаантай зүйрлэж, дүрсэлсэн байдаг. Тус номд Монголын хөдөө тал нь анир чимээгүй онгон дагшин байдаг бол хот нь хүн, машин олноороо холхисон, бизнес, худалдааны орчин үеийн төв цэг гэжээ. Гэхдээ Улаанбаатарын өнгө төрх нь тийм гэж хэлэмгүй олон янз. Армани брэндийн хослолтой нэгэн, үндэсний дээлтэй нөгөөтэй зөрж өнгөрөх дүр зураг энэ хотод жирийн үзэгдэл бөгөөд хот хөдөөгийн амьдрал сүлэлдэж байдгийн нэг жишээ гэдгийг

“Lonely Planet” онцолжээ.

Уул уурхайн “тэсрэлтэт” өсөлтийн үрээр олон улсын хэвлэл мэдээлэл уурхайг хот, хөдөө, хүн ардтай нь цогцоор нь харуулдаг болсноор зөвхөн нүүдэлчид амьдардаг гэх гаднынхны төсөөлөл харьцангуй өөр түвшинд оччихоод байгаа. Улаанбаатарын хувьд өдгөө социалист төрхөөсөө баруунжсан хэв маяг руу хурдацтай хувирч буй. Энэхүү их өөрчлөлтийн давалгаа жуулчдад Монгол Улс хөгжиж, хот тэлж буйг харуулж буй. Хотын аялал жуулчлалд энэ их өөрчлөлтийн үр дүн юу вэ гээд харвал, зочид буудал, рестораны тоо, хүчин чадал нэмэгдсэн гэх зэргийг дурьдаж болох юм. Гэвч үйлчилгээний чанар талаас ярьвал, шинэ, хуучин аль нь ч дэлхийн стандартаас нэлээд зөрүүтэй явааг жуулчид аяллын төгсгөлд санал гомдлын дэвтэртээ бичээд явах нь элбэг. “Хүчин чадлыг нэмэгдүүлэхээс гадна чанар, сэтгэл ханамж дээр анхаарах нь зүйн хэрэг. Ингэхийн тулд стандартыг өндөржүүлэх хэрэгтэй” хэмээн Монголын зочид буудлын холбооны тэргүүн С.Мөнхбат хэлж байна. Өдгөө Улаанбаатар хот нэг өдөрт 10 мянган хүн хүлээн авах боломж бүрдсэн гэдгийг Монголын эдийн засгийн чуулганы үеэр аялал жуулчлалын салбарын мэргэжилтнүүд онцолж байсан.

“Одоо бол Үндэсний баяр наадмын үеэр жуулчиддаа дарагдаад ирэхээр

хоолны газар, зочид буудал хүрэлцэхгүй улмаар чанар сулардаг байдал, мөн халаасны хулгай, гудамжны хүүхдүүд гэх мэт асуудлууд нэг үеэ бодвол нэлээд засарчихлаа. Ерөнхийдөө Улаанбаатар хотыг сөрөг талаас үзүүлдэг байсан хүчин зүйлс ажмаар багасч байна” хэмээн Н.Баатарням хэллээ.

### Бидэнд юу байна вэ?

Бид хотын аялал гэхээр үндсэндээ юу үзүүлдэг вэ гэвэл Гандантэгчилэн хийд, Төв талбай, Зайсан толгой, Түүхийн ганц музей. Сүүлийн үед уран зургийн галерейн тоо нэлээд олширсон нь хотын аялалд багагүй нэмэр болж буйг Н. Баатарням хэлж байна. Групп аялалд багтан Монголд аялж буй жуулчдын дундаж зарцуулалт хоногт 190 ам.доллар байгаа бол бие даан аялагч 120 ам.доллар, үүргэвчтэй аялагч 77 ам.долларыг дунджаар хоногт зарцуулж байгааг 2013 оны салбарын хэмжээн дэх судалгаа харуулдаг. Энэ бол чамлахаар доогуур үзүүлэлт биш. Учир нь дэлхийн хамгийн үнэтэй хотуудын нэг болох Лондонд гэхэд жуулчны дундаж зарцуулалт 72 фунт стерлинг буюу төгрөгт хөрвүүлбэл 210 мянган төгрөг байна. Ингэхээр бид бүтээгдэхүүн, үйлчилгээг үнэтэй болгох бус төрөлжүүлэх цаашлаад чанаржуулж, жуулчдын хоноглох тоог олшруулах шаардлага эндээс урган гарч буй. Үүний тулд Улаанбаатар жуулчид дайрдаг бус зорьдог газар байх зорилгыг өвөртөлж, энэ улсад хоёр дахь удаагаа ирж буй хүнд ч сонирхолтой байхуйц үзвэр үйлчилгээний сонголтууд мөн хэрэгтэй юм. Сүүлийн жилүүдэд жуулчдын хувьд

үзэж харах үзэмрийн тоонд төдийлэн өөрчлөлт ороогүй ч үзвэрийн хувьд жинтэй өөрчлөлт орсныг салбарынхан хэлж байна. Нийслэлийн төсвийн таван хувь буюу 30 гаруй тэрбум төгрөгийг жил бүр зарцуулахаар болсон “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөр батлагдаад ердөө хагас жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хүрээнд 32 төрлийн арга хэмжээг зохион байгуулахаар тогтсон бөгөөд үйл явдлууд эхнээсээ цуварч буй нь ялангуяа Төв талбайг ихээхэн “завгүй” болгож буй. Одоохондоо тус арга хэмжээнүүд нь жуулчдын аяллын хөтөлбөрт албан ёсоор багтаагүй ч нэмэлтийн үүрэг гүйцэтгэж байна. Харин бодитоор аяллын багцад багтааж, зорьж үздэг болгохын тулд дээрх арга хэмжээнүүдийг тогтмолжуулах, хуваарийг 2-3 жилийн өмнө гаргаж занших хэрэгтэйг тур операторуудын төлөөлөл хэлж байна. Гаднын жуулчид дийлэнхдээ 1-2 жилийн өмнө аяллын захиалга өгдөг. Тиймээс арга хэмжээг тухайн жил гарснаас хойш төлөвлөдөг байвал аяллын нэг хэсэг байхаасаа өнгөрөх аж.

Тур операторуудын хэлж байгаагаар Монголд нэг л арга хэмжээний тов хамгийн тодорхой, өөрчлөлтгүй байдаг нь Нийслэл дэх Үндэсний баяр наадам. Тиймээс л гадныханд санал болгодог гол арга хэмжээ Улсын наадам байдаг. Ингээд яг энэ арга хэмжээний үеэр буюу долоодугаар сард Монголыг зорьдог жуулчдын 70-80 хувь нь ирдэг. “Наадмын улирлыг задалж, бусад сард Наадамтай өрсөлдөхүйц томоохон арга хэмжээ байх хэрэгтэй” хэмээн “Дисковер Монголиа Травел” компанийн Ерөнхий

захирал Б.Барсболд хэлсэн. Жишээлбэл, өнгөрсөн жил зохион байгуулсан морин фестиваль ихээхэн амжилттай болсныг тэрбээр мөн жишээ татаж ярьсан юм.

“Арга хэмжээ дагасан жуулчлалын үр дүн нь, оролцож байгаа хүн нь цөөн ч тухайн хот, улсын брэнд имижийг бүрдүүлэхэд хамгийн их нөлөөлдөг” хэмээн Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга Э.Баттулга хэлж буй. Түүний хэлж байгаагаар бол “Найрсаг УБ” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж буй арга хэмжээнүүд нь Улаанбаатарыг соёлын уур амьсгал бүрдсэн уйдаах завгүй, дэвшилтэт, сонирхол татахуйц газар гэсэн имижтэй болгохыг зорьж буй гэсэн. Угтаа морь унаад явж байдаг хүмүүс гэх гадныхны төсөөллийг давсан хэмжээний зүйл бидэнд байгаа шүү гэдгийг эдгээр арга хэмжээнүүдээр дамжуулан харуулах нь гол зорилго аж.

Ойрын жилүүдэд Монголд ирэх жуулчдын тоон өсөлт тасралтгүй саарч байгаа бөгөөд өнгөрсөн хоёр жил дараалан салбарын хэмжээнд үзүүлэлт хасахтай гарсан. Уул уурхай, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх гэж тодорхойлогддог салбар төр дэмжсэн, дэмжээгүй аяндаа өсч хөгжиж байдаг үе нь өнгөрчихөж. Таваарын бүтээгдэхүүний үнэ тэнгэрт хадаж, ухаж гаргаад баяжчихдаг үе улирсан бол аялал жуулчлалын хувьд Монгол “моданаас” гарч, Монголыг бууралтын мөчлөг дайрч байна гэж мэргэжилтнүүд хэлж буй. Жам ёсоороо өсөлтийн үе мөдтөө эргэж ирэхгүй нь. Гэхдээ тэр нь бид үүнийг сөрж зогсож, өөрчилж чадахгүй гэсэн үг биш. ■

## ГУРВАН АСУУЛТ

# Жуулчдын төлсөн татвараар дараагийн төслүүдийг санхүүжүүлнэ

Б.Энхцэцэг

Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газрын дарга Э.Баттулга нь 2002 оноос хойш аялал жуулчлалын салбарт ажиллаж байгаа.

Тэрбээр Монгол, Япон, Австрали улсад суралцаж, мэргэжил эзэмшсэн. Газарзүйн ухааны болон Бизнесийн удирдлага-Олон улсын аялал жуулчлалын магистрийн зэрэгтэй.



**-Манай улсыг зорих жуулчдын тоо жилээс жилд буурсаар байна. Үүний шалтгааныг мэргэжлийн хүний хувьд хэрхэн тайлбарлах вэ?**

-Сүүлийн хэдэн жил дараалан аялал жуулчлалын салбарын гол үзүүлэлтүүд бууралттай байгаа. Үүний шалтгааныг аялал жуулчлалд Батлерын гэх зүй тогтлоор тайлбарладаг.

Аяллын зорих газрыг шинэ зүйлсийг эрэлхийлэгчид, адал явдал хайгч, үүргэвчтэй аялагчид нээж, зохион байгуулалттай аялагчид өсгөж, масс жуулчлал хөгжлийн боломжит цэгт нь хүргэж өгдөг.

Энэ үйл явц зарим газарт хэдэн жил, зарим газарт хэдэн арван жил ч үргэлжилж болно. Зөв бодлого, менежмент хэрэгжүүлсэн нь тогтвортой өсөж хөгжөөд явдаг. Гараа хүмшиад суусан нь жуулчидгүй хоцордог.

Хэдэн жилийн дараалсан бууралтын шалтгааныг хөндлөнгийн хүчин зүйлсээс хайх шаардлагагүй, Монгол "мода"-наас гарч байна л гэсэн үг. Зам тээвэр дэд бүтцийн хөгжил, нийгмийн үйлчилгээ, аюулгүй байдлын түвшин гэх мэт аялал жуулчлал өндөр хөгжсөн улс, хотуудын түвшинд хүргэх ёстой "харьцуулах давуу талууд" гэж бий. Нөгөө талаас жуулчдад санал болгох үзвэр, үйлчилгээ, нэгдсэн дүр төрх гэх мэт өрсөлдөгчдөөс ялгаруулах "өрсөлдөх давуу талууд" аль алинд нь бид анхаарал хандуулах ёстой.

**-Тэгвэл Нийслэлийн Аялал жуулчлалын газрынхан зүгээр суугаагүй байх гэж найдаж байна. Бууралтыг зогсоогоод бас дээр нь хотын жуулчдын тоог өсгөх боломжтой гэж үзсэн зах зээлээ тодорхойлсон үү?**

-Улаанбаатар хот "Найрсаг УБ" хөтөлбөр хэрэгжүүлэхдээ амжилтад хүрсэн улс, хотуудын жишгээр бууралтыг зогсоох хоёр үндсэн аргыг зэрэг хэрэглэж байна. Эхнийх нь уламжлалт зах зээл буюу Баруун Европ, Хойд Америк, Япон, Солонгосын зах зээлд шинэ дүр төрхтэйгөөр дахин гарч ирэх явдал. Одоогийн зах зээлийн дөрөвний нэг орчим хувийг эзэлж буй амралтын зорилгоор Монголыг зорих жуулчид хот суурин газрын соёл, амьдралын хэв маягийг сонирхох нь ховор.

Гагцхүү агаарын болон төмөр замын тээврийн зангилаа болж буй байдал нь Улаанбаатар хотод ирэх шалтгаан болж байгаа. Үүнийг өөрчлөх амаргүй ч амралтын зорилгоор ирдэг жуулчдын сэтгэлд

хүрсэн үзвэр, үйлчилгээ, эерэг хандлагыг бий болгох замаар аль болох олон хонуулах, нийслэл дэх мөнгөн зарцуулалтыг нь нэмэгдүүлэхэд анхаарч байна. Өмнө дурьдсан харьцуулах давуу талаа бэхжүүлэхэд ач холбогдол өгч байгаа.

Халаасны хулгай, муу үйлчилгээ, найрсаг бус байдал, үзэж харах зүйлсийн хомсдолоос шалтгаалаад тур операторууд жуулчдаа хотоос аль болох хурдан авч гарахын хүслэн болдог байлаа шүү дээ. Одоо бол Улаанбаатарыг "Найрсаг" гэсэн тодотголтой, жуулчдад ээлтэй хот болгох олон арван ажил хийгдэж байна. Үр дүнг нь удахгүй үзнэ гэж найдаж байгаа.

Дараагийн арга нь шинэ зах зээлд анхаарал хандуулж буй явдал. Хөрш орны "аяллын зорилгоор ирэгсэд"-ийн урсгалыг бий болгохоор зорьж байна. Тэд яалаа гэж манайд жуулчлах вэ гэж зарим нь бодож байж магад. Аялах эдийн засгийн боломж хэзээ бүрдэнэ тэр цагаас эхлэн хил залгаа эсвэл газар нутаг ойр дөт улсын, бага зардлаар хүрч болохуйц төв суурин газрууд руу хүмүүс зорчиж эхэлдэг. Үүнийг Бартоны дөрвөн үечлэл гэж нэрлэдэг.

Бид эхлээд Эрэн, Бээжин, тэгээд Хонконг, Сингапур хүрсэн шиг тэд Алтанбулаг, Замын-Үүдээр дамжаад Улаанбаатарт аялах болно. Энэ үйл явцдор хаяж 10 гаруй жил үргэлжилнэ. Хөрш орны жуулчид дотор хамгийн өндөр ач холбогдол өгөх сегмент нь Монгол туургатнууд байх юм.

Бусад орны жуулчидтай харьцуулахад нүүдлийн соёл ахуй, онгон байгаль тэдний хувьд төдийлөн сонирхол татах зүйл биш тул аялал жуулчлалын бусад бүсээс илүү Улаанбаатар хот хамгийн тохиромжтой аялах газар гэдэгтэй бүгд санал нийлэх байх. Жуулчдын тоо хэд ч хүрсэн 70-80 хувь нь хоёр хөршийн иргэд байдаг одоогийн бүтцээс их өөрчлөгдөхгүй.

Соёлын холбоо, хүлээн авагч илгээгч хоёр зах зээлийн зайн хамаарал гэсэн зүй тогтлууд энэ боломжийг олгодоггүй. Жишээ нь Англид аялдаг жуулчдын дийлэнхийг газар нутгийн хувьд ойролцоо улс орнууд, тэгээд Англитай соёл түүхээрээ холбогддог америк, канад, австрали, шинэ зеландууд эзэлдэг.

**-“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрт**

**нийслэлийн төсвийн таван хувийг зарцуулахаар Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан. Бас дээр нь 2020 онд хоёр сая жуулчин авах төлөвлөгөөтэй. Төсөв, төлөвлөгөө хоёр их өндөр сонсогдож байна.**

-Манай хөтөлбөрийг анхааралтай уншвал төсөв бүрдүүлэх эх үүсвэр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга замыг маш тодорхой заасан байгаа. Жишээ нь, аялал жуулчлалд зарцуулах хөрөнгийг олон улсын жишгийн дагуу жуулчны үйлчилгээний байгууллагуудын орлогоос бүрдүүлнэ гэж заасан. Нийслэл хотын албан татварын хуулиар жуулчны үйлчилгээнээс авах татвар батлагдлаа.

Иргэдийн бус, жуулчдын төлсөн татвараар дараагийн олон жуулчдыг татах ажлыг санхүүжүүлнэ гэсэн үг. Жуулчдын тооны хувьд улс орнууд хилээр нэвтэрсэн гадаад иргэдийн тоогоор, хотууд бол жуулчдын өнгөрүүлсэн хоногийн тоогоор тооцдог гэдгийг хэлэх хэрэгтэй.

Зочид буудлын ор хоногийн татвараар дамжуулж хотууд жуулчдынхаа тоог баттай гаргаж чаддаг.

"Найрсаг УБ"-ын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө, зарцуулах хөрөнгийг дийлэнх нь хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдсэн Нийслэлийн аялал жуулчлалын зөвлөлөөр хэлэлцдэг тогтолцоонд шилжсэн. Салбарын хэмжээнд хамгийн ач холбогдолтой гэсэн ажлууд хийгдэж, шийдэгдэж байгаа. Үр дүнд нь салбарын хэмжээнд тулгамдсан асуудлууд том, жижиг гэлтгүй шийдэгдэж байна. Жуулчин тээврийн хэрэгслүүдийн дугаарын хязгаарлалт, авто зогсоолууд, үйлчилгээний цагийн хуваарь, жуулчны мэдээллийн төвүүдийн сүлжээ, жуулчны цагдаагийн нэгж гэх мэт.

2015 онд хөтөлбөрийн хүрээнд 32 нийтийг хамарсан эвент, фестивалиуд, хэд хэдэн нийгмийн аян, гадаад сурталчилгааны ажлууд төсвөөс санхүүжүүлэн хийж байна.

Эдгээр ажлын үр нөлөөг бодитоор тооцохын тулд нийслэлийн эдийн засаг, нийгэм соёл, байгаль орчинд үзүүлэх аялал жуулчлалын салбарын шууд ба шууд бус нөлөөллийн судалгаа, жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа, гол зах зээлийн орнуудын болон жуулчдын зан төлвийн судалгаа гэх мэт 10 гаруй төрлийн судалгаа хийж байгаа. ■

## Улсын ирээдүй зөв МОНГОЛ ХҮҮХЭД

Ц.Сайхан

Хуучин цагт хүүхдийг хурдан тоо бодуулж, үсэг бичиг нүдлүүлэх гэж яардаг. Үе холбож сурахтай нь зэрэг олон олимпиад, шалгалтад оруулж шахамдуулдаг барил одоо хоцрогджээ. “Хүн бүр математикч болдоггүй” тул хүүхдийг зөв монгол хүн болгон төлөвшүүлэхийг юу, юуны өмнө тавьдаг болж. Өөрөөр хэлбэл, өв соёл, зан заншлаа мэддэг, дээдэлдэг, ёс журамтай, хүмүүжилтэй сурагчдыг бэлтгэх аж.

Тэгвэл зөв хүн, зөв монгол иргэнийг төлөвшүүлэхэд сурган хүмүүжүүлэгчдэд зөв арга барил хэрэгтэй. Арга барил гэдэг өнөөдөр орхиод маргааш өөрийг олж авдаг зүйл биш ажээ. Тиймээс багшийг сургах тал дээр Нийслэлийн Боловсролын газар их анхаарал хандуулж байгаа гэнэ. Өнөөгийн сургалтын онцлог нь хүүхэд бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшлах арга зүй. Хүүхэд бүрийн сурах арга барил ялгаатайг үл харгалздаг байсан нь хуучин системийн дутагдал байж. Харин бодлогод өөрчлөлт орсноор хүүхдийг бага ангид нь академик мэдлэг суулгах гэж хүчлэхгүй өөрийгөө нээж, сурах арга барилаа олж авахад нь туслах чиглэл баримтладаг болжээ. Арга зүйг багш нарт суулгахын тулд хүүхдийг хөгжүүлэх чиглэлээр олон жил ажилласан гадны улсаас туршлагыг судлах, багш нарыг сургалтад хамруулах ажлуудыг тогтмол зохион байгуулж бэлтгэх болжээ. Нийт давхардсан тоогоор 52 удаа зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн хэмээн тайландаа тусгасан байх юм. Багш нар ч өөрсдөө хүүхэд бүрийг хөгжүүлэхэд тулгамдаж байгаа асуудлуудаа чуулж, хэлэлцэж, шийдвэрлэх арга замыг тодорхойлохоор үргэлж оролддог болжээ.

Боловсролын салбарт хийсэн өөрчлөлт удаан хугацааны дараа үр дүнгээ өгдөг гэж судлаачид үздэг. Гэсэн ч үүнийг үгүйсгэсэн амжилт гарч байгаа. “Хамгийн гол нь багш нар маань ажилдаа сэтгэлтэй, дуртай болж байна. Хүүхэд нь хөгжиж, ахиж байгааг хараад эцэг, эхчүүд ч баяртай байна” хэмээн Нийслэлийн боловсролын газрын дарга Ц.Отгонбагана хэлсэн юм. Хүүхэд рүүгээ хандсан хөтөлбөр нь “Зөв монгол хүүхэд”. Хөтөлбөрийн хүрээнд “Авьяс”, “Ном” дэд хөтөлбөрийг нийслэлд хэрэгжүүлж зөвхөн “Авьяс” хөтөлбөрийн хүрээнд 13825 төрлийн ажил зохион байгуулж 691442 сурагч, 424773 эцэг эх, 93191 багш хамрагдсан байна. “Ном” хөтөлбөрийн хүрээнд 153252 хүүхэд ном уншиж тэмдэглэл хөтлөх үр чадварт суралцжээ.

Ирээдүйн чадварлаг боловсон хүчин бэлтгэн гаргахын тулд өнөөдөр чадвартай багш хэрэгтэй. Тийм багш нарыг төрөн гаргах боловсон хүчний бодлого чухал. Ялангуяа зөв



монгол хүүхдийг сургах, хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн багш нарт өөр шаардлага тавигдах болжээ. Энэ үүднээс “Боловсролын их сургууль”-д элсэн суралцах босгыг өндөрсгөсөн байна. Түүнчлэн хоёр жилийн өмнөөс элсэлтийн ерөнхий шалгалтанд өндөр оноо авч багшийн мэргэжлийг сонгосон оюутнуудын сургалтын төлбөрийг 100 хувь хүртэл чөлөөлж байгаа аж. Өнөөдрийн байдлаар багш бэлтгэдэг их дээд сургуулиудад 2000 орчим оюутан энэ хөнгөлөлтийг эдэлж байгаа гэнэ. Тэднийг ажлын байранд гарах үеээс боловсролын салбарт томоохон дэвшил гарна гэж хүлээж буй. Гэхдээ энэ нь өнөөдөрт боловсролын салбарын боловсон хүчний чадвар муу гэсэн үг биш. Бодлогын шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй нэг ажил юм. Одоогийн байдлаар нийслэлд мэргэжилтэй багшийн хангалт 99.7 хувьтай байгаа аж. Харин бодлогын шинэчлэл хийгдэж буй учир хүүхэд бүрийг хөгжүүлэхийн зэрэгцээ багш бүрийг чадавхжуулах бодлого хэрэгжүүлж байгаа гэлээ.

Эцэст нь энэ бүх ажлыг бараг мөнгөгүй шахам хийж байгаа нь гайхам. Боловсролд төсөвлөсөн хөрөнгийн 90 гаруй хувь нь байр сууцны засвар, дулааны, цахилгааны мөнгө, цалин, нийгмийн даатгал гэх зэрэг үндсэн зардал эзэлж, сургалт судалгаанд чиглэсэн зардал 10 хүрэхгүй хувийг бүрдүүлдэг байна. Нийслэлийн Боловсролын газрын төсөвт төлөвлөсөн арга хэмжээний зардалд ойролцоогоор 50 сая орчим төгрөг хуваарилдаг нь жилдээ хүрэлцээ муу. Харин дээр дурьдсан арга хэмжээ, үйл ажиллагааг үндсэндээ сургуулиуд өөрсдөө идэвх, санаачлагатай ажиллаж гадна дотнын байгууллагуудын хандив тусламж, хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж байгаа аж. Тухайлбал “Авьяс” хөтөлбөрийг л гэхэд НҮБ-ын Хүүхдийг ивээх сан, Дэлхийн зөн, Лувсанвандан сан, эцэг эхийн дэмжлэг, сургуулийн төсөв нийлсэн 284,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Нийслэлд өнөөдөр “Монгол бичгийн”, “Англи хэлний”, “Боловсрол”, “Багшийн хөгжил”, “Зөв Монгол хүүхэд” гэсэн үндэсний хөтөлбөр, “Авьяс”, “Ном” дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа. Мөн энэ жил хийж гүйцэтгэсэн гол ажил нь хөтөлбөрүүдийг нэгтгэсэн “Бага боловсролын цөм хөтөлбөр”-ийн хэрэгжилт. Хөтөлбөрийн хэрэгжилт улс даяар сайн дүн авсан гэнэ. Харин ирэх хичээлийн жилд “Суурь боловсролын цөм хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх бөгөөд дараа жил нь ахлах боловсролыг хамарснаар энэ ажил дуусгавар болж дараагийн үе эхлэх юм байна. ■

# Ц.Отгонбагана: Монгол Улсын ирээдүйг боловсролтой хүн авч явна

Ц.Элбэгсайхан

*Нийслэлийн Боловсролын газрын дарга Ц.Отгонбаганыг гурван асуулт буландаа уриллаа*

**-Нийслэлийн боловсролын салбарт ямар өөрчлөлт шинэчлэл хийгдэж байна. Боловсролын бодлогыг хэрэгжүүлэхэд бэрхшээл, шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудал юу байна вэ?**

-Боловсролын газрын “Зөв монгол хүүхэд”, “Хүүхэд бүрийг хөгжүүлэх” бодлогыг хэрэгжүүлж байна. Өнгөрсөн хичээлийн жилд бага боловсролын цөм хөтөлбөрийг сургуулиудад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. Хичээлийн жилийн төгсгөлд бүс, дүүрэг, нийслэл, эцэст нь улсын хэмжээнд зөвлөгөөн зохион байгуулж боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэсэн. Хөтөлбөр амжилттай сайн хэрэгжиж байна гэсэн дүгнэлтэд хүрч байна. Ирэх хичээлийн жилээс суурь боловсролын буюу 6-9 дүгээр ангийн боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, нэг талаас сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэх үе шаттай ажил хийж байна


Хүндрэл гэвэл цөм хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр сургалтын хэрэглэгдэхүүн ашиглах шаардлага маш их болж байна. Өнөөдөр сургуулийн төсөвт хичээл, практикийн зардлаар тусгаж буй мөнгө нь маш бага. Улсын төсвөөс боловсролын салбарт зарцуулж буй мөнгөн дүнгийн 90-95 хувийг зөвхөн тогтмол зардал, багш ажилчдын цалин, нийгмийн даатгал, бусад шимтгэл эзэлдэг. Үлдэж буй багахан хувийг сургалтын үйл ажиллагаанд зориулж байна. Үүнээс гадна нийслэлд тулгамддаг чухал асуудал нь сургууль, цэцэрлэгийн хүртээмж. Сүүлийн гурван жилд харьцангуй их хөрөнгө оруулалт хийгдэж зөвхөн энэ жил гэхэд 170 гаруй

барилгын гүйцэтгэл хийгдэж буй ч хүн амын өсөлт хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд буурахгүй байгаагаас ачааллаа гүйцэхгүй байгаа юм.

**-Цэцэрлэгийн хүртээмж нийслэлд хурцаар тавигддаг асуудал. Таны бодлоор үүнийг шийдэх ямар боломж байна вэ?**

-Хувь хүнийхээ зүгээс цэцэрлэгийн асуудлыг төвлөрсөн байдлаар шийдэх боломжгүй гэж хардаг. Асуудлыг шийдвэрлэхэд аж ахуйн нэгж байгууллагын дэргэд хүүхдийн цэцэрлэг байгуулах хэрэгтэй. Сүүлийн хоёр жилд томоохон аж ахуйн нэгжүүд дэргэдээ цэцэрлэг байгуулах нь идэвхжиж байгаа. Үр дүнд нь ажилчдынхаа нийгмийн асуудлыг тодорхой түвшинд шийдэж чадаж байна. Нийслэлд дөрвөн хүүхэд тутмын нэг нь цэцэрлэгт хамрагдаж чаддаггүй. Гэтэл хамрагдсан хэсэгт бас асуудал тулгардаг. Өглөө хүүхдээ цэцэрлэгт хүргэж өгөх, орой очиж авах нь ямар хүндрэлтэйг хүн бүхэн мэднэ. Энэ нь эргээд байгууллагуудад ажилчин нь ажлын цагаа үр дүнтэй ашиглаж, бүтээмж нэмэгдэх байдлаар өгөөжөө өгнө.

Хувийн хэвшилд сүүлийн хоёр жилд өмнөх 7-8 жилд байгуулснаас хоёр дахин их цэцэрлэг байгуулжээ. Энэ нь цэцэрлэгийн тусгай зөвшөөрлийг жилд нэг удаа олгодог байсныг гурав болгож нэмсэнтэй холбоотой. Энэ хэрээр төрийн ачаанаас хөнгөвчилж байгаа. Өнөөдөр 100 ортой цэцэрлэг байгуулах зардал нэг тэрбум төгрөг. Хувийн хэвшил цэцэрлэг байгуулснаар улсын төсвөөс энэ хэмжээний ачаа хөнгөлж байгаа юм. Хувийн хэвшил, төр ачаагаа хамт үүрэлцэх нь илүү үр ашигтай. Төрөөс хувийн цэцэрлэгүүдэд хувьсах зардал гэж олгодог. Магадгүй энэ зардлын хэмжээ болон хүүхдийн хоолны мөнгийг хөшүүрэг болгож шийдвэрлэх нь 100



ортой нэг цэцэрлэг барихаас илүү үр дүнтэй, ач холбогдолтой байх болов уу.

**-Боловсролын салбарт маш их өөрчлөлт хийж байна. Кембрижийн системийг нэвтрүүлэхээр зарим сургууль дээр туршиж байна. Гэтэл нэг хэсэг нь үндэсний боловсролын систем бий болгох хэрэгтэй гэж байхад зарим огт өөр жишиг нэвтрүүлэх тухай ярих юм. Төрийн бодлого яг хаашаа чиглэж байна вэ?**

-Нэг буруу ойлголт байгаа юм. Боловсролын салбарт Кембрижийн зөвлөх үйлчилгээг л авч ажиллаж байгаа. Хөтөлбөр төлөвлөгөө нь мэдээж үндэсний хөтөлбөрөө баримталж байна. Олон улсын лаборатори гурван сургуулийн хувьд үндэсний хөтөлбөрийн зэрэгцээ олон улсын хөтөлбөрийг хамт судалж яваа. Түүнээс Кембрижийн хөтөлбөрөөр монгол хүүхдүүдээ сургаж байгаа юм биш. Анхнаасаа буруу нэр томъёо ашигласнаас болоод ойлголтын зөрүү үүсчихээд байгаа юм. Миний хувьд Монголын ирээдүйг уул уурхай биш оюунлаг, боловсролтой монгол хүн гэж хардаг. Өнөөдөр боловсролын салбарын бодлого ч үүнд чиглэсэн. Өмнө нь бид бага ангийн боловсролыг л гэхэд хэн хурдан үсгээ цээжилж, уншиж сурснаар нь үнэлж, хооронд нь уралдуулдаг байсан бол өнөөдөр эхлээд монгол хүн болж төлөвших, зан заншилд суралцах, сурах арга барилаа олж авахад нь чиглүүлж байна. Тэгвэл суурь боловсролоор илүүтэй академик мэдлэг олж, ахлах ангидаа өөрийн дуртай, сонирхдог мэргэжлийн чиглэлийн хичээлүүдээ түлхүү судлах бодлогын шинэчлэл хийж байна. Цаашдаа ахлах сургууль, их сургуулийн хооронд залгамж холбоо бий болгох бодлого барьж байгаа. Тиймээс ойрын ирээдүйг мэдлэг, боловсролтой боловсон хүчин авч явна гэдэгт итгэлтэй байна. ■